ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2016 ОНЫ АРАВДУГААР САР

Лиахона

Суралцахуйн баяр баясгаланг мэдрэх дөрвөн арга зам, х.10

Амиа хорлох явдал: Цөхөрсөн, тусламж эрсэн чимээгүй гуйлт, х.18

Гэр бүлийн түүхийн талаар Лихайгаас авах сургамж, х.26

Шунал тачаалын ерөндөг, х.30

"Чи Бурханд найдлага тавихын хэрээр өөрийн бэрхшээл, мөн зүдгүүр, мөн зовлонгуудаасаа ангижруулагдаж мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг чамайг санаасай хэмээнэ би."

Алма 38:5

Лиахона, 2016 оны аравдугаар сар

ЗАХИАСУУД

4 **Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Дуулгавартай байхад ирдэг адислал**
Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 **Айлчлагч багшийн захиас бичиг: Гэр бүл Бурханаас заяагддаг**

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

16 **Бага насны хүүхдүүд ба ариун ёслол**
Аарон Л.Вэст
Ариун ёслолоос хүртэхдээ бяцхан хүүхдүүд гэрээ хийхэд өөрсдийгөө бэлтгэх боломжтой.

18 **Амиа хорлох явдлыг ойлгох нь: Сэрэмжлүүлэх шинж тэмдгүүд ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ**
Кэничи Шимокава

24 **Бошиглолын суу билэгт үгсийг санаанд оромгүй газраас олсон нь**
Колэтт Линдал
Байранд орхисон хэдэн Лиахона сэтгүүл нэгэн эрэгтэйг сайн мэдээ рүү хөтлөн, амьдралыг нь өөрчилжээ.

26 **Гэр бүлийн түүх: Амар амгалан, хамгаалалт ба амлалтууд**
Ахлагч Брадли Д.Фостэр

30 **Хайр ба шунал тачаал**
Жошуа Ж.Пөрки
Бурханы хүслийн эсрэг ямар нэг зүйлийг эзэмдэхийг эрэлхийлэхэд хүргэдэг шунал тачаалын ерөндөг юу вэ?

36 **Алс тэртээх Иорданд үйлчилсэн нь**
Р.Вал Жонсон, Рэчэл Колман
Хүмүүнлэгийн ахмад хос номлогч Их Эзэний хүссэн газарт үйлчилснээрээ мянга мянган хүний амьдралд нөлөөлжээ.

ӨГҮҮЛЛҮҮД

8 **Сүмд үйлчлэх нь: Үйлчлэлээр дүүрэн ням гаргууд минь**
Жэффри А.Хогг

9 **Эргэн дурсахуй: Мэлвагийн сүүлчийн зоог**
Шэрил Харвард Уилкокс

10 **Аврагчийн арга барилаар заах нь: Суралцахуйн баяр баясгалан**
Тэд Р.Каллистэр

40 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**

44 **Бидний гэр орон, гэр бүл: Эммагийн төлөө мацаг барьж, залбирсан нь**
Сэсил Норрунг

80 **Биднийг дахин уулзах хүртэл: Их Эзэний Сүмийн тэнгэрлэг суу билэг**
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли

4

ХАВТСАН ДЭЭР
Нүүрэн талд: Лэсли Нилсоний авсан гэрэл зураг. Дотор талын хавтсанд: Гэрэл зургийг jamievanbuskirk/GettyImages. Дотор талын хавтсанд: Райн Маквэй болон Кристофэр Элвэлл/Thinkstock-ын авсан гэрэл зургуудын эвлүүлэг.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



46 **Жинхэнэ мянган жилийнхэн мэт зогс**
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон
Жинхэнэ мянган жилийнхэн мэт зогсож болоход туслах дөрвөн зөвлөмж

Энэ дугаарт нуусан Лиахонаг олж чадах эсэхээ хараарай. Сэжүүр: Хөршүүдэд тань жимсний мод байдаг уу?

ӨСВӨР ҮЕЙЙНХЭНД ЗОРИУЛАВ

54 **Зөөлөн гал дээр болгохын гайхамшиг**
Дэвид А.Эдвардс
Тэсвэр тэвчээртэй байх нь хэрхэн хамгийн сайхан шарсан талхтай бяслагтай сэндвич хийж, Есүс Христтэй илүү адил болоход тань тусалж чадах вэ?

57 **Зурагт хуудас: Өөрсдийгөө сэргээн босгогдож байгаагаар төсөөл**

58 **Цөхрөлтгүй зүтгэх хүч чадал**
Жэссика Төрнэрийн түүхийг Лин Крандаллд ярьснаар
Итгэлийг минь хүчирхэгжүүлсэн энгийн зүйлийг хийсэн нь автомашины ослын дараа эдгэрч, үргэлжлүүлэн амьдрахад надад тусалсан.

61 **Сүмийн удирдагчдын хариулт: Хэрхэн Аврагчийг амьдралынхаа төв болгох вэ?**
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

62 **Суралцах жор**
Рөүзмэри Такэрэй
Бурханы үгийг бодгальд тань илүү амттай болгохын тулд энэ дөрвөн арга замыг туршиж үз.

64 **Асуулт, хариулт**
Өөрийнхөө жишгийг хүчирхэгжүүлэхийн тулд өөр жишгийг дагадаг найзуудтай байх хэрэгтэй гэж зарим хүн хэлдэг. Энэ үнэн үү?



ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

66 **Загасчлахаар явсан нь**
Жюлия Вэнтура
Хэйдэн бяцхан дүү нь хамаг загасыг айлгаад үргээчихнэ гэж санаа зовж байв. Гэвч бяцхан дүү нь алга болоход түүний санаа бүр их зовжээ.

68 **Төлөөлөгчдийн хариулт: Би гэр орноо амар тайван газар болгоход хэрхэн тусалж болох вэ?**
Ахлагч Гари И.Стивэнсон

69 **Бидний хуудас**

70 **Нэр төрөө өндөрт өргөн авч яваа хүүхдүүд: Сторигийн тухай түүх**
Жилл Хакинг
Стори болон түүний гэр бүл амьдарч байгаа улсдаа цорын ганц Сүмийн гишүүд байв. Түүний нэр төрөө хэрхэн өндөрт өргөж яваг хар.

72 **Ээжийн өгсөн сургамж**
Ахлагч Жайро Маззагарди
Ахлагч Маззагарди ээжийнхээ үнэнч шударга зангаас суралцжээ. Та нар эцэг эхээсээ ямар зарчим сурсан бэ?

74 **Мормоны Номын баатрууд: Мормоны Номон дахь эмэгтэй баатрууд**

76 **Мормоны Номын түүхүүд: Амлагдсан нутаг руу аялсан нь**

79 **Будах хуудас: Хөгжим намайг аз жаргалтай болгодог**

2016 ОНЫ АРАВДУГААР САР, 17, №5
ЛИАХОНА 13290 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг, Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Робэрт Д.Хэйлс, Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Иосеф В.Ситати
Туслах редакторууд: Жэймс Б.Мартино, Кэрол Ф.Макконки
Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Крэг А.Кардон, Шэрил А.Эсплин, Кристоффэл Голдэн, Даглас Д.Холмэс, Ларри Р.Лорэнс, Кэрол М.Стэфэнс

Удирдах захирал: Питэр Ф.Эванс
Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал: Винсэнт А.Ваун
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Хэвлэлийн туслах: Мэган Вэрхеф
Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фуллэр, Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жилл Хакин, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Аннэ Сэлу, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Рачэл Смит, Брэд Тиэри, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Глэн Адэйр, Конни Вауторп Бриж, Жюли Бардэтт, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэйт Раффэрти, Derek Richardson
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жэфф Л.Мартин
Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн. Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2016 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувилан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: October 2016 Vol. 17 No. 5. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаа

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох олон өгүүлэл, үйл ажиллагааг оруулав. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.

"Бяцхан хүүхдүүд ба ариун ёслол," 16-р хуудас: Эцэг эхийн хувьд та уг өгүүллийг уншсаныхаа дараа бага насны хүүхдүүддээ ариун ёслолоос хүртэхдээ болон нэгэн өдөр баптисм хүртэхдээ хийх гэрээний ач холбогдлыг заах арга замын талаар ярилцаж болно. Та ариун ёслолын залбирлыг (Сургаал ба Гэрээ 20:77, 79-д гардаг) баптисм хүртэхдээ өгдөг амлалт болон ням гараг бүр ариун ёслолоос хүртэх нь хэрхэн бидэнд тэдгээр амлалтаа шинэчлэх боломжийг олгодог тухай заахын тулд ашиглаж болно. Түүнээс гадна ариун ёслолын үеэр бага насны хүүхдүүддээ Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлэхэд нь туслахын тулд Аврагчийн зургуудтай энгийн зурагт ном хийх гэх мэт санааг гаргаж болно.

"Суралцах жор," 62-р хуудас: Хэрэв танд судраас бие дааж суралцдаг том хүүхэд байдаг бол тэдэнтэй хамт энэ өгүүллийг уншаад, өгүүлэл дээрх санааг хэрэгжүүлэхэд урих талаар бодож үз. Гэр бүлийн гишүүн бүр хувийн судлах тэмдэглэлтэй болоод, түүн дээрээ тогтмол бичих зорилго тавьж болно. Гэр бүлийн гишүүд дараа дараагийн гэр бүлийн үдшээр судлах тэмдэглэл дээрх бодол, сэтгэгдлээ сайн дурааараа хуваалцаж болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр **languages.lds.org** хаягаар орж үзэж болно. Сүнслэг захиас, гэр бүлийн үдшийн санаа, найзуудтайгаа болон гэр бүлтэйгээ хуваалцаж болох зүйлүүд зэргийг олж мэдэхийг хүсвэл **facebook.com/liahona.magazine** (англи, португаль, испани хэл дээр байгаа) хуудас руу орно уу.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заажж байгаа болно.

Амар амгалан, *58, 68*
Амиа хорлох тухайд, *18*
Аравны нэг, *72*
Ариун Сүнс, *70*
Ариун сүм, *55*
Ариун ёслол, *9, 16*
Бошиглогчид, *46, 80*
Бошиглогчийг дагах, *46*
Бурханлаг шинж чанар, *46*
Гайхамшгууд, *44*
Гэр бүл, *7, 26, 44, 66, 68, 70*
Гэр бүлийн түүх, *26, 42*
Гэрчлэл, *74*
Дуудлагууд, *8*
Дуулгавартай байдал, *4, 30, 46*
Дуу хөгжим, *79*
Есүс Христ, *4, 61, 76*
Жишгүүд, *64*
Заах, *16, 72*
Залбирал, *44, 66*
Зарлигууд, *4*
Зориг, *74*
Итгэл, *46, 58, 74, 76*
Мацаг барих, *44*
Мормоны Ном, *26, 43, 74, 76*
Найдвар, *58*
Найз нөхөд, *64*
Нигүүлсэл, *40*
Номлогчийн ажил, *24, 36*
Сорилтууд, *18, 44, 58*
Судраас судлах, *43, 62*
Тэвчээр, *54*
Үйлчлэл, *41, 58*
Үнэнч шударга байдал, *72*
Хайр, *30, 41*
Хувийн илчлэлт, *46*
Хүмүүнлэгийн үйлчлэл, *36*
Хүндэтгэлийн өдөр, *8, 42*
Хүүхдүүдэд, *16, 42*
Шунал тачаал, *30*

Ерөнхийлөгч Томас С.Монсон

ДУУЛГАВАРТАЙ БАЙХАД ИРДЭГ АДИСЛАЛ

Ерөнхийлөгч Монсон "Бурханыг ярих тэр үед бид дуулгавартай байж чадвал үргэлж зөв байх болно хэмээх үнэн нь мөнх бус байдалд бидний мэдэж авч болох хамгийн агуу зарчим юм"[1] гэж заасан.

Бид мөн адислагдах болно. Саяхан болсон Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Монсоны хэлсэнчлэн: "Бид зарлигуудыг сахивал амьдрал маань илүү аз жаргалтай, утга учиртай, ээдрээ багатай болно. Бид бэрхшээл, асуудлуудаа давж гарахад илүү амар болж, Түүний амласан адислалыг хүлээн авах болно."[2]

Сүмийн ерөнхийлөгчийн хувиар заасан сургаалын түүвэрт ерөнхийлөгч Монсон зарлигууд бол аз жаргал, амар амгаланд хүрэх хамгийн баттай хөтөч гэдгийг бидэнд сануулдаг.

Аялалд зориулсан заавар

"Бурханы зарлигууд нь биднийг хааж боох эсвэл бидний аз жаргалд саад болохын тулд өгөгдөөгүй. Харин ч үүний эсрэг зорилгоор өгөгдсөн. Биднийг бүтээж, төгс хайрладаг Бурхан бидний хамгийн эрхэм аз жаргалыг олж авахын тулд хэрхэн амьдрах хэрэгтэйг сайн мэднэ. Тэр бидэнд заавар өгсөн бөгөөд хэрэв бид түүнийг дагаж чадвал ихэнхдээ аюултай байдаг энэхүү мөнх бус аяллын турш хамгаалагдах болно. Бид нэгэн танил дууллын "Зарлигуудыг дагацгаая! Ийн аюулгүй, ийн амар амгалан байна" хэмээх үгсийг санаж байгаа ["Keep the Commandments," *Hymns,* 303-р хуудсыг үзнэ үү]."[3]

Хүч чадал ба мэдлэг

"Дуулгавартай байдал нь бошиглогчдын онцлог шинж чанар юм; олон зууны турш энэ нь тэдэнд хүч чадал, мэдлэгийг олоход тусалсаар ирсэн. Бид ч мөн адил энэхүү хүч чадал, мэдлэгийн эх сурвалжийг авах эрхтэй гэдгээ ухаарах нь маш чухал. Бурханы тушаалуудыг дуулгавартай дагавал бид үүнийг одоо ч гэсэн авч болно. . . .

Хайж буй мэдлэг, хүлээж буй хариултуудаа болон энэхүү түвэгтэй, хувирамтгай дэлхийн бэрхшээлүүдийг даван туулахад туслах хүч чадлыг бид Их Эзэний тушаалуудыг дуулгавартай дагаснаар л олж авч чадна."[4]

Дуулгавартай байхыг сонго

"Бидний амьдарч буй цаг үе ёс суртахуунгүй байдалд хүлцэнгүй хандаж байна. Сонин сэтгүүл, телевизийн нэвтрүүлгүүд залуусын үлгэр дуурайл болсон кино дэлгэцийн одод, спортын талбар дахь баатруудыг Бурханы хуулиудыг зөрчин, олны өмнө нүгэлт үйлдэл хийх нь буруу биш мэтээр харуулж байна. Үүнд бүү итгэ! Бидний амьдралыг дэнслэх өдөр ирнэ. Бид бүгд энэ амьдралд эсвэл ирэх амьдралд хийсэн үйлдлийнхээ үр дагаврыг амсана. Шүүлтийн өдөр ирнэ. . . .Би та нараас дуулгавартай байхыг сонгохыг гуйж байна."[5]

Баяр баясгалан ба амар амгалан

"Заримдаа Сүмээс гаднах дэлхийн амьдралд байгаа хүмүүс та нараас ч илүү аз жаргалтай, баяр хөөртэй байгаа мэт санагдаж магадгүй. Заримдаа Сүмд дагаж, мөрддөг зүйл та нарын эрх чөлөөг хязгаарлаж байгаа юм шиг санагдаж болно. Ах эгч нар аа, гэсэн хэдий ч Аврагчийг дагаж, зарлигуудыг сахиснаар ирэх Сүнснээс өөр *юу ч* жинхэнэ баяр баясгалан, амар амгаланг авчирч чадахгүй гэдгийг би тунхаглаж байна."[6]

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖИМ МАДСЭН

Цэх шулуун алх

“Бидэнд амлагдсан адислал хязгааргүйг би та нарт гэрчилж байна. Аянгын бараан үүлс хуралдаж, аадар бороо бидэн дээр цутгаж мэдэх ч, хэрэв бид цэх шулуун алхаж, зарлигуудыг сахивал сайн мэдээний тухай мэдлэг, Тэнгэрлэг Эцэгээ болон Аврагчийг хайрлах хайр биднийг тайтгаруулж, дэмжих болно. Энэ дэлхийд биднийг юу ч ялж чадахгүй.”[7]

Аврагчийг дага

“Уй гашуу, гай зовлонг амссан тэр Хүн хэн байв? Алдар суугийн Хаан, олон түмний тэрхүү Их Эзэн хэн бэ? Тэр бол бидний Эзэн. Тэр бол бидний Аврагч. Тэр бол Бурханы Хүү. Тэр бол бидний авралын зохиогч. ‘Намайг дагагтун’ гэж Тэрээр уриалан дууддаг. ‘Явж, үүний адил үйлдэгтүн’ хэмээн зааварлаж, ‘Миний зарлигуудыг сахь’ хэмээн Тэрээр хүсдэг.

Түүнийг дагацгаая. Түүний үлгэр жишээнээс суралцацгаая. Түүний үгийг дуулгавартай дагацгаая. Ингэснээр бид Түүнд тэнгэрлэг талархлын бэлгийг өгч чадна.”[8] ■

ЭШЛЭЛҮҮД

1. “They Marked the Path to Follow,” *Лиахона,* 2007 оны 10-р сар, 5.
2. “Зарлигуудыг сахь,” *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 69.
3. “Зарлигуудыг сахь,” 69.
4. “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 103, 105.
5. “Иттэ, дуулгавартай бай, тэвч,” *2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 129.
6. “Ариун газруудад зогсогтун,” *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган.*
7. “Зоригтой бай,” *2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган.*
8. “Аялалдаа баяр баяслыг олох нь,” *2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 97.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Монсон бидэнд дуулгавартай байснаар хүлээж авч болох хүч чадал, мэдлэг, баяр баясал, амар амгалан гэх мэт олон адислалын талаар заасан. Дуулгавартай байснаар хэрхэн адислагдсан тухай заадаг хүмүүсээсээ асуух талаар бодож үз. Та тэднийг адислалынхаа талаар үргэлжлүүлэн тунгаан бодож, санаж явдаг зүйл болон туршлагуудаа тэмдэглэл дээрээ бичихэд урамшуулж болно. Бас тэднийг цаашид дуулгавартай байснаар адислалынхаа төлөө Бурханд талархаж байгаагаа харуулахад урамшуулан дэмжиж болно.

Түймэр ба дуулгавартай байх талаар олж авсан сургамж

Ерөнхийлөгч Томас С.Монсон нэгэн удаа дуулгавартай байдал чухал гэдгийг хэрхэн ойлгож авсан тухайгаа ярьсан юм. Түүнийг найман настай байхад гэр бүл нь уулан дээрх зуслангийн байшиндаа очжээ. Тэрээр найзуудтайгаа түүдэг гал асаахын тулд хэсэг өвсөрхөг газрыг цэвэрлэх гэж оролдсон байна. Тэд өвсийг цэвэрлэхийн тулд гараараа зулгаан, хамаг чадлаараа угзарч, татсан ч хэдхэн атга зэрлэг ургамлаас өөр юу ч зулгааж чадсангүй. Ерөнхийлөгч Монсон "Гэтэл 8 настай миний ухаанд нэгэн сайхан санаа гэнэт орж ирэв. Би Даннид хандан: 'Энэ зэрлэг ургамлыг ерөөсөө шатаачихъя. Яг тэр тойрог доторх газрын өвсийг л *шатаачихъя!'* гэж хэлж билээ" гэв.

Хэдийгээр шүдэнз ашиглахыг хориглосон гэдгийг мэдэж байсан ч тэр байшин руугаа гүйн орж, шүдэнз авчирч, Данни тэр хоёр өвстэй газар жижиг түүдэг асаасан байна. Тэд гал өөрөө унтарчих байх гэж бодсон боловч улам дүрэлзэн ассаар, аюултай түймэр болон хувирав. Данни тэр хоёр тусламж гуйхаар гүйлдэж, удалгүй томчууд түймрийг мод руу орохоос нь өмнө унтраахаар яаран гарч ирцгээжээ.

Ерөнхийлөгч Монсон цааш нь ярихдаа "Тэр өдөр Данни бид хоёр хэцүүхэн боловч чухал хэд хэдэн зүйлийг сурсны нэг нь дуулгавартай байхын ач холбогдол байсан юм" хэмээн хэлэв. ("Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг," *2013 оны Ерөнхий чуулган,* 103-107-г үзнэ үү.)

Та нар ерөнхийлөгч Монсонтой адил дуулгавартай байх тухай сургамжийг хэцүү байдалд орсноор авч байсан уу? Та ирээдүйд дуулгавартай байхаар дамжуулан өөрийгөө аюулаас хол байлгахын тулд ямар ямар зорилго тавьж болох вэ?

Зөвийг сонго

Зөвийг сонгох нь бидэнд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд илүү ойртоход тусалдаг. Энэ нь мөн бидэнд аз жаргалтай, аюулаас хол байхад тусалдаг. Зөвийг сонгох арга замуудыг дугуйл.

Сүмд явах

Хичээл дээрээ бусдаас хуулах

Судруудыг унших

Бусдад үйлчлэх

Зөв тоглоом тоглох

Ах, эгч, дүү нартайгаа хэрэлдэж, зодолдох

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭТИ МАКДИЙ

Энэ материалыг залбирч судлаад, юуг хуваалцахаа мэдэхийн тулд сүнслэг өдөөлтийг эрэлхийл. "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"-ийг ойлгох нь таны Бурханд итгэх итгэлийг нэмэгдүүлэн, айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийг тань хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол ***reliefsociety.lds.org*** *хаягаар орж үзнэ үү.*

Гэр бүл Бурханаас заяагддаг

"'Гэр бүл Бурханаас заяагддаг' дууны үг [Хүүхдийн хэсгийн дуу] . . . бидэнд цэвэр сургаалыг сануулдаг" хэмээн Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стэфэнс хэлжээ. Бид гэр бүл Бурханаас заяагддаг гэдгийг мэдэхийн зэрэгцээ бүгд Бурханы гэр бүлийн нэг хэсэг гэдгээ ойлгож авдаг. . . .

. . . Эцэгийн хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөө нь хайрын төлөвлөгөө юм. Энэ нь Бурханы хүүхдүүдийг буюу Бурханы гэр бүлийг Өөртэй нь нэгтгэх төлөвлөгөө юм."[1]

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Л.Том Пэрри (1922–2015): "Бид уламжлалт гэр бүл бол тогтвортой нийгэм, эдийн засаг, ёс суртахууны зарчим бүхий соёлын үндсэн нэгж төдийгүй засгийн газрын болон Бурханы хаант улсын мөн мөнх амьдралын үндсэн нэгж гэдэгт итгэдэг.

Тэнгэрийн зохион байгуулалт болон засгийн газар нь гэр бүлүүдэд түшиглэн байгуулагдана гэдэгт бид итгэдэг"[2] хэмээн хэлжээ.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон "Гэр бүлийн нөхцөл байдал ямар болох мөн хэдэн хүүхэдтэй гэдгээсээ үл хамааралгүй хүн бүр гэр бүлийн тунхагт тайлбарласан Их Эзэний төлөвлөгөөний хамгаалагч нь байж чадна. Хэрэв энэ нь Их Эзэний төлөвлөгөө юм бол мөн бидний ч төлөвлөгөө байх ёстой!"[3] гэжээ.

Нэмэлт судрууд

Сургаал ба Гэрээ 2:1–3; 132:19

Үүнийг эргэцүүлэн бод

Яагаад гэр бүл нь энэ амьдралын болон мөнх амьдралын хамгийн чухал нэгж вэ?

ЭШЛЭЛҮҮД

1. Кэрол М.Стэфэнс, "Бурханы гэр бүл," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 129.
2. Л.Том Пэрри, "Яагаад гэрлэлт ба гэр бүл дэлхийн хаана ч чухал байдаг вэ," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 23–26.
3. Бонни Л.Оскарсон, "Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 132.
4. Жюли Б.Бэк, "Гэр бүлийн талаарх сургаал заах нь," *Лиахона,* 2011 оны 3-р сар, 12-17.

Итгэл, гэр бүл, халамж

Гэр бүлийн сургаал

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч асан Жюли Б.Бэк эгч гэр бүлийн сургаал нь Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал дээр үндэслэгдсэн хэмээн хэлээд,

"Дэлхийг бүтээснээр гэр бүлүүдэд амьдрах газрыг өгсөн. Мөн гэр бүлийн чухал хоёр хэсэг болох эрэгтэй, эмэгтэй хүнийг Бурхан бүтээсэн. Адам, Ева хоёр лацдан холбогдож, мөнхийн гэр бүлийг үүсгэх нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг байв.

. . . Уналт нь тэдэнд охид, хөвгүүдтэй болох боломж олгосон.

[Христийн] Цагаатгал гэр бүлд мөнхөд лацдан холбогдох мөн мөнхөд өсөж хөгжин, төгс төгөлдөр болох боломж өгдөг. Авралын төлөвлөгөө гэж нэрлэгддэг аз жаргалын төлөвлөгөө нь гэр бүлүүдэд зориулагдсан төлөвлөгөө байсан. . . .

. . . Энэ бол Христийн сургаал байсан. . . . Гэр бүл үгүй бол төлөвлөгөө гэж үгүй бөгөөд мөнх бус амьдралд зорилгогүй байх болно" гэж заажээ.[4]

АРГЕНТИН ДАХЬ БУЭНОС АЙРЭС АРИУН СҮМИЙН УРД АВСАН ГЭРЭЛ ЗУРАГ

ҮЙЛЧЛЭЛЭЭР ДҮҮРЭН НЯМ ГАРГУУД МИНЬ

Жэффри А.Хогг

Би ням гарагт завгүй байдаг ч гэсэн ахлагч Парли П.Пратт гэх мэт Сүмийн эхэн үеийн удирдагчдад тулгарч байсан зовлон зүдгүүрийг амсахгүйгээр үйлчлэх боломжтой байгаадаа талархдаг.

Ням гаргийн өглөө. Миний өмнө хурал цуглаан, ярилцлага, баталгаа, томилгоо хийх 12 цагийн хөтөлбөр байна. Би энэ бүх ажлыг аагим халуун өдөр гадасны нэг төвөөс эхлээд, хотын нөгөө захад байрлах өөр нэгэн цуглааны байранд дуусгах хүртэл хийнэ.

Би хурал, ярилцлага, баталгаа, томилгоо бүрийг тэсэж ядан хүлээдэг. Гэхдээ би өчигдөр *"Парли П.Праттын намтар"*-ыг нээж, орхисон хэсгээсээ үргэлжлүүлэн унших хүртэл, өөрийгөө завгүй байх нь дээ гэж бодон өрөвдөж суулаа. Ахлагч Парли П.Пратт Миссури дахь хүнд үед Иосеф Смит, Хайрум Смит болон бусад хүний хамт шоронд хоригдож байв. Ах нар Индепенденс рүү хүргэгдсэнийхээ дараа буудалд хоригдон, шалан дээр мод дэрлэн унтаж байлаа.

Нэгэн хүйтэн, цастай өглөө ахлагч Пратт босоод, нуцаар буудлаас гарч явжээ. Тэрээр тосгон дундуур зүүн зүгийг чиглэн явсаар, зэргэлдээх талбай руу орлоо. 1.6 км орчим алхсаныхаа дараа ахлагч Пратт ой руу ороход будрах цас мөрийг нь баллаж, модод биеийг нь халхалж байсан аж.

Яг энэ үед тэр ярвигтай нөхцөл байдлынхаа талаар эргэцүүлэн боджээ. Зүүн зүгийг чиглэн явбал өөр муж руу зугтан гарч, гэр бүлээ авчрах боломжтой болох байлаа. Харин буудал руу буцаж очвол хоригдон, ноцтой гэмт хэрэгт буруутгагдах байв. Зугтахыг завдсан ч ахлагч Пратт хэрэв явбал бусад хоригдолд учрах "бэрхшээл, тэр ч бүү хэл үхлийн" тухай боджээ.

Ийнхүү бодлогоширон байтал "Учир нь хэн өөрийн амийг аврахыг хүснэ, тэр хүн түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө, сайн мэдээний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ аварна" гэсэн судрын эшлэл санаанд нь орж ирэв (Марк 8:35; С ба Г 98:13-ыг үзнэ үү).

Ингээд ахлагч Пратт буудал руугаа буцжээ. Үүний дараа олон сарын турш хоригдож гэр бүл, гэгээнтнүүдээсээ хол байж, төлөөлөгчийн дуудлагадаа үйлчлэх боломжгүй болсон юм.[1]

Би номоо хаагаад, зарим нь миний өвөг дээдэс болох эхэн үеийн гэгээнтнүүдийн гачигдал зовлонгийн талаар тунгаан бодлоо. Тэд сайн мэдээний талаарх гэрчлэл, Есүс Христэд итгэх итгэлээсээ болж харгислал, хавчлагыг амссан. Тэд тэвчээртэй байж чадсан учраас би өнөөдөр итгэл, гэрчлэлээрээ тэдэнтэй холбогдон, эрх чөлөөтэй үйлчилж, шүтэн биширч байгаа билээ.

Намайг энэ ням гарагт бэлдэж байхад гэр бүл маань аюулаас хол, тав тухтай цуглааны байранд шүтэн бишрэх өдрийг тэсэн ядан хүлээж байгаа. Гэгээнтнүүдийн нөхөрлөл өдрийг маань гэрэлтүүлэх бөгөөд бид гишүүний баталгаа, томилгоог хийн, үүрэг хариуцлагаа биелүүлж, итгэлээ бэхжүүлж байхдаа тэдэнтэй хамт баясацгаана. Бид Аврагчаа болон Түүний цагаатгагч золиослолыг дурсан санаж, ариун ёслолоос хүртэнэ. Харин өнөө орой бид тав тухтай орондоо орон, зөөлөн дэрэн дээр толгойгоо тавихын өмнө гэртээ тойрон суугаад, Мормоны Номоо уншин, хамтдаа залбирна.

Ням гарагт надад ямар ч цаг зав байхгүй. Ийм байгаа нь адислал бөгөөд би үүндээ талархдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Парли П.Пратт, *Autobiography of Parley P. Pratt,* ed. Бага Парли П.Пратт (1979), 194–197.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЧАЙДИ УЭЙН

МЭЛВАГИЙН СҮҮЛЧИЙН ЗООГ

Шэрил Харвард Уилкокс

"Та ариун ёслолоос хүртэх гээд оролдоод үзэх үү?" гэж би өнөө маргаашгүй болж, хоногоо хүлээж байсан ээжээсээ асуув.

Ээж минь 92 нас хүрээд, саяхан нас барсан юм. Эмч нар түүнийг эмчилгээгүй, насан өөд болох хүртэл нь аль болох тайван байлгахаас өөр зүйл хийх хэрэггүй гэсэн шийдвэр гаргах үед тэр эмнэлэгт хэвтэж байв.

Түүнийг гэрт нь аваачихаар бэлдэж байхад тэр хавийн тойргийн хоёр ах ирээд, ээжийг минь ариун ёслол хүртэх хүсэлтэй байгаа эсэх талаар надаас асуув. Эхэндээ би тэдэнд "Үгүй дээ, баярлалаа" гэж хэлсэн. Ээж минь юм ч залгиж чадахгүй байсан юм. Дараа нь би "Байзаарай, би түүнээс асууя" гэж хэлэв. Би ээж рүүгээ ойртоод, "Энд хоёр санваартан байна. Та ариун ёслол хүртэх гээд оролдоод үзэх үү?" гэж асуулаа. Сулхан хэрнээ тод сонсогдохуйц дуугаар тэр "Тэгье" гэж хариулсан юм.

Адисалсны дараа би савнаас талхны хэлтэрхийг аваад, өчүүхэн үртэс хэсэглэн авч, ээжийнхээ аманд хийв. Тэр нэлээн удаан зажилж, би удаж байгаад нь ах нараас хүлцэл өчихөд тэд зүгээр ээ гэж хэлэв. Хоёр дахь залбирлын дараа би жижиг хуванцар аягатай усыг түүний уруулд ойртуулав. Жаахан балгасан ч сайн залгиж чадсанд нь би гайхлаа.

Би ах нарт талархаж, тэд ч хажуугийн өрөө рүү оров. Ээж минь ойролцоогоор цагийн дараа тайван гэгч амьсгал хураасан юм.

Дараагийн хэдэн өдөр нь би ямар ариун нандин мөчийг ээжтэйгээ хамт өнгөрүүлэх боломж олдсон болохыг ухаарсан юм. Ээжийн минь энэ амьдралдаа хамгийн сүүлд хийсэн зүйл бол ариун ёслолоос хүртсэн явдал байсан. Хамгийн сүүлчийн үг нь "Тэгье" буюу ариун ёслолоос хүртье, "харууссан зүрх, гэмшсэн сэтгэл"-ээ өргөе (3 Нифай 9:20), өөр дээрээ Есүс Христийн нэрийг авч, Түүнийг үргэлж дурсан санаж, Түүний Сүнсийг хүлээн авъя гэсэн үгс байсан. Хамгийн сүүлд хүртсэн зүйл нь ариун ёслолын бэлгэдэл байв.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРИСТОФЕР ТОРНОК

Сүүлчийн зоог нь хэчнээн сайхан амттай байсан бол! Хөдлөх байтугай ярих ч тэнхэлгүй байсан тэрээр Христ дотор ямар эрч хүчтэй байсан бол! Мөнх бус аяллынхаа эцсийн мөчүүдэд өөрийг нь дэмжиж, мөнх амьдралын найдварыг өгч байсан Түүний гэтэлгэгч, боломжийг олгогч хүчинд ээж маань хэчнээн их талархаж байсан бол!

Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ болон Түүний Хүү Есүс Христтэй адил болох гэж хичээх үедээ гэрээнүүдээ шинэчилж, өршөөл ба ач ивээлийг мэдрэх боломжтой байгаадаа талархах болтугай. Тэгж чадвал талх, ус нь ээжид минь "бүхнээс дээгүүр амттай, . . . бүхнээс цэвэр" (Алма 32:42) байсны адил байх болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

АВРАГЧИЙН АРГА БАРИЛААР ЗААХ НЬ

Ням гаргийн ангийн ерөнхий ерөнхийлөгч
Тэд Р.Каллистэр

Суралцахуйн баяр баясгалан

Бид илүү хариуцлагатай суралцагч болсноор Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах үед ирдэг тэнгэрлэг баяр баяслыг мэдрэх болно.

Тосгондоо залхуугаараа алдартай нэгэн хүний тухай түүх байдаг. Тэрээр ажил хайж, хийх ч хүсэлгүй нэгэн байв. Тэр зүгээр л бусдын хөлс хүчээр амьдардаг байлаа. Эцэст нь тосгоны хүмүүсийн тэвчээр барагдсан аж. Тэд түүнийг тосгоны бөглүү хэсэг рүү хөөж явуулахаар шийдэв. Ийнхүү тосгоны зах руу түүнийг сүйх тэргээр хүргэж явах үед жолооч эрд өрөвдөх сэтгэл төржээ. Шоовдорлогдсон түүнд дахин нэг боломж олгох нь зүйтэй гэж бодогдов. Ингээд тэрээр “Бүхнийг шинээр эхлэхийн тулд бага зэрэг эрдэнэ шиш авах уу?” гэж асуулаа.

Харин үүний хариуд нөгөөх эр ”Хальсыг нь арилгасан уу?”[1] гэж асуусан гэдэг.

Багш, суралцагч хоёр хоёулаа хувь нэмэр оруулах үүрэгтэй

Зарим хүн судар судлахдаа ямар ч хичээл зүтгэл гаргадаггүй буюу судрын үгээс зооглохын өмнө хальсалж өгөхийг хүсдэг. Түүнээс гадна тэд сайн мэдээг сонирхолтой хэлбэрээр дуу бичлэг болон видео бичлэгийн цуврал болгож авахыг хүсдэг. Тэд өөрсдийнхөө зүгээс маш бага бэлтгэл хийж эсвэл оролцон, Ням гаргийн багшаар бүх зүйлийг бэлдүүлж, ам руугаа халбагадуулахыг хүсдэг.

Үүнээс эрс ялгаатай нь, Аврагч үгийг нь ойлгохгүй байсан хүмүүсээс гэртээ харихыг хүссэн юм. Тэрээр тэдэнд “би та нарт дахин ирэх маргаашийн төлөө оюун санаагаа бэлтгэж” болохын тулд залбирч, тунгаан бод хэмээн зарлиглажээ (3 Нифай 17:2–3-ыг үзнэ үү).

Гол сургамж нь бэлтгэлтэй ирэх нь багшийн төдийгүй суралцагчийн үүрэг хариуцлага юм гэсэн утгатай. Сүнсээр заах нь багшийн үүрэг хариуцлага байдгийн адил суралцагч ч гэсэн Сүнсээр суралцах үүрэг хариуцлагатай байдаг (С ба Г 50:13–21-ийг үзнэ үү).

Мормоны Номонд “Номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү бус ажгуу, бас *багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; мөн тийн тэд бүгд адил тэгш* байв” (Алма 1:26; онцлон бичилт нэмэв) хэмээн цэдэглэсэн.

Сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах үүргээ биелүүлснээр ирдэг баяр баяслыг мэдрэхийн тулд бид юу хийж чадах талаар зарим зөвлөгөөг доор дурдав.

Гэртээ суралцах нь
Судруудыг судал

Гишүүн бүр өөрөө сайн мэдээнээс суралцах үүрэг хариуцлагатай бөгөөд уг үүрэг хариуцлагаа бусдад дамжуулж болохгүй. Бид ихэнхдээ судраас тогтмол судлах үедээ суралцаж байдаг. Ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973): “Хэрэв бид судруудыг өдөр болгон уншихгүй бол гэрчлэл маань нимгэрч байдаг”[2] хэмээн тунхаглажээ. Төлөөлөгч Паул “Берой дахь иудейчүүд Тесалоникийн хүмүүсийг бодвол уужим сэтгэлтэй байсан бөгөөд тэд үгийг дуртайяа хүлээн авч” байсныг дурдсан байдаг бөгөөд үүний шалтгааныг “[Тэд] *Судрыг өдөр бүр нягтлан үзэж байлаа*” (Үйлс 17:11; онцлон бичилт нэмэв) хэмээн хэлжээ.

Өдөр болгон судар судлах нь сүнслэг байдлын маань амин чухал хэсэг юм. Өдөр тутмын амьдралд гүйцэтгэдэг үүний орон зайг өөр юугаар ч орлуулах боломжгүй. Иймээс судар судлах нь зөвхөн цаг зав гарвал хийдэг зүйл биш, харин зориуд цаг гарган хийх ёстой зүйл юм.

Зарим хүн “Амьдралд нь байгаа олон үүрэг хариуцлагын хажуугаар өдөр тутам судар судлах цаг алга” гэж хэлдэг байж болно. Энэ мэдэгдэл нь нэг өдөрт хэн нь олон мод тайрах тэмцээн явуулсан хоёр түлээчингийн түүхийг санагдуулдаг. Ургах нарнаар тэмцээн эхэллээ. Жижиг биетэй эрэгтэй нь цаг тутам 10 орчим минут ой руу явдаг байв. Ингэх бүрд өрсөлдөгч нь түрүүлж байгаа гэдэгтээ итгээд, инээмсэглэн, толгойгоо дохиж байлаа. Том биетэй түлээчин байрнаасаа огт хөдөлсөнгүй, тайрахаа ч зогсоосонгүй, амсхийсэн ч үгүй.

Өдрийн төгсгөлд маш их цаг дэмий гарздаж дээ гэж бодсон өрсөлдөгч нь илүү олон мод тайрсан байхыг хараад, том биетэй эр цочирдож, “Чи тийм их амарсан байтлаа яаж энэ бүхнийг хийж чадав аа?” гэж асуулаа.

Ялагч “Аан, би сүхээ ирлэж байсан юм” гэж хариулжээ.

Судраас унших бүрдээ бид сүнслэг сүхээ ирлэж байдаг. Гайхалтай зүйл нь гэвэл, бид үүнийг хийснээр үлдсэн цагаа илүү ухаалаг зарцуулж чаддаг юм.

Урьдчилан бэлд

Сүмийн гишүүдийн зөвхөн цөөхөн хувь нь Ням гаргийн ангид үзэх судруудаа урьдчилан унших болохыг судалгаа харуулсан. Бидний хүн нэг бүр энэ нөхцөл байдлыг өөрчилж чадна. Бид илүү бэлтгэлтэй, судруудаа

уншчихсан, санал бодлоо хуваалцахад бэлэн ангид ирснээр суралцах үйл явцад гүйцэтгэдэг өөрийн үүргийг биелүүлж чадна. Бидний бэлтгэл ангийнхаа гишүүдэд өгөх сүнслэг бэлэг байж болох юм.

Ангид суралцах нь

Хичээлд оролц

Амаа нээх зарлиг нь (С ба Г 60:2–3-ыг үзнэ үү) зөвхөн сайн мэдээг хуваалцах үед бус, анги танхимд ч гэсэн хамаатай. Бид оролцсоноороо хуваалцсан зүйлийн маань үнэнийг гэрчилж, бидний оюуныг илүү гүн ойлголтоор гэгээрүүлдэг Сүнсийг урьж байдаг. Үүнээс гадна, бидний оролцоо өөр хүний бодлыг өдөөж, тэдний оролцоог дэмжих болно.

Ийм маягаар бид Их Эзэний заасан *"бүгдээрээ бухнээс сэнхэрсэн байж болохын тулд,* нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог" (С ба Г 88:122; онцлон бичилт нэмэв) хэмээх сургаалыг дагаж байгаа юм. Хичээлд идэвхтэй оролцох нь заримдаа амар байдаггүй ч биднээс өөрсдийнхөө дассан хүрээнээс гарахыг шаардаг. Гэхдээ үүнийг хийснээр ангид байгаа бүх хүнд өсөлт хөгжил авчирдаг.

Төрсөн мэдрэмжээ бичиж тэмдэглэ

Би сүмд ирэхдээ тэмдэглэх цаас авчран, тэмдэглэж болох сургаалын тухай ойлголт, сүнслэг өдөөлтийг эрэлхийлдэг болсон юм. Үүнийг хийснийхээ ач тусыг хүртсэн гэдгээ би баттай хэлж чадна. Энэ арга миний үзэл бодлыг өөрчилж, суралцах үйл явцыг нэг чиглэлд төвлөрүүлэн, хурдасгаж, сүмд тавих хүлээлтийг маань нэмэгдүүлсэн.

Яагаад сүм дээр болон өөр газар хүлээн авсан сүнслэг туршлагаа тэмдэглэж байх нь тийм чухал байдаг вэ? Нэгэн ээжийг өсвөр насны хүүтэйгээ ярьж байгаагаар түр зуур төсөөлөөд үзье. Энэ үеэр хүү нь "Ээж ээ, энэ чинь үнэхээр сайн зөвлөгөө байна" гэж хэлэв. Дараа нь тэр тэмдэглэлийн дэвтрээ гаргаж ирээд, ярилцаж байх үед төрсөн мэдрэмжээ бичиж эхэлнэ. Ийм үед ээж нь гайхсан ч дараа нь хүүдээ дахин зөвлөгөө өгөхийг хүсэхгүй гэж үү?

Энэ зарчим Тэнгэрлэг Эцэгээс ирж буй зөвлөгөөнд ч мөн адил үйлчилнэ гэдэгт ямар ч эргэлзээ байхгүй. Түүний бидэнд өгсөн мэдрэмжийг бичиж авч байх юм бол Тэр бидэнд илүү олон илчлэлт өгөх нь гарцаагүй. Үүнээс гадна, бидний хүлээн авдаг мэдрэмж эхэндээ өчүүхэн жижиг боргоцой мэт санагдаж байж болох ч хэрэв бид тэдгээрийг тордож арчлан, тунгаан бодвол агуу том сүнслэг царс мод болон ургаж болно.

Бошиглогч Иосеф Смит хүлээн авсан ойлголт, төрсөн сэтгэгдлээ тэмдэглэж байхын ач холбогдлын талаар "Хэрэв та нар . . . чухал асуултыг авч хэлэлцсэн мөртлөө . . . тэмдэглэж аваагүй бол, . . . Бурханыг илчлэх үед тэдгээрийг үнэ цэнгүй зүйл хэмээн үзэж, үл тоомсорлон, тэмдэглэж аваагүйн улмаас Сүнс та нараас холдож болох бөгөөд . . . юунаас ч чухал, асар их мэдлэг алдагдсан байх болно" хэмээн хэлсэн.[3]

Суралцахуйн баяр баясгалан

Суралцах нь бурханлаг үүрэг хариуцлагаас ч илүү агуу зүйл юм. Энэ нь туйлын их баяр





хөөртэй байхаар заяагдсан юм.

Нэг удаа эртний нэгэн математикч Архимедээс хаан нь шинэ титмээ цул алт байна уу эсвэл дархан зарим алтыг мөнгөөр орлуулсан байна уу үгүй юу гэдгийг олж тогтоохыг хүсжээ. Архимед шийдлийг тунгаан бодсоны эцэст хариулт нь ирсэн байна. Тэрээр хариултыг олсондоо магнай хагартал баярласан бөгөөд домогт дурдсанаар "Эврика, эврика!" хэмээн хотоор нэг хашгиран гүйсэн гэдэг. Энэ нь "Би оллоо! Би үүнийг оллоо!" гэсэн утгатай үг юм.

Шинжлэх ухааны нээлт хийсэн түүний баясал ийм агуу байхад Есүс Христийн сайн мэдээний үнэнийг нээж олбол түүнээс ч илүү агуу баяр хөөрийг мэдрэх болно. Тэдгээр үнэн нь бидэнд мэдээлэл өгөхөөс гадна биднийг авардаг билээ. Энэ учир шалтгаанаар Аврагч "та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв" (Иохан 15:11) хэмээн айлджээ. Мөн үүний учир авралын төлөвлөгөөний талаар мэдэж аваад, "Бурханы бүх хөвгүүд баярлалдан уухайлсан" юм (Иов 38:7). Үрэнд ургаж томрох байгалиас заяасан чадвар байдгийн адил сайн мэдээний үнэнд баяр баяслыг авчрах байгалиас заяасан хүч бий.

"Суралцахыг эрэлхийлэгтүн" (С ба Г 88:118) гэдэг нь тэнгэрлэг зарлиг төдийгүй бурхантай адил болох гэсэн эрэл хайгуул юм. Бид судраас суралцан, ангидаа илүү сайн бэлтгэлтэй ирж, ангийн ярилцлагад оролцон, асуулт тавьж, ариун нандин сэтгэгдлээ тэмдэглэх болгондоо Бурхантай илүү адил болж, Түүний мэдэрдэг баяр баяслыг мэдрэх чадвараа өсгөн нэмэгдүүлж байдаг.

Бид гэр орон, анги танхим, өөр хаана ч байсан илүү хичээнгүй, илүү тэнгэрлэг суралцагчид байх болтугай. Ингэж чадвал бид Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, түүнийг дагаж амьдарснаар хүлээн авах төгс баяр баясгаланг мэдрэх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Ахлагч Д. Тодд Кристоффэрсон үүнтэй адил түүхийг 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хуваалцсан.
2. Харолд Б.Лий, бүсийн төлөөлөгчдийн семинар, 1970 оны 12-р сарын 12.
3. Иосеф Смит, *Сүмийн Түүх,* 2:199.

Бурхантай адил

суралцахыг эрэлхийлэх нь

Бид судраас суралцан, ангидаа илүү сайн бэлтгэлтэй ирж, ангийн ярилцлагад оролцон, асуулт тавьж, ариун нандин сэтгэгдлээ тэмдэглэх болгондоо Бурхантай илүү адил болж, Түүний мэдэрдэг баяр баяслыг мэдрэх чадвараа өсгөн нэмэгдүүлж байдаг.

Бага насны хүүхдүүд БА ариун ёслол

Бага насны хүүхдүүд маань ариун ёслол бидний хувьд чухал гэдгийг мэдэрсэн болов уу. Бид энэ нь тэдэнд ч гэсэн чухал гэдгийг ойлгуулахын тулд илүү ихийг хийж болох байсан.

Аарон Л.Вэст

Яагаад бид баптисм хүртээгүй хүүхдүүдэд ариун ёслолоос хүртэхийг зөвшөөрдөг талаар та нар бодож байсан уу? Талх авах гэж орилж хашгирахаас нь зайлсхийхийн тулд л гэж үү? Эсвэл ёслолыг нам гүм орчинд, илүү амар хялбар гүйцэтгэхийн тулд юм болов уу?

Би тэгж бодохгүй байна. Үүнд илүү гүн гүнзгий учир шалтгаан бий гэдэгт би итгэдэг. Би яагаад үүнд итгэдэг вэ гэвэл, Есүс Христ "бүх" гэж хэлэхдээ бүх хүнийг хэлсэн байдаг. Тэрээр цугласан олонд хандан ярихдаа хэнийг ч гадуурхдаггүй байсан.

Амилсан Аврагч ариун ёслолыг Америк тив дэх хүмүүстээ танилцуулахдаа уг ёслол нь баптисм хүртсэн хүмүүсийн хувьд онцгой утга учиртай гэдгийг онцолсон байдаг.[1] Тэгж хэлсэн ч гэсэн Тэрээр [ариун ёслолыг] *цугласан олонд* өг гэсэн зарлигийг шавь нартаа өгсөн байдаг билээ.[2] Цугласан олонд "бяцхан үрс" ч гэсэн багтаж байсан.[3]

Өнөөдөр санваартнууд ариун ёслолын залбирлыг уншиж байхдаа Тэнгэрлэг Эцэгээс талх, усыг "үүнээс хүртэх тэд *бүгдийн* бодгалийн тулд" адисалж мөн ариулж өгөхийг хүсдэг.[4] Бүгд. Үүнд хүртэж байгаа хүн бүр, балчир хүүхдүүд ч мөн адил орно

Талх, уснаас хүртэж байхдаа балчир хүүхдүүд энэ бэлгэдлийг цэвэр ариун бодгалиуддаа адислал болгон



хүлээн авдаг юм бол тэдэнд ёслолын утга учрыг ойлгоход нь туслах арга зам бас байх ёстой.

Үүнийг ойлгосноороо би хүүхдүүдийнхээ бага балчир байсан үеийг эргэн санав. Эхнэр бид хоёр ариун ёслолыг тарааж байх үеэр тэднийг чимээгүй суулгаж чаддаг байлаа. Тэд ариун ёслол бидний хувьд чухал гэдгийг мэдэрсэн байх гэж би боддог. Гэхдээ энэ нь *тэдний* хувьд ч гэсэн чухал гэдгийг ойлгуулахын тулд бид илүү олон зүйл хийж болох байсан.

Бид юу хийж болох байсан бэ? Бид бага насны хүүхдүүд ариун ёслолын залбиралд орсон амлалтуудыг сахих чадвартай гэдгийг санаж болох байсан. Тэд жижигхэн ч гэсэн өөрсдөдөө тохирсон хүчирхэг арга замаар Есүсийг "үргэлж дурсан санах" гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгож чадна. Тэд "зарлигуудыг сахих" амлалт өгч чадна. Тэр байтугай удахгүй баптисм хүртэж, гишүүнээр батлагдсаныхаа дараа Христийн "нэрийг өөрсөд дээрээ авахад бэлэн" байх болно гэдгээ харуулж чадна.[5]

Харин гэрээнүүдээ хэрхэн шинэчлэх вэ? Сүмийн удирдагчид бид ариун ёслолоос хүртэж байхдаа Их Эзэнтэй хийсэн бүх гэрээгээ шинэчилдэг гэж заасан.[6] Бага насны хүүхдүүдэд шинэчлэх гэрээ байхгүй.

Хүүхдүүд маань бага байсан үеийг би дахин эргэн санадаг. Бид тэдэнд гэрээнүүдээ шинэчлэхэд нь тусалж чадахгүй боловч тэдгээрийг хүлээн авахад бэлдэхэд нь тусалж чадах байсан. Би өөрийгөө нэгэн ням гаргийн өглөө нэг бяцхан хүү эсвэл охинтой хамт байгаагаар төсөөлөн бодов. "Чи найман нас хүрээд баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна. Чи гэрээ хийнэ. *Тэр үед* хийх гэрээ чинь *одоо* ариун ёслолоос хүртэхдээ өгдөг амлалттай чинь адил юм. Би өнөөдөр ариун ёслолоос хүртэхдээ тэдгээр амлалтаа дахин өгч байгаатай адил, баптисмын гэрээгээ шинэчлэх болно. Намайг үүнийг хийж байхад чи надтай хамт байх боловч ямар нэг гэрээ шинэчлэхгүй. Чи хараахан гэрээгээ хийгээгүй байгаа. Харин үүний оронд чи гэрээ хийх *дадлага* хийж болно. Чи ариун ёслолоос хүртэх болгондоо баптисм хүртэж, гишүүнээр батлагдахад өөрийгөө бэлдэж байдаг. Ингэж чадах юм бол чи найман нас хүрэхдээ бэлэн болсон байна" гэж хэлнэ.

Хэрэв *дадлага хийх* гэдэг үгийг энэ маягаар ашиглах нь сонин санагдаж байвал дараах зүйлийг бодож үзээрэй. Бишрэл хүндэтгэлтэй орчинд эцэг хүн хүүхдүүддээ баптисмын ёслолд бэлдэхэд нь туслахын тулд усанд хэрхэн хамтдаа зогсохыг зааж, баптисмын залбирлын үгийг хуваалцаж болно. Ийм нөхцөлд ёслолыг гүйцэтгэж байгаа юм биш. Нэг ёсондоо хүүхдүүддээ дадлага хийхэд нь тусалж байгаа хэрэг. Ингэх юм бол баптисмын усанд орох үед юу болох бол гэж санаа нь зовохгүй байх болно. Түүнчлэн эцэг эхчүүд хүүхдүүддээ баптисмын гэрээг хийж, сахих дадлага хийхэд нь тусалж чадна гэдэгт би итгэдэг. Ариун ёслол нь Аврагчийн Цагаатгалын бэлгэдлээс хүртэх болгондоо бага насны хүүхдүүдэд ариун нандин дадлага хийх боломж байж болно.

Тэгэхээр би эхлээд тавьсан асуултаа эргэн харъя. Яагаад бид баптисм хүртээгүй хүүхдүүдэд ариун ёслолоос хүртэхийг зөвшөөрдөг вэ? Үүнийг зүгээр л "дэг журамтай" байлгахын тулд хийдэг гэж үү? Мэдээж үгүй. Бид бага насны хүүхдүүддээ Аврагчаа дурсан санаж, дэлхийн хаанаас ч олж авч чадахгүй амар амгаланг нь хадгалж үлдэхийн тулд ариун ёслолоос хүртэхэд тусалдаг.[7] Бид тэдэнд тэрхүү амар амгаланг ирээдүйд илүү их, арвин хүлээн авч, өөрсдөө Түүнтэй гэрээ хийж мөн сахихад бэлдэхэд нь тусалдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. 3 Нифай 18:5, 11-ийг үзнэ үү.
2. 3 Нифай 18:4; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. 3 Нифай 17:21; 18:1–4-ийг үзнэ үү.
4. Сургаал ба Гэрээ 20:77, 79; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
5. Сургаал ба Гэрээ 20:77.
6. Л.Том Пэрри, "As Now We Take the Sacrament," *Liahona,* 2006 оны 5-р сар, 41-ийг үзнэ үү.
7. Иохан 14:27-г үзнэ үү.

Амиа хорлох явдлыг ойлгох нь

СЭРЭМЖЛҮҮЛГИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Доктор Кэничи Шимокава
ХҮГ-ийн Гэр бүлийн үйлчлэлийн алба, Япон дахь салбар

Кэвинийг 16 настай байхад эцэг, эх хоёр нь салжээ. Энэ үеэс эхлэн тэр сэтгэл санааг нь тогтворжуулахад тусалдаг эпилепси өвчний эмээ уухаа больсон байна. Хоёр туйлт сэтгэцийн өвчинтэй гэдгээ мэдэхгүй байсан учраас тэр дэмийрч, ухаан санаа нь балартаж, сэтгэл гутралд гүн автсан байжээ. Эм нэмэр болохгүй байгаа мэт байв. Энэ нь даамжирсаар тэр бүх зүйлээс залхах болж, бусдад мэдэгдэлгүй амиа хорлохоор шийджээ.

Кэвин амиа хорлохоор завдсан тэр өдрийнхөө тухай ийнхүү ярьсан байна. Тэрээр "Би уйлж байв. Би маш их ядарч цөхрөн, сэтгэл санааны хувьд туйлдсан байлаа. Би хүмүүс рүү харж, хэн нэгэн хүн 'Чи ЗҮГЭЭР ҮҮ?' гэж асуугаасай гэж хүсэж байв. Үүнийг хэчнээн их хүсэж байсан ч [толгойд] 'Чи үхэх ёстой' гэсэн дуу хоолой сонсогдож байлаа. . . . Би өөрөөсөө [үүнийг битгий хийгээч] гэж гуйж байсан ч дуу хоолой дэндүү хүчтэй байсан болохоор эсэргүүцэж чадаагүй юм" гэжээ.[1]

Харамсалтай нь, хэн ч түүний зовлонг олж хараагүй ажээ. Тэр өөрт нь хэн ч санаа тавьдаггүй гэдэгт итгэсэндээ амиа хорлох гэж оролдсон боловч гайхалтай нь амьд үлдсэн юм.

Бид түүний сэтгэлийн шаналал, цөхрөл, чимээгүйхэн тусламж гуйж байгааг бага ч гэсэн мэдрэх байсан болов уу?

Амиа хорлох нь ийм бодол төрдөг хүмүүст болон үлдэж байгаа ар гэрийнхэнд мөнх бус байдалд тохиолддог хамгийн хүнд сорилтуудын нэг юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард: "Миний хувьд гэр бүлд хайртай хүн нь амиа егүүтгэхээс илүү хүнд цаг үе гэж байхгүй. Амиа хорлох явдал бол гэр бүлд маш хүнд тусдаг зүйл юм"[2] гэж хэлсэн. Энэ сорилтын ноцтой байдлыг харгалзан үзээд, бүгдээрээ (1) амиа хорлож болзошгүй

ГЭРЭЭЛ ЗУРГИЙГ © ISTOCK/THINKSTOCK

талаарх шинж тэмдгүүд, үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд юу хийж болох гэх мэт мэддэг зүйлсээ; (2) үлдэж байгаа ар гэрийнхэн болон хүмүүс юу хийж болох; (3) цөхрөлд орохгүйн тулд бид Христэд итгэх итгэл, найдвараа хүчирхэгжүүлэхээр юу хийх хэрэгтэй талаар ярилцацгаая.

Амиа хорлох явдлыг ойлгох нь

Дэлхий даяар жил бүр 800 000 гаруй хүн амиа егүүтгэдэг байна.[3] Энэ нь 40 секунд тутамд дэлхий дээр хэн нэгэн хүн амиа егүүтгэж байна гэсэн үг юм. Амиа хорлох гэдэг нь эмзэг сэдэв ба зарим улс оронд хууль бус байдаг тул үүнийг нуун дарагдуулах тохиолдол их байдаг учраас бодит тоо баримт нь үүнээс ч олон байх магадлалтай. Амиа хорлох явдал 15-29 насны хүмүүсийн нас баралтын хоёр дахь шалтгаан болдог. Ихэнх оронд 70-аас дээш насны хүмүүс амиа хорлосон тоон үзүүлэлт хамгийн өндөр байдаг байна. Амиа хорлох нь шууд эсвэл шууд бус замаар нийгмийн дийлэнх хэсэгт нөлөөлдөг.

Аюулын дохио

Амьдралд тулгарах саад бэрхшээл хэрээс маань хэтэрсэн мэт санагдах үед бид ихээхэн дарамтад ордог. Сэтгэл санааны зовлон шаналал дааж давшгүй мэт санагдах үед хүний ухаан санаа уймарч, улмаар үхэл бол цорын ганц сонголт гэж үзэхэд хүргэдэг. Тэд хэн ч өөрсдөд нь тусалж чадахгүй гэж боддог тул нийгмээс өөрсдийгөө тусгаарлаж, гарцгүй, найдваргүй гэсэн мэдрэмж нь улам бүр даамжирч, улмаар амиа хорлохыг цорын ганц гарц гэж бодоход хүрдэг.

Алмагийн зааснаар бид “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд үүрэлцэж, . . . гашуудах тэдний хамт гашуудаж, тийм ээ тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруул[ах]” ёстой.

Хэн нэгэн хүнд дараах ноцтой шинж тэмдгүүдийн *аль нэг нь* илэрвэл[4] бид сэтгэцийн эмнэлэг эсвэл цагдаа гэх мэт яаралтай тусламж үзүүлэх байгууллагад хандах хэрэгтэй. Үүнд:

- Өөрсдийгөө гэмтээх эсвэл амиа хорлоно гэж заналхийлэх
- Өөрсдийгөө егүүтгэх арга зам, хэрэгслийг эрж хайх
- Үхэх, нас барах эсвэл амиа хорлох талаар ярих эсвэл бичих

Дараах шинж тэмдгүүд амь насанд аюултай биш ч ийм шинж тэмдэг илэрч байгаа хүнд ойртон дотносож, тусламж үзүүлэх ёстой. Тухайлбал:

- Мухардаж, амьдралын зорилгогүй болсноо илэрхийлэх
- Уурлаж хилэгнэх эсвэл өшөө авахыг эрэлхийлэх
- Бодлогогүй үйлдэл хийх
- Гарах гарцгүй болсон мэт санагдах
- Согтуурууллах ундаа эсвэл мансууруулах бодисын хэрэглээгээ нэмэгдүүлэх
- Найз нөхөд, гэр бүл, нийгмээс өөрсдийгөө тусгаарлах
- Сэтгэл тавгүйтэх, цухалдах эсвэл зан ааш нь огцом өөрчлөгдөх
- Нойргүйтэх эсвэл байнга унтах
- Бусдад ачаа дарамт болж байна гэж үзэх

Амиа хорлохыг завдаж байгаа хүн бүр энэ тухайгаа бусдад мэдэгдээд байдаггүй. Ихэнх хүнд дээрх шинж тэмдэг илэрдэг. Тиймээс эдгээр шинж тэмдгийг нухацтай авч үзээрэй!

Мэргэжлийн тусламж шууд авах боломжгүй ч гэсэн чин сэтгэлээсээ санаа тавьдаг найз нөхөд, гэр бүлийнхний хүч чадлыг дутуу үнэлж болохгүй.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Хүн амиа хорлохыг завдах үед гэр бүлийнхэн болон найз нөхдийн тусламж чухал үүрэг гүйцэтгэдэг. Алмагийн заасанчлан бид “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд үүрэлцэж, . . . гашуудах тэдний хамт гашуудаж, тийм ээ тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулж” байх ёстой (Мозая 18:8, 9).

Гэр бүлийнхэн ба найзууд дараах тус болох зүйлсийг хийж болно. Үүнд:

Тусламжийн гараа сунгаж, хайраар сонс. Ахлагч Баллардын зөвлөснөөр, "Зовж буй хүмүүсийг тэврэн авах хайрын мутраас илүү хүчтэй зүйл гэж үгүй."[5] Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэйл Г.Рэнланд "Бид тэднийг . . . Тэнгэрлэг Эцэгийн нүдээр харах ёстой. Зөвхөн тэгснээр бид тэднийг гэсэн Аврагчийн сэтгэлийг ойлгох болно. . . . Улам бүр гүнзгийрэх энэ ойлголт бидний зүрх сэтгэлийг нээж, бусдын уй гашуу, айдас, зовлон шаналлыг ойлгоход тусална" хэмээн заасан.[6]

Бодитой зүйл дээр тусал. Хэн нэгэнд тулгарч байгаа хямрал аюулгүй байдал, үндсэн хэрэгцээнд нь нөлөөлж байгаа бол бодитой тусламж үзүүлэхийг санал болго. Гэхдээ уг хүнээр тусламж хүлээн авах эсэх сонголтыг нь хийлгэх ёстой. Жишээлбэл, ажлаа алдсанаас болж амиа хорлох бодол тээж байгаа хэн нэгэнд нээлттэй ажлын байр олоход туслах сонголтыг гаргаж өгөх нь гацаанд орсон мэт мэдрэмжээс салахад тусална.

Тэднээс амиа хорлох талаар бодож байгаа эсэхийг асуу. Хэрэв хэн нэгэн сэтгэлийн зовиурт унаж, амиа хорлох гэсэн шинж тэмдгүүд илэрч байгаад санаа зовж байгаа бол түүнээс амиа хорлох талаар бодож байгаа эсэхийг асуу. Ингэж асуух нь эвгүй байж болох ч амиа хорлох талаар бодож байгаа эсэхийг шууд асууж, мэдэж авах нь хамгийн зөв зүйтэй арга юм. Энэ нь уг хүнд тулгарч буй асуудал, санааг нь зовоож байгаа зүйлээ ярилцах үүд хаалгыг нээж өгч болно.

Жишээлбэл, "Наадах чинь ямар ч хүнд давж гарахад хүнд л зүйл юм шиг сонсогдож байна. Чи амиа хорлоё гэж бодоогүй биз дээ?" эсвэл "Чи ингэж их зовж байгаа юм чинь амиа хорлох талаар бодож байгаа юм биш биз? Хэрэв тэд амиа хорлох бодолгүй байгаа бол үүнийгээ танд хэлэх байх.

Хэрэв тэд амиа хорлох тухай бодлынхоо талаар нээлттэй ярилцахгүй байвал юу хийхээ мэдэхийн тулд Сүнсний өдөөлтийг анхааралтай сонс. Тантай нээлттэй ярилцах хүртэл хамт бай гэсэн өдөөлт ирж болно.

Уг хүнтэй хамт байж, тусламж ав. Хэрэв хэн нэгэн хүн амиа хорлох бодолтой байгаагаа танд хэлбэл уг хүнтэй ойр байж, юу тэднийг зовоож байгаа талаар яриул. Хэрэв тэд амиа хорлох тодорхой арга, цаг хугацааны талаар яривал уг хүнд онцгой байдлын үед туслах төвийн утсаар эсвэл сэтгэцийн түргэн тусламжийн тасагтай холбоо барихад нь тусал.

Амиа хорлох явдалд үзүүлэх хариу үйлдэл

Зарим хүн аюулын шинж тэмдэг илэрч байгаа эсэх нь мэдэгдэхгүй байж байгаад амиа хорлодог. Хайртай хүн нь амиа хорлосон гэр бүлийн гишүүд, найз нөхөд асар их, гүн гүнзгий уй гашууд автдаг. Тэд дараах хариу үйлдлийг үзүүлж болох юм. Үүнд:

- Ичгүүр, гутамшгийг мэдрэх
- Хүнд цохилтод орж, иттэхгүй байх
- Уурлах, тайвшрах эсвэл өөрийгөө буруутгах
- Үхлийн шалтгааныг нуух
- Нийгмээс тусгаарлах, гэр бүлийн харилцаанд хагарал гарах
- Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд идэвхтэй, хэт улайран оролцох
- Яагаад гэдгийг ойлгох гэсэн хүсэлд автах
- Орхигдсон, хаягдсан мэт санагдах
- Талийгаачийг ч, өөрийгөө ч мөн бусдыг болон Бурханыг буруутгах
- Амиа хорлох гэсэн бодолд эсвэл өөрийгөө үгүй хийх гэсэн мэдрэмжинд улам бүр автах
- Баяр ёслолоор болон нас барсан өдрөөр нь сэтгэлийн дарамтад орох[7]

Үлдэж буй ар гэрийнхэн болон хүмүүс юу хийж чадах вэ

Шүүмжлэхээс татгалз. Амиа хорлох нь ноцтой үйлдэл боловч ахлагч Баллард "Мэдээж, бид амиа хорлох явдалтай холбоотой нөхцөл байдлыг бүрэн дүүрэн мэдэхгүй. Зөвхөн Их Эзэн бүх зүйлийг мэдэх бөгөөд Тэр л ганцаар дэлхий дээрх бидний үйлдлийг шүүх болно. [Их Эзэн] биднийг шүүхдээ генетикийн онцлог, сэтгэл санааны байдал, оюуны чадамж, заалгасан сургамж, эцэг өвгөдийн уламжлал, эрүүл мэнд гэх мэт бүх зүйлийг харгалзаж үзнэ гэж бодож байна" гэж сануулсан.[8]

Хүн бүрд өөрийнхөөрөө гашуудах боломж олгон, үйлдлийг нь хүндэл. Хүн бүрийн талийгаачтай харилцах харилцаа янз бүр байх тул тэд өөр өөр арга замаар гашуудлаа илэрхийлдэг. Тиймээс бие биенийхээ гашуудаж байгаа арга замыг хүндэл.

Хайртай хүмүүс маань орхин одох үед биднийг хүчтэй, бүр асар хүчтэй мэдрэмж эзэмдэн авдаг. Гашуудаж байна гэдэг нь иттэл дутаж байна гэсэн үг биш юм. Их Эзэн "Чи хайранд хамтдаа амьдрах ёстой, ийнхүү чи нас нөгчсөн тэднийг алдсаныхаа . . . төлөө уйлах ёстой" хэмээн айлдсан (С ба Г 42:45). Уй гашуу бол талийгаачийг хайрлах бидний хайр, харилцаа холбоо ямар утга учиртай байсны илрэл юм.

Тусламж хүс. Гашуудах үед аливаа зүйл дааж давшгүй мэт санагдаж болно. Тусламж хүссэнээрээ та бусад хүнд таныг хайрлаж, танд үйлчлэх ариун нандин боломжийг олгоно. Тэдэнд туслах боломж олгох нь зөвхөн таныг ч бус тэднийг ч мөн адил эдгээж, хүчирхэгжүүлж чадна.

Холбоотой бай. Зарим хүн дотроо гашуудаж, өөрийгөө бусдаас тусгаарладаг учраас гэр бүлийнхэн, найз нөхөдтэйгөө холбоотой бай. Гашуудаж байгаа гэр бүлийн гишүүд, төрөл садан, найзуудтайгаа тогтмол холбоо барьж, тусламж хэрэгтэй байгааг асуу. Яагаад гэвэл тэд өөрсдөө тан дээр ирэхгүй байж магадгүй.

Аврагчид найд. Эцсийн эцэст Аврагч бол эдгээх, амар амгалан байх эх ундарга мөн. "Түүний Цагаатгал . . . мөнх бус байдлын бүхий л ачаа дарамтыг даван туулах хүчийг өгөхийн тулд бидний бүх сул доройг мэдэрч туулсан Түүнийг дуудах боломжийг бидэнд олгодог. Тэрээр бидний өвчин зовлонг мэддэг бөгөөд Тэр бидэнд туслахад бэлэн байдаг. Сайн самари хүний адилаар Тэрээр замын хажууд шархадсан биднийг олж, бидний шархыг боон, биднийг асрах болно (Лук 10:34-ийг үзнэ үү)."[9]

Бид бүгдээрээ чадах зүйлээ хийхийг хичээхийн сацуу Их Эзэн Есүс Христэд болон Түүний Цагаатгалд бүрэн найдах хэрэгтэй гэдгээ ухааран ойлгоцгооё. Үүнийг даруу байдлаар хүлээн зөвшөөрч, зовж шаналж байгаа гэр бүл, хөршүүдээ ойлгохыг хичээн, тэдэнд хайрын гараа сунган, Аврагчид иттэх илүү их иттэл найдварыг хамтдаа хөгжүүлцгээе. Учир нь Тэрээр эргэн ирж "тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно" (Илчлэлт 21:4). ■

ЭШЛЭЛҮҮД

1. Кэвин Хайнс, Аманда Бауэрийн "A Survivor Talks About His Leap," *Time,* 2006 оны 5-р сарын 24, Time.com.
2. М.Рассэлл Баллард, Жэйсон Свэнсоны "Elder Ballard Offers Comfort and Counsel to Those Affected by Suicide," *Church News,* 2014 оны 12-р сарын 19, news.lds.org.
3. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, *Preventing Suicide: A Global Imperative* (2014), 2-ыг үзнэ үү.
4. М.Дэвид Радд болон бусад хүн, "Warning Signs for Suicide: Theory, Research, and Clinical Applications," *Suicide and Life-Threatening Behavior,* 36-р боть, № 3 (2006), 255–262.
5. М.Рассэлл Баллард, "Sitting on the Bench: Thoughts on Suicide Prevention" (видео бичлэг), lds.org/media-library.
6. Дэйл Г.Рэнланд, "Бурханы мэлмийгээр харах нь," *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 82.
7. Жон Р.Жордан, "Is Suicide Bereavement Different? A Reassessment of the Literature," *Suicide and Life-Threatening Behavior,* 31-р боть, № 1 (2001), 91–102-ыг үзнэ үү.
8. М.Рассэлл Баллард, "Suicide: Some Things We Know, and Some We Do Not," *Ensign,* 1987 оны 10-р сар, 8.
9. Даллин Х.Өүкс, "Есүс Христийн Цагаатгалаар хүчирхэгжсэн," *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 50.

САНАЛ БОЛГОХ МАТЕРИАЛ

Жэффри Р.Холланд, "Эвдэрсэн сав шиг," *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 40–42.

Дийтр Ф.Угдорф, "Бурханы гэрлийн найдвар," *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 84–87.

Шэйн М.Бөүэн, "Яагаад гэвэл би амьд байна. Та нар ч амьд байна," *2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 17–20.

Бошиглолын суу билэгт үгсийг санаанд оромгүй газраас олсон нь

Орхисон нэгэн сэтгүүл Оскар Кастрогийн амьдралыг үүрд өөрчилжээ.

Колэтт Линдал

Энэр нь түүнийг хоёр бяцхан хүүхэдтэй нь орхиж явсан тэр өдөр Оскарын амьдралын хамгийн хүнд өдрүүдийн нэг байсан. Тэр олон шийдвэр гаргах хэрэгтэй байв. Тэр ажил хайж байсан бөгөөд амьдрах шинэ газар олох хэрэгтэй болжээ. Амьдрал нь сүйрсэн мэт түүнд санагдаж байв. Бууж өгмөөр санагдаж байсан бөгөөд хоёр сайхан хүүхэд нь байгаагүй бол тэгэх ч байсан байх.

Аргентины Сан Жуанд Оскарын мөнгөнд таарсан түрээсийн байр тийм ч олон байсангүй. Гэтэл нэгэн аюулгүй тайван дүүргийн жижигхэн байшинд амьдарч байсан залуучууд нүүж гарсан учраас Оскар тэр байрыг түрээсэлж, хүүхдүүдтэйгээ хамт амьдралаа шинээр эхлүүлэхээр бэлтгэв.

Шинэ гэрийнх нь шалан дээр хэд хэдэн сэтгүүл, ном хэвтэж байсан бөгөөд Оскар бүтэн өдөр цэвэрлэгээ хийж, цэгцэлсний дараа амсхийн суух зуураа сэтгүүлүүдээс нэгийг авч гарчиглажээ. Хавтас нь яагаад ч юм түүний сонирхлыг татлаа. *Лиахона* гэсэн гарчгийн доор цамхаг дээр зогсоод хүмүүстэй ярьж байгаа нэг хөгшин эрийн зураг байв. Уг хүн библийн үеийн бошиглогчдын зургийг түүнд санагдуулаа.

Оскар сэтгүүлийг нээгээд, дараах үгсийг уншив. “Бид бүгд хайрт хүмүүстээ “Хайртай шүү” гэж хэлэх хэрэгтэй гэдгээ мэддэг. Гэхдээ бид мэддэг зүйлээ тэр болгон ажил үйлсээрээ харуулдаггүй.”[1] Оскар эхнэртээ хэлж байсан болон түүнээс сонсож байсан хатуу үгсийг бодов. Тэр хүүхдүүдээ өөрсдөөсөө илүү сайн хүн болгохыг хүсдэг байлаа. Оскар сэтгүүлийг үргэлжлүүлэн уншсаар, дотор нь найдвар төрж байгааг мэдэрч эхэлжээ. Долоо хоног дуусахаас өмнө тэр өгүүлэл бүрийг уншиж, илүү ихийг мэдэхийг хүсэв.

Нэг сарын дараа Оскарын амьдардаг газар хоёр номлогч алхаж явлаа. Оскар тэдэнтэй очиж уулзаад, хожмын үеийн гэгээнтэн номлогчид мөн эсэхийг мөн Сүмийн сэтгүүлээс илүү ихийг авбал ямар үнэтэй болохыг асуужээ. Ахлагчид үүний үнэнд тэр 20 минут зарцуулахад л хангалттай гэж хэлэв.

Маргааш нь хоёр номлогч Оскарын гэрт ирлээ. Оскар нүүж ирснээ мөн хэрхэн Сүмийн талаар ойлголт өгсөн хуучин ном, сэтгүүл, товхимлуудыг олсноо тэдэнд ярив. Түүнчлэн уншсан эхний өгүүлэл нь түүний амьдралтай шууд холбоотой байсан гэдгийг тайлбарлалаа. Тэр гэр бүлийн ач холбогдлын талаар аль хэдийн мэддэг байсан бөгөөд гэр бүлийн үдэш, залбирлын талаар илүү ихийг мэдэхийг хүсжээ. Тэрээр Иосеф Смит, сайн мэдээний сэргээлт гэх мэт Сүмийн тухай өөр юу мэдэж авснаа ахлагчдад ярив.

Тэрээр ахлагчдын нүд рүү эгцлэн ширтээд, номлогч бүрийн сонсохыг хүсдэг “Би Иосеф Смит Бурханы бошиглогч байсан гэдэгт итгэдэг” гэсэн үгсийг хэлэв. Ахлагчид түүнээс баптисм хүртэхийг урихад Оскар

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАН БООР; ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЭОХИОГЧИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

нүдэндээ нулимстай зөвшөөрчээ. Хэдэн долоо хоногийн дараа Оскар Кастро баптисм хүртэж, Сүмийн гишүүнээр батлуулав.

Их Эзэн Оскарыг бэлдсэн бөгөөд тэр гэмшсэн сүнстэй байж, суралцаж, өсөж хөгжихөд бэлэн байсан юм. Байшиндаа нүүж ирсэн тэр нэгэн мартагдашгүй өдөр *Лиахона* сэтгүүлийн Ерөнхий чуулганы дугаар дээрх захиасын сүнс Оскарын зүрх сэтгэлийг хөндсөн билээ. Өмнө нь амьдарч байсан хүмүүс Сүмийн хэдэн сэтгүүл орхиж яваад, ямар нөлөө үзүүлэхийг нь мэдээгүй ч сэтгүүлүүд дээрх сайн мэдээний захиас номлогчийн чухал зэмсэг болж чаджээ. Тэдгээр сэтгүүл Оскарыг хайж байсан үнэн рүү нь хөтөлж, амьдралыг нь үүрд өөрчилсөн билээ. ■

Оскар Кастро нүүж орсон байшингаасаа Лиахона сэтгүүлийн Ерөнхий чуулганы дугаарыг олсны-хоо дараа баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан юм.

Өгүүллийн зохиогч нөхрөө номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэх хугацаанд Аргентинд амьдарч байв.

ЭШЛЭЛ

1. Дэвид А.Бэднар, "Гэр орондоо анхаарал төвлөрүүлж, санаа тавьж байх нь," *2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 18.

Далын
ахлагч
Брадли Д.Фостэр

ГЭР БҮЛИЙН ТҮҮХ: АМАР АМГАЛАН, ХАМГААЛАЛТ БА АМЛАЛТУУД

ЗУРАГ ЧИМЭГТЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЭРТ

Таныг гэр бүлээрээ бичээсүүд цуглуулж, зүрх сэтгэлийг анагаан, гэр бүлийн гишүүдийг лацдан холбох ажилд оролцох үед та өөрөө төдийгүй таны үр удам үүрд мөнх адислагдах болно.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүх нь гэр бүлүүдийн тухай түүх юм. Би *гэр бүлүүдийн* тухай ярихдаа ээж, аав, хүүхдүүд гэсэн орчин үеийн ойлголтоос өөр зүйлийн талаар ярьж байгаа юм.

Би энэ үгийг Их Эзэний хэрэглэдгээр буюу *үндэстэн* эсвэл *олон үе дамжсан гэр бүлүүд* гэсэн утгаар хэрэглэдгийн учир нь хүн бүр гэр бүлтэй билээ. Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөө хүүхдүүд нь олон үеийн өмнөх өвөг дээдсээсээ хүч чадал авч, эцэг эхчүүд үр удмаа олон үеэр нь адислахыг эрэлхийлдэг гэр бүл дээр төвлөрдөг.

Энэ утгаараа Мормоны Ном ч гэсэн гэр бүлүүдийн түүхийг өгүүлдэг. Бид эдгээр түүхийг уншиж байхдаа гэр бүлүүд олон зууны туршид тийм ч их өөрчлөгдөөгүй гэдгийг ойлгож авдаг. Тэр ч байтугай өөр цаг үе, газарт амьдарч байсан хүмүүс бидэнтэй олон талаараа адил байдаг бөгөөд хүүхдүүдээ аз жаргалтай, мөнхийн гэр бүлд амьдраасай гэсэн Бурханы хүсэл ч гэсэн өөрчлөгдөөгүй хэвээр.

Яагаад Их Эзэн эдгээр түүхийн цэдгийг хадгалан үлдээсэн бэ? Тэрээр биднийг цэдгүүдээс юу сураасай гэж хүссэн бэ? Тэдгээр нь гэр бүлүүдээ цуглуулан, анагааж, лацдан холбоход гаргах хичээл зүтгэлд маань туслах сургамжийг агуулдаг уу?

Лихайгаас авах сургамж

Мормоны Номын анхны гэр бүл болох Лихайн гэр бүл бидэнд анзааралгүй орхигдуулсан байж болох нэгэн чухал сургамжийг үлдээсэн гэдэгт би итгэдэг. Лихайн гэр бүл бидэнд гэр бүлийн цэдгийн талаар асар их зүйлийг, тэр дотроо яагаад тэдгээр нь Их Эзэнд чухал болох мөн яагаад бидэнд чухал байх ёстой гэдгийг зааж өгдөг.

Түүхийн эхэнд Лихай, Сариа хоёр охин, дөрвөн хүүгээ Иерусалимд өсгөж, энэ агуу хотод тав тухтай амьдарч байгаагаар гардаг. Их Эзэнийг Лихайд гэр бүлээ аглаг буйд руу авч явахыг

зарлиглах үед тэдний амьдрал үүрд өөрчлөгдсөн.

Лихай дуулгавартай байж, гэр бүлийнхээ хамт материаллаг эд баялгаа орхин, аглаг буйд руу аялдаг. Хэсэг хугацаанд аялсны дараа Лихай хүү Нифайдаа хандан,

"Болгоогтун чамайг болон ах нарыг чинь Иерусалимд *буцахыг* Их Эзэн надад зарлиг болгосон нэг зүүдийг би зүүдлэв.

Учрыг болгоогтун, иудейчүүдийн цэдэг мөн түүнчлэн миний эцэг өвгөдийн угийн бичиг Лебенд буй бөгөөд тэдгээр нь гуулин ялтсууд дээр сийлбэрлэгдсэн ажгуу" хэмээн хэлсэн (1 Нифай 3:2–3; онцлон бичилт нэмэв).

Энэ зарлиг байсан учраас бидний гэр бүлүүд Нифайн хэлсэн дараах итгэл, дуулгавартай байдлын агуу тунхгаар адислагдсан билээ. "Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно" (1 Нифай 3:7).

Гуулин ялтсууд бол цэдэг байсан. Тэдгээр нь судраас гадна Лихайн гэр бүлийн түүхийг агуулж байв. Уг цэдгийг хожмын олон үед зориулан хадгалах нь ямар чухал болохыг Их Эзэн мэдэж байсан.

Та нар Их Эзэн яагаад Лихайг биш, хөвгүүдийг нь цэдгүүдийн араас явахыг зарлигласан юм бол гэж бодож байсан уу? Тэрээр гэр бүлийнхээ патриарх нь байсан юм. Их Эзэн *түүнд* үзэгдэл өгсөн. Лихай Лебенд хөвгүүдээсээ илүү нөлөөлж чадах байсан юм биш үү?

Яагаад Их Эзэн Лихайн хөвгүүдэд Иерусалим руу буцахыг зарлигласныг бид мэдэхгүй боловч тэднийг Их Эзэний хүссэн зүйлийг гүйцэлдүүлэхийн тулд бэрхшээл амссан гэдгийг мэднэ. Уг даалгавар хүнд байсан бөгөөд итгэлийг нь сорьсон юм. Тэд аглаг буйдад хийх аяллынх нь турш тус болох үнэт сургамжийг хүлээн авсан. Магадгүй хамгийн чухал нь тэд Их Эзэн зарлиг өгөхдөө арга замыг нь үнэхээр зэхэж өгдөг гэдгийг ойлгож авсан байж болох юм.

Хөвгүүд, охидоос маань гэр бүлийн цэдгүүдээ авахаар "буцах" үедээ юуг сурч аваасай хэмээн Их Эзэн хүсдэг вэ гэж бид өөрсдөөсөө асууж болно. Тэрээр хэрхэн тэдэнд арга замыг бэлтгэж өгч байна вэ? Түүнд хүүхдүүдэд маань өгөхийг хүсэж байгаа туршлага байна уу? Бид тэднийг энэ туршлагыг олж авахад урьж байна уу? Бурхан таны охид, хөвгүүдэд ариун сүм болон гэр бүлийн түүхийн үйлчлэлээр дамжуулан ямар адислалууд өгөхийг хүсэж байгаа вэ?

Их Эзэн Лихайн гэр бүлд эдгээр цэдэг байгаасай гэж хүссэн. Уг цэдэг нь түүний үр удамд удам угсааных нь талаар мэдээлэл өгсөн.

Нифайг болон түүний ах нарыг эцгийнхээ майханд эргэж ирэх үед Лихай "гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэрхүү цэдгийг авч, мөн тэрбээр тэдгээрийг эхнээс нь судалсан авай." Тэрээр тэндээс "Мосегийн таван ном," "ариун бошиглогчдын бошиглолууд," "эцэг өвгөдийнхөө угийн бичгийг олов; иймийн тул тэрээр Иосефын удам байсныг мэдсэн ажээ; . . . Египетэд худалдагдсан [түүний]" гэдгийг мэдэж авчээ. Мөн Лихай "эдгээр бүх зүйлийг хараад, тэрээр Сүнсээр дүүргэгдэв" (1 Нифай 5:10, 11, 13, 14, 17).

Дараа нь Лихай гуулин ялтсуудаас мэдэж авсан зүйлээ гэр бүлдээ заажээ. Түүний майхан гэр бүлийн түүх, сургалтын төв болсон гэж хэлж болох юм. Бидний гэр орон ч гэсэн тийм газар болох ёстой.

Яагаад Их Эзэн Лихайн гэр бүлд эдгээр цэдэг байгаасай хэмээн хүссэнийг ойлгоход амархан. Уг цэдэг үр удамд нь удам угсааных нь тухай мэдлэгийг өгч, тэднийг өнгөрсөн үеийн итгэлтэй патриархуудтай холбож, "эцгүүдэд нь хийсэн амлалтуудыг" зүрх сэтгэлд нь суулгасан юм (С ба Г 2:2; Иосеф Смит—Түүх 1:39). Эдгээр цэдэг нь төрөөгүй үеийнхний итгэлд маш чухал байсан учраас үүнгүйгээр бүхэл бүтэн "үндэстэн итгэлгүйдээ бууран доройтох болно" (1 Нифай 4:13) гэдгийг Сүнс Нифайд анхааруулсан.

Мормоны Номон дээрх өөр хүмүүсийн туршлага цэдгүүд алдагдвал үнэн алдагдаж, хойч үеийнхэнд үзүүлэх нөлөө нь хөнөөлтэй гэдэг нь ямар үнэн болохыг харуулдаг.

Мюлекчүүд Лихайн гэр бүлтэй ойролцоо цаг үед Иерусалимаас гарсан. Лихайн гэр бүлээс ялгаатай нь, "тэд өөрсөдтэйгөө цэдгүүдийг авчирсан нь үгүй" байв. Мозая тэднийг 400 орчим жилийн дараа олох үед "тэдний хэл гуйвуулагджээ; . . . мөн тэд өөрсдийг нь Бүтээгч байдгийг үгүйсгэсэн бөлгөө" (Омнай 1:17). Тэд гэрээт хүмүүс гэсэн гарал сурвалжаа мартсан байв.

Мозая мюлекчүүдэд өөрийн хэлийг заасан бөгөөд ингэснээр тэд түүнд байсан цэдгүүдээс суралцаж чаджээ. Үүний үр дүнд мюлекчүүд эмх замбараагүй, бурхангүй нийгмээс өөрсдөд нь болон гэр бүлүүдэд нь

зориулсан Бурханы төлөвлөгөөг ойлгодог үндэстэн болсон юм.

Гэр бүлтэйгээ хамт эргэж ир

Бурхантай болон бие биетэйгээ харилцах харилцааны хувьд хэн гэдгээ ойлгох нь бидний бодож, үйлдэх, бусадтай харьцах байдлыг өөрчилдөг. Цэдгүүд нь бидний гарал сурвалж, хэтийн төлөвийн амин чухал хэсэг мөн. Эргэж харах нь биднийг урагш явахад бэлтгэдэг.

Эцэг эхчүүд ээ, та нар гэр бүлээ "буцаж ирэхэд" урьсан уу? Гэр бүл тань цэдгүүдээсээ эсвэл нэг нэгнээсээ ямар нэг байдлаар салсан байна уу? Гэр бүлийн тань одоогийн болон өнгөрсөн үеийн хоорондын холбоо сүлбээнд ан цав гарсан уу? Танай гэр бүлийн түүхэнд ийнхүү салж сарних ямар зүйл болсон бэ? Энэ нь цагаачлал, гэр бүлийн зөрчилдөөн, сайн мэдээнд хөрвөгдөх зэргээс болсон уу эсвэл зүгээр он цагийн урсгалаар бий болсон уу? Та нар ойрд FamilySearch.org дээрээс өвөг дээдсээ хайж олохоор оролдож үзэв үү?

Израилийн угсаа тараагдсан бөгөөд үүнд бидний гэр бүл, цэдгүүдийн тараагдалт мөн адил ордог. Бидний үүрэг хариуцлага бол тэднийг цуглуулж, шаардлагатай үед салалтаас үүссэн шархыг эдгээх явдал юм. Бид хүүхдүүдийнхээ зүрхийг эцгүүд рүү нь эргүүлэхийг хичээнгүйлэн эрэлхийлэх үед бидний зүрх хүүхдүүд рүүгээ эргэж,[1] бид хамтдаа энэ ажлыг хийснээр ирдэг амар амгалан, эдгээлтийг олж авах болно (С ба Г 98:16).

Лихай ариун нандин цэдгүүдийг авчруулахаар хөвгүүдээ Иерусалим руу илгээсний адил бүгдээрээ хүүхдүүдээ гэр бүлийнхээ цэдэг рүү явуулцгаая. Их Эзэн Нифайд арга замыг нь бэлдэж өгсний адил хүүхдүүдэд маань гэр бүлүүдээ цуглуулж, эдгээх боломжийг олгох интернэт болон өөр бусад технологийг өгсөн. Түүнчлэн Тэр олсон нэрсээ аваачиж, лацдан холбох ёслолоор дамжуулан цугларалтаа баталгаажуулах ариун сүмүүдийг өгсөн билээ.

Аглаг буйд дахь баяр баясал

Миний эхнэр Шарол бид хоёр гэрлэхдээ дөрвөн хүүтэй болно гэж шийдсэн юм. Харин Их Эзэнд өөр төлөвлөгөө байв. Тэр бидэнд дөрвөн охин өгсөн.

Бид охидтойгоо хамт аглаг буйдад аялдаг байсан бөгөөд одоо тэд маань гэрлэж, үр хүүхдүүдтэй болоод, өөрсдийнхөө аглаг буйдад аялж байна. Аян замд бүх зүйл амар байсан уу? Үгүй. Бид бувтнах үедээ бувтналдаж, саад бэрхшээлтэй олонтоо учирч байсан.

Амьдралын аглаг буйд гэр бүлүүдэд амаргүй байж болно. Хүмүүсийг "Та болон таны гэр бүл сайн уу?" гэж асуухад би ихэвчлэн "Бид яг одоо асуудлаас асуудлын хооронд л явж байна даа. Асуусанд баярлалаа" гэж хэлдэг.

Гэхдээ уг зам дээр жинхэнэ баяр баяслыг ч мөн адил мэдэрдэг. Патриарх, матриархын хувьд бид хүүхдүүдээ аглаг буйдаар аялахад нь туслан хүчирхэгжүүлэхэд асар их цаг зарцуулсан. Өнөө үеийн бошиглогчид гэр бүлийн түүхийн ажил бол "чөтгөрийн нөлөөнөөс хамгаалах хамгаалалт"[2] болон "гүн ба удаан хугацаагаар" Аврагчид хөрвөгдөх явдлыг хангадаг хэмээн амласан[3]. Гэр бүлүүдээ цуглуулан, эдгээж, лацдан холбох нь юутай хүчирхэг арга зам бэ!

Би гэр бүлийнхээ патриархын хувьд охидоосоо цэдгүүдийг *олохоор* буцаж, нэрсээ ариун сүмд *аваачиж,* зээ нарт маань бас *зааж* өгөөсэй гэж хүссэн. Би тэднийг манай гэр бүлийн түүхийн ажилд оролцсоноор хэний үр удам болохоо мэдэж аваасай гэж хүссэн.

Нэгэн амлалт

Та нар хүүхдүүдээ "буцаж очин," гэр бүлийнхээ цэдгүүдийг олоход уривал хамтдаа Лихай, Сариа нарын адил "асар их баярлаж," "Израилийн Бурханд таларха[х]" болно гэдгийг би амлаж байна. Та нар цэдгүүдээ судалбал "Сүнсээр дүүргэгдэж," "тэдгээр нь хүсүүштэй болохыг олж мэдэж; агуу эрхэм чухал" гэдгийг мэдэх болно. Мөн та нар "[өөрсдийн] амлалтын нутгийг зорин аглаг буйдад зорчихдоо [та нар] эдгээрийг [өөрсөдтэйгөө] авч явах нь Их Эзэний мэргэн ухаан буйза" (1 Нифай 5:9, 17, 21–22) гэдгийг мэдэх болно.

Сүмд таны гэр бүлийг энэ аяллын тань турш дэмжиж, хүчирхэгжүүлнэ. Гэр бүл тань бичээсийг цуглуулж, зүрх сэтгэлийг анагаан, гэр бүлийн гишүүдийг лацдан холбох ажилд оролцох юм бол та болон таны үр удам үүрд мөнхөд адислагдах болно гэдгийг амлаж байна. ■

2015 оны 2-р сарын 14-нд АНУ-ын Юта мужийн Солт Лэйк хотод болсон RootsTech Гэр бүлийн түүхийн чуулганы үеэр хэлсэн "Гэр бүлүүдийг цуглуулан, эдгээж, лацдан холбох нь" гэсэн сэдэвтэй үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Гуулин ялтсууд дээрх цэдгүүд Лихайн үр удмыг хэрхэн эдгээсэн тухай жишээнүүдийг харахыг хүсвэл Алма 37:8–10-ыг үзнэ үү.
2. Ричард Г.Скотт, "Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан," *2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 113–116.
3. Дэвид А.Бэднар, "Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно," *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 28.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Хоёр төлөөлөгч гэр бүлийн түүх болон ариун сүмийн үйлчлэлд оролцдог өсвөр үеийнхэнд адислалуудыг амласан. Англи хэл дээрх видео бичлэгийг үзэхийн тулд энэ QR кодыг уншуул эсвэл lds.org/go/1016000 руу ор.

Хайр ба шунал тачаал

Жошуа Ж.Пөрки
Сүмийн сэтгүүл

Шунал тачаал.

Энэ бол яах аргагүй муухай үг. Бидний ихэнх нь үүний талаар судлах нь бүү хэл бодохыг ч хүсдэггүй. Уг үг нь таагүй, ямар нэг харанхуй, толгой эргүүлэм байдаг ч буруу гэсэн мэдрэмж төрүүлдэг.

Ийм мэдрэмж төрүүлдэг нэг шалтгаан бий. Хэрэв "мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн" (1 Тимот 6:10) юм бол шунал тачаал үүний нууц хамсаатан гэдэг нь тодорхой. Энэ нь ичгүүр сонжуургүй, бохир зүйл юм. Шунал тачаал нь хүмүүсийг болон эд зүйлсийг, тэр ч бүү хэл үзэл санааг ч гэсэн хүслээ хангахын тулд өмчилж эсвэл авч болдог зүйл болгон хувиргадаг. Бид энэ юу болохыг аль хэдийн мэддэг юм бол яагаад энэ талаар илүү их зүйл мэдэх хэрэгтэй вэ?

Учир нь хэрэв бид шунал тачаал гэдэг нь яг юу гэсэн үг болохыг илүү сайн ойлговол үүнээс зайлсхийж, илрэх үед нь ялан дийлэхийн тулд бодол, мэдрэмж, үйлдлээ хэрхэн өөрчлөхийг мэдэж авч чадна. Энэ нь бидний бодол, хүслийг ариусгаж, хүчирхэгжүүлдэг Ариун Сүнсний нөхөрлөлтэй илүү ойртуулах болно. Энэ нь илүү аз жаргалтай, амар амгалан, баяр баясгалантай амьдрал руу хөтлөх болно.

Шунал тачаалыг тодорхойлох

Бид шунал тачаал гэдгийг өөр хүнд бие махбодоороо зохимжгүй байдлаар хүчтэй татагдах мэдрэмж гэж боддог боловч мөнгө төгрөг, өмч хөрөнгө, эд зүйлс, мэдээж бусад хүн гэх мэт бараг ямар ч зүйлийн араас тачаадаж эсвэл шунах боломжтой (Судруудын удирдамж, "Шунал тачаал"-ыг үзнэ үү).

Хэрэв бид шунал тачаал гэж яг юу болохыг илүү сайн ойлгож чадвал хэрхэн үүнээс зайлсхийх талаар суралцаж, Ариун Сүнстэй илүү ойр байлгах зүйлийг сонгож чадна.

ХАЙР, ШУНАЛ ТАЧААЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Хайр өргөмжилдөг бол шунал тачаал доройтуулдаг. Хайр үнэнийг хүлээн авдаг бол шунал тачаал худал хуурмагийг хүлээн авдаг. Хайр бүтээн цогцлоож, хүчирхэгжүүлдэг бол шунал тачаал устгаж, сулруулдаг. Хайр нийцтэй байдаг бол шунал тачаал эе эвгүй байдаг. Хайр амар амгаланг авчирдаг бол шунал тачаал зөрчилдөөн авчирдаг. Хайр сэтгэл сэргээдэг бол шунал тачаал мохоодог. Хайр эдгээдэг бол шунал тачаал зэрэмдэглэдэг. Хайр эрч хүч өгдөг бол шунал тачаал дүрсхийлгэдэг. Хайр гэрэлтүүлдэг бол шунал тачаал харанхуйлуулдаг. Хайр тэтгэж, дэмждэг бол шунал тачаал ханаж цадахгүй болгодог. Хайр амлалттай нягт холбоотой байдаг бол шунал тачаал бардам занг дагаж байдаг.

Шунал тачаал нь хүнийг Бурханы хүслийн эсрэг ямар нэг зүйлийг олж авахыг эрэлхийлэхэд хүргэдэг. Үүнд хувь хүнийг Бурханы зарлигуудыг сахихын оронд хувийн сонирхол, хүсэл, дур тачаал, дуршил гэх мэт дэлхийн эд зүйл, амин хувиа бодсон үйлдлүүд дээр анхаарлаа төвлөрүүлэхэд нөлөөлдөг бүхий л мэдрэмж эсвэл хүсэл ордог.

Өөрөөр хэлбэл, Бурханы хүслийн эсрэг зүйлийг хүсэмжлэх эсвэл Бурханы хүслийн эсрэг арга замаар эд зүйлсийг эзэмших гэж хүсэх нь шунал тачаал бөгөөд энэ нь аз жаргалгүй байдал руу хөтөлдөг.[1]

Бэлгийн харьцааны шунал тачаалын аюул

Хэдийгээр шунал тачаал нь ерөнхийдөө шуналын нэг хэлбэр гэдгийг бидэнд анхааруулсан ч гэсэн бэлгийн харьцааны хүрээнд энэ нь бүр ч аюултай. Аврагч: “Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” (Матай 5:28) хэмээн анхааруулсан.

Эртний төлөөлөгчид үүнтэй холбоотой шунал тачаалын талаар олон сэрэмжлүүлэг өгсөн. Жишээлбэл, төлөөлөгч Иохан “Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм” (1 Иохан 2:16; мөн 17-р шүлэг; Ром 13:14; 1 Петр 2:11-ийг үзнэ үү) хэмээн хэлжээ.

Сэрэмжлүүлэг өнөөдөр ч ирсээр байна.[2] Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Энэ яагаад ийм аюултай нүгэл вэ? Энэ нь Ариун Сүнсийг биднээс холдуулснаар оюун санааг маань мөхөөдгийн хамт мөнх бус энэ амьдралд Бурханаас бидэнд өгсөн хамгийн эрхэм, ариун нандин харилцааг бузарладаг нүгэл мөн гэж би боддог. Энэ харилцаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биеэ хайрлах хайр, үүрд мөнх байх гэр бүлдээ үр хүүхэдтэй байх хүсэл юм”[3] хэмээн тайлбарласан.

Шунал хүслээ тээх нь олон нүгэлт үйлдлийн үндэс болсоор ирсэн юм. Гэм зэмгүй мэт харц нь аймшигт үр дагавар бүхий завхайралд хүргэж болно. Яагаад гэвэл шунал тачаал нь Ариун Сүнсийг холдуулж, биднийг чөтгөрийн бусад уруу таталт, заль мэх, урхинд өртөмтгий болгодог.

Хаан Давидын эмгэнэлт сонголт энэ мэдрэмж хэчнээн хүчирхэг, аюултай байж болохыг харуулсан гунигт жишээ юм. Давид Батшибаг биеэ угааж байхад нь хараад тачаадсан. Шунал тачаал нь үйлдэл хийхэд хүргэн, тэр түүнийг авчруулан, түүнтэй унтдаг. Тэгээд нүглээ нуух гэж Давид Батшибагийн нөхрийг тулаанд баттай алуулах газар байрлуулах зарлиг өгдөг (2 Самуел 11-ийг үзнэ үү). Үүний үр дүнд Давид өргөмжлөлөө алдсан (С ба Г 132:38–39-ийг үзнэ үү).

Давидын нөхцөл байдал туйлширсан мэт санагдаж болох ч шунал тачаал бол хүчтэй уруу таталт мөн гэсэн гол санааг баталж өгдөг. Үүнд бууж өгөх юм бол биднийг эрүүл ухаантай хүний хэзээ ч хийхгүй зүйлийг хийхэд хүргэнэ. Энэ нь далдуур, амархан өдөөгддөг, биднийг Ариун Сүнснээс холдуулах үр нөлөөтэй байхаас гадна хориотой зүйлийг хийхийн тулд дур хүсэлдээ бууж өгөхөд хүргэдэг учраас бүр ч аюултай зүйл юм. Энэ нь порнограф үзэх, ёс бус үгтэй дуу сонсох, зохисгүй дотно харилцаанд ороход өдөөдөг. Үүний зэрэгцээ шунал тачаалын мэдрэмж нь хувь хүнийг

Шунал тачаалд хувь хүнийг Бурханы зарлигуудыг сахихын оронд хувийн сонирхол, хүсэл, дур тачаал, дуршил гэх мэт дэлхийн эд зүйлс, амин хувиа бодсон үйлдлүүд дээр анхаарлаа төвлөрүүлэхэд нөлөөлдөг бүхий л мэдрэмж, хүсэл ордог.

порнографыг эрэлхийлэхэд нөлөөлж болно. Энэхүү гинжин хэлхээ мэт харилцаа нь асар хүчтэй бөгөөд аюултай.[4]

Бэлгийн харьцааны шунал тачаал нь бүх харилцааг дордуулж, сулруулдаг бөгөөд үүний дотор Бурхантай харилцах хувийн харилцаа ч гэсэн ордог. "Мөн би өмнө нь хэлсэнчлэн, үнэнээр би та нарт хэлнэ, эмэгтэй хүнийг тачаангуйгаар харах тэрээр, эсвэс хэрэв хэн нэг нь зүрх сэтгэлдээ садар самууныг үйлдэх аваас, тэдэнд Сүнс байх нь үгүй, харин тэд итгэлийг үгүйсгэж мөн эмээх болно" (С ба Г 63:16).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт (1928–2015) "Бэлгийн харьцааны ёс суртахуунгүй байдал нь Ариун Сүнсний хамаг өөдрөг, гэгээлэг, хүчирхэг байдлын нөлөөнд саад болдог. Энэ нь бие болон сэтгэл санааг асар их өдөөж өгдөг. Барагдашгүй дур хүсэл зөрчил гаргагчийг улам ноцтой нүгэл үйлдэхэд хүргэдэг"[5] хэмээн заажээ.

Шунал тачаал гэж юуг хэлдэггүй вэ?

Шунал тачаал гэж юу *болохыг* тодорхойлохын зэрэгцээ ямар зүйл шунал тачаал *биш* болохыг ойлгох нь мөн адил чухал бөгөөд зохистой бодол, мэдрэмж, хүслийг шунал тачаал гэж андуурахгүй байхад анхаарах хэрэгтэй. Шунал тачаал бол нэг *төрлийн* хүсэл боловч зөв шударга хүсэл гэж бас байдаг. Жишээлбэл, бид Их Эзэний ажлыг хийхэд туслах сайн, зохистой зүйлсийг хүсэж болно.

Бодоод үз дээ.

- **Мөнгөтэй болох хүсэл.** Мөнгөтэй болохыг хүсэх нь өөрөө муу зүйл биш юм. Паул *мөнгө* бол бүх төрлийн бузар муугийн үндэс гэж хэлээгүй. Тэр *"мөнгөний хайр* бол бүх төрлийн бузар муугийн үндэс" гэж хэлсэн (1 Тимот 6:10; онцлон бичилт нэмэв). Иаковын заасан зүйлс дараах нэмэлт тодруулга өгдөг. "Харин та нар баялгуудыг эрэлхийлэхийн өмнө, Бурханы хаант улсыг эрэлхийлэгтүн та нар. Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо дараа хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас, та нар баялгуудыг олох болно; мөн та нар тэдгээрийг сайныг үйлдэх зорилгын төлөө эрэлхийлэх болно—нүцгэнийг хувцаслахад, мөн өлссөнийг хооллоход, бас боолчлогдсоныг чөлөөлөхөд, мөн өвдсөн бас зовсныг халамжлахад буюу" (Иаков 2:18–19).
- **Эхнэртээ эсвэл нөхөртөө зүй ёсны дур хүсэл бүхий мэдрэмжтэй байх.** Бурханаас заяагдсан тэдгээр мэдрэмж нь гэрлэлтийг хүчирхэгжүүлэн, бэхжүүлж, нэгдмэл болгоход тусалдаг. Гэхдээ эхнэртээ эсвэл нөхөртөө зохисгүй мэдрэмжтэй байх тохиолдол бас *бий*. Хэрэв бид зөвхөн

Тэнгэрлэг Эцэг бидэнд сонгох эрхийг өгсөн учраас бид бодол, мэдрэмж, үйлдлээ хянах чадвартай.

> өөрсдийнхөө хүслийг гүйцэлдүүлэхийг эсвэл өөрийнхөө хүсэл, мэдрэмжийг л хангахыг эрэлхийлбэл шунал тачаал болох бөгөөд энэ нь гэрлэлтийн харилцаанд хор хөнөөлтэй байж мэднэ. Гэрлэлтэд бие махбодын зохистой дотно харилцааг эрэлхийлж, хадгалж авч үлдэх түлхүүр нь цэвэр ариун, хайрлах хүсэл юм.

Аливаа зүйлийг зөв учир шалтгаанаар буюу Бурханы хаант улсыг байгуулж, дэлхий дээр сайн сайхан зүйлийг өсгөн нэмэгдүүлэхийн төлөө эрэлхийлэх нь хамгийн чухал зарчим мөн. Харин шунал тачаал биднийг зохистой хэм хэмжээний хүрээнээс халин, хүсэл маань Бурханыг гутаан доромжилж, хүмүүсийг эд зүйл болгон харж, эд зүйлс, хөрөнгө мөнгө, эрх мэдлийг хүртэл мэдрэх чадварыг маань гуйвуулан, харилцааг маань сэвтүүлэх хэмжээнд очиход хүргэдэг.

Яагаад бид ихэвчлэн шунал тачаалд бууж өгдөг вэ

Шунал тачаал хэчнээн хор хөнөөлтэй, аюултай гэдэг нь илэрхий ч, яагаад энэ нь тийм дур татам, давамгайлах чадвартай байдаг вэ? Яагаад бид ихэнх тохиолдолд үүнд ялагддаг вэ? Өнгөцхөн харахад хувиа хичээх зан эсвэл биеэ барих чадвар дутагдах нь шунал тачаалд хүргэдэг гэж харагдаж болох юм. Тэдгээр нь үүнд нөлөөлдөг хүчин зүйл мөн боловч шунал тачаалын үндэс нь ихэвчлэн хоосрол байдаг. Хувь хүмүүс амьдралд нь буй хоосон зайгаа нөхөх гэж шунал тачаалд автдаг. Шунал тачаал бол хуурамч сэтгэл хөдлөл бөгөөд жинхэнэ хайр, жинхэнэ үнэ цэн, үнэнч шавь байх явдлыг орлож чадахгүй.

Сэтгэл хөдлөлөө зохих ёсоор хянах гэдэг нь нэг үгээр бол зүрх сэтгэлийн төлөв байдлыг хэлнэ. “Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм” (Сургаалт үгс 23:7). Бид оюун санаа, сүнслэг мэдрэмжээ юун дээр төвлөрүүлнэ, тэр нь аажимдаа бодол, мэдрэмж, үйлдлийг маань хөдөлгөгч хүч болох юм. Тиймээс бид шунал тачаалд уруу татагдаж байгаагаа мэдрэх болгондоо уг уруу таталтыг илүү зохистой ямар нэг зүйлээр орлуулах хэрэгтэй.

Залхуурал тачаангуй бодлыг төрүүлдэг. Амьдралд хийх зүйл маш бага байгаа үед бид муу нөлөөнд автагдах нь илүү амархан байдаг. Бид сайн үйлсэд санаа сэтгэлээ бүрэн зориулж (С ба Г 58:27-г үзнэ үү), цагаа үр дүнтэй ашиглавал тачаангуй бодолд эсвэл бусад сөрөг нөлөөнд автах нь багасна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс гүйцэлдүүлэхийг хүсдэг хүсэл маань бидний үйлдэлд нөлөөлөөд зогсохгүй аажимдаа бидний хэн болоход нөлөөлдөг буюу “Хүсэл нь бидний эн тэргүүнд тавих зүйлийг, эн тэргүүний зүйл нь сонголтыг, сонголт нь бидний үйлдлийг тодорхойлдог. Бид ямар хүслээр үйлдэнэ, энэ нь бид хэрхэн өөрчлөгдөж, юунд хүрэх болон ямар хүмүүс болохыг тодорхойлдог”[6] хэмээн тайлбарлажээ.

Өөрөөр хэлбэл, бид ямар сэтгэл хөдлөлд автаж байгаагаа хянахын зэрэгцээ эдгээрийг үүсгэж эсвэл өдөөж байгаа бодлоо ч бас хянаж байх ёстой. Алмагийн заасанчлан бодол санаа маань бохир байвал "бодлууд маань ч биднийг буруутгах болно" (Алма 12:14).

Ерөндөг нь Христийнхтэй адил хайр юм

Шунал тачаал бол зайлшгүй байх ёстой зүйл биш. Тэнгэрлэг Эцэг бидэнд сонгох эрхийг өгсөн учраас бид бодол, мэдрэмж, үйлдлээ хянах чадвартай. Бид тачаангуй бодол, мэдрэмжийн араас хөөцөлдөх шаардлагагүй. Уруу татагдах мөчид бид тэдгээрийг дагахгүй байх сонголтыг хийж чадна.

Бид шунал тачаалын уруу таталтыг хэрхэн даван гарах вэ? Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ зохих ёсны харилцааг үүсгэж, бусдад үйлчлэхийг сонгох замаар эхэлж болно. Түүнээс гадна бид өдөр бүр амьдралд маань Ариун Сүнсийг урьдаг залбирах, судраас суралцах гэх мэт шүтлэг бишрэлтэй холбоотой зан үйлийг хийж байна. Эцсийн дүнд нууц жор нь Бурханы хаант улсыг байгуулж, Түүний алдар суугийн төлөө бүхнээ зориулах хүсэлтэй, цэвэр ариун, жинхэнэ, үнэнч хайр буюу Христийнхтэй адил хайр юм. Бид энэ хайрыг зөвхөн Ариун Сүнстэй хамт байгаа үед л мэдрэх боломжтой.

Шунал тачаалыг үгүй болгохын тулд бид Бурханд хандан тэрхүү мэдрэмжийг зайлуулж, оронд нь энэрэнгүй хайрыг өгөхийг хүсэн, чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй (Моронай 7:48-ыг үзнэ үү). Үүнийг бүх наманчлалын адил Есүс Христийн Цагаатгалын ач ивээлээр хийх боломжтой.[7] Ингэснээр бид Аврагч болон Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг шиг хайрлаж сурах боломжтой.

Бид Тэнгэрлэг Эцэг дээр анхаарлаа үргэлж төвлөрүүлэн, Бурханыг хайрлах мөн хөршөө өөрийн адил хайрлах (Матай 22:36–39-ийг үзнэ үү) гэсэн эхний бөгөөд хоёр дахь агуу зарлигуудын дагуу амьдарч, Түүний заасны дагуу амьдрахын тулд чадах бүхнээ хийвэл цэвэр ариун, үнэн зөв хүслүүд амьдралд маань улам илүү хүчтэй нөлөөлөх болно. Бид хүслээ Эцэгийн хүсэлтэй нэгтгэх үед уруу таталт, шунал тачаалын нөлөөлөл буурч, тэд Христийн цэвэр хайраар солигдох болно. Үүний дараа бид энэ дэлхийн дорд хүслүүдээр биш Бурханы хаант улсыг байгуулах хүслээр дүүргэгдэх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Даллин Х.Өүкс, "Joy and Mercy," *Ensign,* 1991 оны 11-р сар, 75; мөн Томас С.Монсон, "Finishers Wanted," *Ensign,* 1972 оны 7-р сар, 69-ийг үзнэ үү.
2. Цөөн жишээ харахыг хүсвэл Сургаал ба Гэрээ 88:121; Спэнсэр В.Кимбалл, "President Kimball Speaks Out on Morality," *Ensign,* 1980 оны 11-р сар, 94–98; Нийл А.Максвэлл, "The Seventh Commandment: A Shield," *Ensign,* 2001 оны 11-р сар, 78–80; Рассэлл М.Нэлсон, "Where Is Wisdom?" *Ensign,* 1992 оны 11-р сар, 6–8-ыг үзнэ үү. Шунал тачаалын эсрэг судрууд дээр цэдэглэгдсэн илүү олон сэрэмжлүүлгийг уншихыг хүсвэл Судруудын удирдамж дээрх дараах сэдвийг үзнэ үү. Үүнд: Гэр бүлээс гадуурх харилцаа; Зуурдын; Ариун явдал; Шунах; Бэлгийн харьцааны нүгэл; Ижил хүйстэндээ татагдах; Шунал тачаал; Тачаангуй; Бэлгийн харьцааны ёс бус байдал.
3. Жэффри Р.Холланд, "Бодгальд минь дайсанд өгөх зай үгүй," *2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 51–54.
4. Энэ сэдвээр нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Даллин Х.Өүкс, "Порнографын урхинаас мултрах нь," *Лиахона,* 2015 оны 10-р сар, 50-ийг үзнэ үү.
5. Ричард Г.Скотт, "Making the Right Choices," *Ensign,* 1994 оны 11-р сар, 38.
6. Даллин Х.Өүкс, "Хүсэл," *2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 42.
7. Жишээлбэл, Д.Тодд Кристоффэрсон, "Наманчлалын бурханлаг бэлэг," *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган,*

ЦЭВЭР АРИУН АМЬДРАХАД ТУСЛАХ ТАВАН ЗӨВЛӨГӨӨ

Ахлагч Жэффри Р.Холланд цэвэр ариун амьдралыг хэрхэн бий болгож, хадгалах талаар таван зөвлөгөө өгсөн.

1. Та нарыг хорлох хүмүүс, материал, орчноос өөрсдийгөө хол хөндий байлга.
2. Тусламж эрэлхийл.
3. Муу нөлөөг арилгахын тулд өөрийгөө хянах чадварыг хөгжүүлж мөн ашигла.
4. Ёс журамгүй бодлоо найдварын төсөөлөл, аз жаргалтай дурсамжаар соль.
5. Ариун Сүнсийг эрэлхийлж, Их Эзэний Сүнс байдаг газарт бай.

"Бодгальд минь дайсанд өгөх зай үгүй," *2010 оны 4-р сарын чуулган,* 51–54.

Алс тэртээх Йорданд

ҮЙЛЧИЛСЭН НЬ

Их Эзэний дуудсан, бидний хэрэгцээ байгаа хаана ч гэсэн

Р.Вал Жонсон, Рэйчэл Колман
Сүмийн сэтгүүл, хэвлэлийн алба

Хэрэгцээ шаардлага асар их байв. 2013 оны эхээр Ойрх Дорнодын улс Йордан дахь Затари нэртэй дүрвэгчдийн хуаранд улаан бурхан өвчний таван тохиолдол илэрчээ. Битүү чихцэлдсэн нөхцөлд амьдарч байсан 100 000 гаруй Сирийн дүрвэгчид энэ халдвартай, аюултай вирусээр өвчлөх аюул нүүрлээд байв. Йорданы засгийн газар өвчний тархалтыг зогсоохын тулд өргөн хүрээний дархлаажуулалтын аян хийхээр төлөвлөжээ. Төлөвлөгөө ёсоор 6 сартайгаас 30 хүртэлх насны 90 000 Сирийн дүрвэгчийг хоёр долоо хоногийн дотор дархлаажуулах байлаа.

Гэвч нэг асуудал гарч ирэв. Эм тариа нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Санд (UNICEF), эмнэлгүүд нь Йорданы Эрүүл Мэндийн Яамны мэдэлд байв. Харин тэдэнд тариурын зүү, хурц багаж зэмсэг хийх сав, эм тариа хадгалах хөргөгч зэрэг хүйтнээр хадгалахад шаардлагатай зүйлүүд байгаагүй бөгөөд хугацаа маш давчуу байлаа.[1]

Яг тэр үед Рон болон Сэнди Хаммонд гэх халамжийн хоёр ахмад номлогч ХҮГ энэрлийн байгууллагын орон нутаг хариуцсан захирлаар үйлчлэхээр Йорданд иржээ. Рон, Сэнди хоёр НҮБ-ын Хүүхдийн сан ба Эрүүл Мэндийн Яамтай аль хэдийн ажлын харилцаа холбоо тогтоосон байсан учраас ХҮГ энэрлийн байгууллага хэрхэн тусалж чадахыг тодорхойлохын тулд энэ хоёр байгууллагын хамтарсан ажилд шалавхан нэгдсэн байна.

Рон "Бид хүйтнээр хадгалах хэрэгцээт зүйлсийг худалдаж авахад ямар зардал гарахыг асуув. Тэднийг хариулахад нь бид 'ХҮГ энэрлийн байгууллага тусалж чадна

ХҮГ энэрлийн байгууллага 90 000 Сирийн дүрвэгчийг улаан бурхан өвчний эсрэг дархлаажуулахад туслав.

ЗҮҮН ТАЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ САМИР БАДРАН, UNICEF-JORDAN-ЫН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; АРЫН ЧИМЭГТЭЛ БА ЙОРДАНЫ АММАНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙГ © ISTOCK/THINKSTOCK


Амман, Йордан

байх гэж бид бодож байна' гэж хэлсэн юм. Тэд "Хэр хурдан авчирч чадах вэ? Бид түргэн хөдлөх хэрэгтэй байна!" гэлээ.

ХҮГ энэрлийн байгууллага хүйтнээр хадгалахад шаардлагатай зүйлийг худалдан авах саналыг 20 цагийн дотор батлав. Рон "Бид Эрүүл Мэндийн Яам, НҮБ-ын Хүүхдийн санд үүнийг хэлэхэд тэд ТББ (төрийн бус байгууллага) яаж ийм хурдан ажиллаж чадав аа? гэж маш их гайхсан. Дархлаажуулах аян хуваарийн дагуу явагдахын зэрэгцээ орон даяар өрнөсөн Йордан, Сирийн олон зуун мянган дүрвэгчийг вакцинжуулах аяныг эхлүүлсэн юм" гэв.

Хямралаас сэргийлж чадсан нь

Үүгээр ч зогсохгүй, НҮБ-ын Хүүхдийн сан, Йорданы Эрүүл Мэндийн Яам, ХҮГ энэрлийн байгууллагын үр дүнтэй хамтын ажиллагаа цаашид хамтран ажиллах үүд хаалгыг нээжээ.

Рон, Сэнди Хаммонд хоёр энэ чухал цаг үед Ойрх Дорнодод ирсэн нь Хаммондынхны иттэлийн мөн Сүмийн ахмад номлогчийн хөтөлбөр илчлэлтээр явагддагийн нотолгоо юм.

Номлогч хосууд хэрэгтэй байна

2012 онд Хаммондынхан Айдахогийн Рэксбург ариун сүмд ёслолын ажилтнаар үйлчилж байжээ. Рон шүдний эмчээр амжилттай ажиллаж, Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн шашны тэнхимд заадаг байв. Гэвч номлолд үйлчлэх өргөдлөө яаралтай явуул гэсэн тод томруун сүнслэг удирдамж хүлээн авснаар тэдний амар тайван амьдралын хэв маяг өөрчлөгджээ. Уг илчлэлт яг энэ цаг үед ирсэн нь тэднийг гайхшируулсан юм. Гэрлэсэн хүүхдүүд нь ажил мэргэжлээ сольж, нүүж сууж байсан бөгөөд Рон тэтгэвэрт гарах хараахан болоогүй байжээ. Гэвч Сүнс тэднийг өөр газарт хэрэгтэй байгааг мөн бүх зүйл сайхан болно гэдгийг баталсан байна.

Яг энэ үед Сүмийн төв байран дахь санваарын удирдагчид Йорданы Амманд ХҮГ энэрлийн байгууллагын захирлаар үйлчлэх зөв хосыг олохоор мацаг барин, залбирч байжээ.

Сэнди "Их Эзэн алсыг харж, бидэнд зориулсан тодорхой үүрэг даалгавраа нарийвчлан бэлтгэж байсан нь тодорхой байсан. Их Эзэнийг үйлчилдэг номлогч бүрийнхээ төлөө үүнийг хийдэг гэдгийг бид мэднэ. Ирэхээс тань өмнө Аврагч таны үйлчлэлд зориулан ажил хэргийг аль хэдийн зохицуулсан байдаг гэдгийг мэдэх нь сайхан" гэж хэлсэн юм.

Харин Рон "Эргээд харахад, бид хаана үйлчлэхээ тодорхой шийдээгүй байсандаа баярладаг. Ийм зүйлийг Их Эзэнд даатгасан нь өөр нөхцөлд хэзээ ч олж авч чадахгүй туршлагыг бидэнд өгөх боломжийг Түүнд олгосон юм" гэж хэллээ.

АМЬДРАЛЫНХАА ХАМГИЙН ГАЙХАМШИГТАЙ 6, 12, 18, 23 САРЫГ ХЭРХЭН ОЛЖ АВАХ ВЭ

Хосууд нөхцөл байдлаасаа шалтгаалан номлолд 6, 12, 18, 23 сар үйлчилж болно.

Үүнээс гадна, номлолын санхүүгийн хамгийн том зардал болох байрны зардлыг Америкийн Нэгдсэн Улс, Канад, Баруун Европ, Япон болон Австралиас үйлчилж байгаа хосуудын хувьд 1 400 ам доллараас их гарахгүй байхаар хязгаарласан нь үүнийг илүү боломжтой болгож байгаа юм. Бусад бүх улсаас үйлчилж байгаа номлогчид боломжоороо төлнө.

Номлолын үйлчлэлд өргөдөл гаргах талаар мэдээлэл аван, номлолд үйлчилж, амьдралынхаа хамгийн сайхан хугацааг өнгөрүүлсөн хосуудын түүхийг уншихыг хүсвэл lds.org/callings/missionary/senior руу орно уу.

Уг туршлагад Йорданы хааны гэр бүлийн сонирхлыг татсан олон хүмүүнлэгийн төсөл дээр хамтарч ажиллах боломж орсон байна. Хаммондынхан орон нутгийн эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, Йорданы эрүүл мэндийн салбарын ажилтнуудад нярайн сэхээн амьдруулах чадвар олгох сургалтыг явуулсан бөгөөд үүний үр дүнд нярайн эндэгдэл эрс буурчээ. ХҮГ энэрлийн байгууллага нь тэдний болон өөр номлогч хосуудын хүчин чармайлтын ачаар нүдний эмнэлэгт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг байгууллагуудад сургалт явуулж, тоног төхөөрөмж хандивлав. Хаммондынхны болон өөр халамжийн номлогчдын дэмжлэг үзүүлсэн газруудын нэг бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тусгай хувцас, гар урлалын эд зүйлсийн загварыг хэрхэн гаргаж, оёхыг заадаг нэгэн төв байсан юм. Эдгээр чадвар нь суралцагчдад өөрсдийгөө болон гэр бүлээ авч явах боломж олгожээ.

Бусад төсөлд ТББ болон Йорданы засгийн газартай хамтран онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх, жил бүр Бригам Янгийн Их Сургуульд суралцах хоёр тэтгэлгийн нэгийг хүлээн авах Йорданы оюутныг сонгон шалгаруулах ажил орсон байна. Хаммондынхны сэтгэлд хамгийн их таалагдсан туршлагын нэг бол Латин католик сүмтэй хамтран цуглах газаргүй болсон Иракийн Христийн шашинтнуудад сургуулийн өрөөнүүд барих явдал байв.

Рон, Санди Хаммонд болон хүмүүнлэгийн бусад номлогч нярайн эндэгдлийг бууруулахын тулд Йорданы хааны гэр бүлтэй хамтран ажиллав.

Их Эзэнтэй хамт Түүний усан үзмийн талбайд

Хаммондынхан Йорданд байхдаа Их Эзэний үйлчилдэг хүмүүстээ өгсөн “Би та нарын өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88) гэсэн амлалт хэчнээн үнэн болохыг мэдэж авчээ.

“Бурхан энэ ажилд гар бие оролцдог. Тэр үйлчлэгчидтэйгээ хамт талбайд хөдөлмөрлөдөг. Номлолд үйлчлэх ямар ч хос усан үзмийн талбайд Их Эзэнтэй хамтран ажилладаг билээ. Бид Йорданд гайхамшгуудад итгээгүй, харин гайхамшгууд дээр амьдардаг болохоо харж байсан” гэж Рон хэлсэн юм.

Яах аргагүй “эргэн тойронд”-оо байгааг нь мэдэрч байсан тэнгэр элчүүдэд тэнгэрлэг биесээс гадна мөнх бус хүмүүс, түүний дотор гэрээсээ хол номлолд үйлчлэх шийдвэрийг нь дэмжсэн хүүхдүүд нь багтаж байв.

Үүний хариуд тэдний гэр бүл Их Эзэний хамгаалалт, дэмжигч хүч чадлаар адислагджээ. Хүүхдүүд нь Их Эзэнд хандан, хамтдаа зөвлөлдөж, нэг нэгнийхээ төлөө залбирч, мацаг барьсны хариуд ажил, нүүдэл суудалтай холбоотой чухал шийдвэрүүдийг гаргаж, төрөхийн хүндрэлтэй холбоотой асуудлыг шийдсэн байна.

Хүүхдүүдийнх нь хүлээн авсан адислал үнэхээр гайхамшигтай байсан учраас Хаммонд ах, эгч хоёрыг хоёр жилийн номлолоо гурван жил болгож сунгахад урихад бүх хүүхэд нь баяр хөөр болон дэмжжээ. Тэдний төлөө хийсэн Их Эзэний онцгой зүйлс эцэг эхийнх нь үйлчлэлтэй шууд холбоотой гэдгийг тэд мэдэж байлаа.

Гэсэн хэдий ч Хаммондын гэр бүлийнхний хувьд нэг нэгнээсээ хол байх нь яах аргагүй золиослол байсан юм. Хайртай хүмүүсээсээ хол, дэлхийн нөгөө өнцөгт байх хэцүү. Гэхдээ энэ нь өмнөх үеийнхтэй адил хэцүү байсангүй. Технологийн тусламжтайгаар энэ гэр бүл хэрэгтэй үедээ нэг нэгнийхээ амьдралд юу болж байгааг мэдэх боломжтой байв. Сэнди “Хосууд гэр бүлийнхэнтэйгээ холбоогоо тасалдаггүй. Бид гэрт үлдсэн хүүхдүүдийнхээ гэр бүлтэй тогтмол холбоо барьдаг байсан. FaceTime, э-мэйл зэргийн ачаар биднийг үйлчилж байх үед төрсөн дөрвөн ач зээ маань биднийг мэддэг болж, эргэж ирэхэд маань халуун дотно угтаж авсан” гэв.

Нүдээ мөн зүрх сэтгэлээ нээх нь

Хаммондынхан йорданчуудын өгөөмөр, нөхөрсөг занг олж харсан нь үйлчлэлээрээ дамжуулан олж авсан

ЗҮҮН ТАЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ХҮГ ЭНЭРЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВШӨӨРЛӨӨР, БАРУУН ТАЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ХАММОНДЫНХНЫ ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙЛЭВ.

Номлолд үйлчилж болох хосуудын санааг зовоодог нэг зүйл нь хүүхдүүд, ач зээ нараасаа хол байх явдал юм. Их Эзэн үйлчилдэг хосуудын гэр бүлийг гайхалтай арга замаар адисалдаг бөгөөд тэд дэлхийн нөгөө хязгаарт байсан ч гэсэн технологийн ачаар тэдэнтэйгээ ойрхон байх боломжтой гэдгийг Хаммондынхан ойлгосон.

олон адислалынх нэг байлаа. Тэд анх дуудлагаа хүлээж авсныхаа дараа ямар хүмүүст үйлчлэх гэж байгаагаа сайн мэдэхгүй байв.

Рон "Гэхдээ мусульман найзууд маань эелдэг, өгөөмөр болохыг бид олж мэдсэн. Хэрэв бидэнд аюул тохиолдвол амиа хайрлахгүй биднийг хамгаална гэдгийг нь бид сайн мэднэ.

Тэдний энэрэл гайхалтай. Йорданчууд өөрсдийнх нь тусламж хэрэгтэй гэдгийг мэдэх юм бол туслахгүй өнгөрч чаддаггүй хүмүүс. Тэд Давидын өмнөх үеэс эхлэн дүрвэгчдийг хүлээн авсаар ирсэн. Библид 'Йорданы тэртээгээс' гэсэн үг орсон олон шүлэг байдаг бөгөөд бид эрт дээр үеэсээ энэрэнгүй байсаар ирсэн энэ улсад энэрлийн үйлчлэл үзүүлэх боломж олдсондоо талархаж, захидлуудаа 'Йорданы тэртээгээс' гэж төгсгөдөг болсон юм. Йордан олон зууны турш энэрлийн нутаг байсаар ирсэн бөгөөд үүнийх нь төлөө Их Эзэний хүмүүсийг адисалсан билээ" гэж хэлэв.

Йорданчуудтай ойр дотно ажилласан нь Хаммондынханд бат бөх нөхөрлөх боломж олгожээ. Санди "Биднийг өдөр бүрийн рамадан мацгийг тайлдаг хэд хэдэн ифтар зоогт урьсан юм. Мусульман найзууд маань биднийг бас сүй тавих найр, хурим болон гэр бүлийн өөр үйл ажиллагаануудад урьдаг байсан" гэж хэлсэн.

Сүмийн зүгээс Йорданд эсвэл хуулиар хориотой аль ч газар номлож, мусульманчуудад баптисм хүртээхийг зөвшөөрдөггүй учраас Хаммондынхан Сүмийн талаар мэдээлэл хуваалцаагүй байв. Үүний оронд тэд хааны гэр бүл, орон нутгийн хүмүүнлэгийн түншүүд, хамт үйлчилж байгаа бусад номлогч хос, шашны болон засгийн газрын удирдагчидтай харилцаагаа хөгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлдэг байжээ. Сүмийн тухай дэлгэрэнгүй мэдэхийг хүсэх үед Хаммондынхан сонирхогчдыг LDS.org сайтаар орж үзэхэд урьдаг байв.

Үйлчлэх дуудлага

Гайхалтай туршлага бүхий Рон, Сэнди хоёр үйлчлэхээр дуудагдсан эсвэл дуудагдаж болох хосуудын дотроос өөрсдийгөө ямар нэгэн байдлаар онцгой гэж боддог болов уу?

Тийм, бас үгүй. Хаммондынхан "Их Эзэнд бидэнд буй тодорхой чадвар, туршлагатай хос хэрэгтэй байсан тэр газар, тэр цаг үед бид үйлчилсэн. Гэхдээ энэ нь бүх ахмад номлогчийн хувьд үнэн юм. Үйлчлэх чадвартай бүх хос өөрсдийн хувьд онцгой арга замаар үйлчлэхэд бэлтгэгдсэн байдаг. Тэд зөвхөн Их Эзэний хүссэн газар руу явах итгэлээ хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд Тэр бусдын амьдралыг өөрчлөхийн тулд тэднийг ашиглах болно" гэж хэлсэн юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс "Хосууд өөрчлөлт хийж чадна. Хосууд хэний ч хийж чадахгүй гайхалтай зүйлийг хийж чадна. . . .

. . . Хосуудын үйлчилж болох арга замд хязгаар гэж үгүй. Номлолын оффист туслах, удирдагчдын сургалт явуулах зэргээс эхлэн гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил, хүмүүнлэгийн үйлчлэл гээд Их Эзэний та нарт өгсөн ямар ч авьяас чадварыг ашиглах боломжууд хязгааргүй. . . .

. . . Та нар амьдралдаа асар их зүйлийг хүлээн авсан учраас урагш явж, Их Эзэн Аврагчийн үйлчлэлд өгөөмрөөр үйлчил. Итгэлтэй бай. Та нар хаана хэрэгтэй байгааг Их Эзэн мэднэ. Ах эгч нар аа, хэрэгцээ асар их байгаа ч хөдөлмөрлөгчид цөөн байна"[2] хэмээн хэлсэн. ■

ЭШЛЭЛҮҮД

1. "Сири, Йордан, Ливан, Ирак, Туркт дэгдсэн улаан бурхны тархалтын үеэр хийгдсэн олон нийтийг хамарсан дархлаажуулалтын аян," 2013 оны 4-р сарын 30, unicef.org-ийг үзнэ үү.
2. Робэрт Д.Хэйлс, "Couple Missionaries: A Time to Serve," *Лиахона,* 2001 оны 7-р сар, 30, 31.

НИГҮҮЛСЭХИЙГ ГУЙСАН НЬ

Эстонд ойролцоох хот руу аялах замдаа би гуйлга гуйж суугаа нэгэн хүнийг харав. Хачирхалтай нь, энэ хүн намайг арван жилийн өмнө энэ хотод номлогчоор үйлчилж байх үед байсан тэр хүн мөн болохыг би таньсан юм. Тэр мөнгө олохоор урьд өмнөх шигээ том уут дүүрэн хуванцар сав үүрэн, тушаах гээд явж байв. Тэр үргэлж задгай мөнгө гуйдаг байсан бөгөөд мөнгө өгөх юм бол дахиад байна уу гэж гуйдаг байсныг би саналаа.

Би түүнийг хараад цочирдсон юм. Үс нь л бууралтсанаас биш тэр 10 жилийн дараа ч өөрчлөгдсөнгүй. Гэхдээ тэр өдөр бүр гуйлга гуйж амьдардаг хэвээр байв. Би түүнийг ийнхүү амьдарч байхад өнгөрүүлсэн сайхан 10 жилийнхээ талаар бодов. Би ариун сүмд гэрлэж, боловсрол эзэмшин, сайн ажилтай болж, эрүүл саруул амьдарсан байлаа.

Энэ нь сүүлчийн удаа түүнийг харах боломж байж магадгүй гэж би бодоод, түүнд ямар нэг юм өгөх хэрэгтэй юм шиг санагдсан юм. Гэвч надад өгье гэж бодсоноос минь том, ганцхан мөнгөн дэвсгэрт байлаа. Би түүнд юу ч өгөхгүй байх уу эсвэл хүссэнээсээ илүү ихийг өгөх үү гэдгийн алийг нь сонгохоо мэдэхгүй байв. Энэ мөнгө миний хувьд их биш боловч түүний хувьд их мөнгө гэж бодсон учраас би мөнгөө түүнд өглөө.

Хоёр өдөр ч өнгөрөөгүй байхад би өөрөө үүнтэй адил нөхцөл байдалд орсон бөгөөд энэ удаад би нигүүлсэхийг гуйгч нэгэн болсон юм. Би маш чухал тэтгэлгийн өргөдлөө явуулах огноогоо андуурч тавьсан байв. Би өргөдлөө хоёр долоо хоногийн өмнө явуулсан гэж бодож байтал огноог дахин шалгаж үзсэнийхээ дараа нэг өдөр хоцроож явуулснаа олж мэдээд цочирдлоо.

Тэтгэлгийн мөнгөн дүн миний гуйлгачинд өгсөн мөнгөнөөс яг 100 дахин их байгааг би анзаарав. Би залбирч, э-мэйл бичиж, Тэнгэрлэг Эцэгээс болон их сургуулийн удирдлагаас нигүүлсэнгүй хандахыг гуйсан юм. Тэд өргөдлийг минь хүлээн авна, гэхдээ хоцорсон гэдгийг маань сануулаа.

Миний залбирлын хариу ирж, би тэтгэлэг авч адислагдсан бөгөөд энэ нь эхнэр бид хоёрт санхүүгийн хувьд маш их тусалсан. Хамгийн чухал нь энэ туршлага надад бид бүгдээрээ Бурханы өмнө гуйлгачид бус уу? гэсэн үнэтэй сургамжийг өгсөн юм (Мозая 4:19-ийг үзнэ үү). ■

Маттью Крандалл, Эстон улс

Эстонд ойролцоох хот руу аялах замдаа би гуйлга гуйж суугаа нэгэн хүнийг харав. Хачирхалтай нь, энэ хүн намайг 10 жилийн өмнө энэ хотод номлогчоор үйлчилж байх үед байсан тэр хүн мөн болохыг би таньсан юм.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СТАН ФЭЛЛОВС

НОЁН ДАНН, ХАТАГТАЙ ДАНН ХЭМЭЭХ ТЭНГЭР ЭЛЧҮҮД

Намайг зурагт үзэж байхад ээж маань утасдаад, өөрийнх нь 92 настай ах буюу миний нагац ах Флоид, эхнэр нагац эгч Миллитэйгээ ханиад хүрч, гэрт нь ямар ч хоол унд байхгүй байгааг хэлсэн юм. Аль аль нь дэлгүүр орж, юм авч чадахгүй байв. Нагац ах Флоид, нагац эгч Милли хоёрын ойр хавьд гэр бүлийн гишүүдээс нь байхгүй болохоор тэдэнд туслах хэн ч байсангүй.

Ээж минь надаас тусалж чадах эсэхийг асуув. Би тэр хавьд байгаа гэр бүлийнхэн дундаа цорын ганц Сүмийн гишүүн бөгөөд өмнө нь иймэрхүү нөхцөл байдал үүсэхэд намайг дуудаж байв. Би АНУ-ын Ютад, харин нагац маань АНУ-ын Калифорни мужийн Херметэд амьдардаг байсанд л асуудал нь байгаа юм.

Би ээжээсээ юу хийхээ бодох хэдэн минутын хугацаа өгөхийг хүсэв. Миний нэг найз Херметэд ойрхон амьдардаг байсан болохоор түүн рүү залгаад, Херметэд таньдаг хүн байгаа эсэхийг асуув. Тэр Калифорнийн Рэдландс ариун сүмд хамт үйлчилдэг байсан Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Данн эгчийн тухай хэллээ.

Данн эгчийг утсаа авахад нь би "Сайн байна уу, Данн эгч ээ. Та намайг танихгүй л дээ, гэхдээ намайг Нэнси Литтл гэдэг бөгөөд би Ютад амьдардаг. Би Сүмийн гишүүн, харин Херметэд амьдардаг нагац ах, эгч хоёр маань гишүүн биш. Тэд өвдчихөөд, гэрт нь ямар ч хоол хүнс байхгүй гэнэ ээ" гэхчилэн ярьж эхлэв. Намайг тэдний хаана амьдардгийг нь хэлэхэд түүний гэрээс хол байв. Би тэдний ойролцоо байдаг хүргэлт хийдэг зоогийн газрын талаар мэдээлэл авах гэсэн юм гэдгээ тайлбарлаж хэллээ.

Харин Данн эгч нөхөртэйгөө хамт нагац ах, эгчид маань хоол аваачиж өгнө гэв. Тэдэнд гэрийн шөлтэй хоол, талх, бас ээжийнх нь саяхан хийсэн жигнэмэг байгаа гэлээ. Би таттгалзсан боловч тэр өөрийнхөөрөө зүтгэсээр байв.

Хэдэн цагийн дараа Данн эгч над руу утасдаад, бүх зүйл зүгээр

Данн эгч нөхөртэйгөө хамт нагац ах, эгч хоёрт маань хоол аваачиж өгнө гэж хэлэв.

гэдгийг уламжиллаа. Дараа нь ээж над руу яриад, нагац ах Флоид тэдний ирсэн тухай юу гэж хэлснийг дамжуулав. Тэр "Гэрт минь ноён Данн, хатагтай Данн гэдэг нэртэй тэнгэр элчүүд жимс, ногоо, шөлтэй хоол, талх, жигнэмэг гээд тэвэр дүүрэн хоолтой ирсэн. Жигнэмэг нь миний идэж байсан хамгийн сайхан амттай жигнэмэг байсан" гэж хэлсэн байлаа. Данн ах, эгч хоёр нагац ахынд маань очиж, хэрэгтэй зүйлээр тусалсан бөгөөд Данн ах сул биетэй, мартамхай өвчтэй нагац эгч Миллийг маань орноос нь өргөж, гал тогооны сандал дээр суулгахад Данн эгч түүнийг хооллосон байв.

Нагац ах Флоид маань тэдний айлчлалын талаар ээжид ярьж байхдаа уйлж байсан аж. Тэр хэзээ ч ийм найрсаг, сайхан сэтгэлтэй хүмүүстэй уулзаж байгаагүй гэжээ. Тэр намайг Ютад амьдарч, "олон мормоноор" хүрээлүүлсэн азтай нэгэн гэж ээжид маань хэлсэн байв.

Үүнээс хойш дөрвөн өдрийн дараа нагац ах Флоид маань шуудангийн хайрцаг руугаа явж байгаад хальтирч унав. Тэр толгойгоо цохиж, дөрвөн өдрийн дараа нас барсан. Гэрийн асрагчийг эс тооцвол нагац ахын маань нас барахаасаа өмнө хамгийн сүүлд уулзсан хүмүүс нь Данн ах, эгч хоёр байсан юм.

Надаас олон зуун бээрийн зайд амьдардаг, хэзээ ч нүүр нүүрээ харалцаж байгаагүй ч нагац ах, эгчид хоёрт маань тусалсан Халамжийн нийгэмлэгийн нэг эгчийн Христийнхтэй адил үлгэр жишээнд би талархаж явдаг. ■

Нэнси Литтл, АНУ, Юта

ЗУРАГ ЧИМЭГДЭЛИЙГ ВИЛСОН ОНГ

ГЭР БҮЛИЙН ТҮҮХЭЭ ХИЙХ ТОХИРОМЖТОЙ ЦАГ

Бага насны хоёр охинтой ээжийн хувьд би хийе гэж хүссэн зарим зүйлээ ихэвчлэн "цаг" нь болоогүй гэдэг шалтгаанаар хойш тавьдаг байсан юм. Эдгээрийн нэг нь гэр бүлийн түүхийн ажил байв.

Хэдийгээр би өмнө нь индексжүүлэлтийг ням гарагт хийх сайхан үйл ажиллагаа гэж үзэн, оролцдог байсан боловч гэр бүлийн түүхээ хийх цаг зав байхгүй, мэдлэг дутмаг гэдгээр шалтаглан, хойш тавьж байгаагаа анзаарлаа.

Хэдэн сарын өмнө өглөө эрт ариун сүм дотор сууж байхад миний зүрх сэтгэл өөрчлөгдсөн юм. Би ариун сүмийн картан дээрх нас барсан хүмүүсийн нэрсийг харж, тэд өөрсдийг нь төлөөлөн хийсэн ариун сүмийн ёслолуудыг хүлээн аваасай гэж залбирч суухдаа "Тэд гэр бүлийн минь гишүүд байсан бол сайхан биш гэж үү? Би тэднийхээ төлөө энэ ажлыг хийх юмсан" гэж бодов. Хэрэв би үүнийг хүсэж байвал Их Эзэн гэр бүлийн түүхээ хийхэд маань, ялангуяа ням гарагт туслах болно гэдгийг Сүнс надад баталж өгсөн юм. Тэр надад зорилгоо гүйцэлдүүлэхэд хэрэгтэй цаг зав, мэдлэгийг өгч тусална гэдгийг би мэдлээ.

Тэр ням гарагт би гэртээ очоод, FamilySearch.org руу оров. Өвөг дээдсийнхээ нэрийг харах үед нүднээс маань нулимс урсаж билээ. Бидний харилцаа холбоо илүү бат бөх болсон. Эмээгийн маань саяхан нэмсэн хувийн гэрэл зураг, баримт бичгүүд нь тэднийг хайрлах хайрыг маань улам бүр өсгөн нэмэгдүүлж, гэр бүлийн маань гишүүдийг надад илүү амьд болгон ойртуулж байлаа. Би хоёр настай охиноо энэ ажилд оролцуулж, тэр маань элэнц эцэг, хуланц эмэг эхийнхээ зургийг таньдаг болсонд ихэд баярлаж билээ. Надад Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний: "Хүндэтгэлийн өдөр нь гэр бүлийн харилцаа холбоог хүчирхэгжүүлэх гайхалтай боломжийг олгодог. Эцсийн эцэст Бурхан бид бүгдийг хишиг хүртсэн гэгээнтнүүд болон өвөг дээдэс, үр удамтайгаа ариун сүмд лацдан холбогдсон гэр бүлүүд болж эргэж ирээсэй хэмээн хүсдэг" гэж дүрслэн хэлсэнтэй адилхан сэтгэгдэл төрж байв ("Хүндэтгэлийн өдөр нь баясгалант өдөр билээ," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 112).

Анхны энэ үйл явдлаас хойш би Хүндэтгэлийн өдөр гэр бүлийн түүхийн ажилд оролцсон хэвээр байгаа. Гэр бүлийнхээ нас барсан зарим гишүүний төлөө ариун сүмийн ажил хийх адислал надад олдсон юм. Төрөл садангуудаа мэддэг болж, өөр шүтлэг бишрэлтэй өвөө, эмээтэйгээ ойр дотно харилцаатай болсон нь бас нэгэн онцгой адислал байв. Энэ нь мөнхийн гэр бүлийнхээ бат бөх холбоос нь болохын тулд гэрээнүүдээ сахиж, эцсээ хүртэл тэвчинэ гэсэн шийдвэрийг маань хүчирхэгжүүлсэн билээ.

Хэдийгээр хийх ажил их байгаа ч Тэнгэрлэг Эцэг маань ялангуяа Өөрийнх нь өдөр Өөрийнх нь ажилд оролцох миний чадавхыг нэмэгдүүлсэнд би талархаж байна. Хүндэтгэлийн өдөр бол миний хувьд жинхэнэ баяр баясал. ■

Рэйчэл Льюис, АНУ, Юта



Би хоёр настай охиноо энэ ажилд оролцуулж, тэр маань элэнц эцэг, хуланц эмэг эхийнхээ зургийг таньдаг болсонд ихэд баярлаж билээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ УИЛСОН ОНГ

Надад ахмад Моронайн жижигхэн баримал байсан бөгөөд би уг баримлаа ахмад Моронай дунд сургуулийн ангийг хэрхэн удирдахыг надад заасан үйл явдлыг өөртөө сануулахын тулд үлдсэн хичээлийн жилийн турш цамцныхаа халаасанд хадгалав.

АХМАД МОРОНАЙ ДУНД СУРГУУЛЬД ХИЧЭЭЛ ЗААХАД МИНЬ ТУСЛАВ

Би арван гурав, арван дөрөвтэй хүүхдүүдэд хичээл заах хүндхэн хичээлийн жилийнхээ талд нь ороод байлаа. Би сүүлчийн үнэлгээний талаар захирлын туслахтай хийсэн сэтгэл гонсойлгосон хурлаас гэртээ дөнгөж орж ирээд байсан юм. Шинэхэн багш байх, ихэнх хичээлээ өөрөө боловсруулахыг шаарддаг гээд хүүхдүүдийнхээ сонирхлыг татах нь хүртэл миний хувьд амаргүй зүйл байв. Хурлын эцэст намайг сурагчдаараа нэг бол хичээлийг нь хийлгүүл эсвэл хариуцлага хүлээлгэ гэсэн хоёр сонголтын аль нэгийг хүчээр сонгуулан, хэлсэн л бол түүнийгээ ажил хэрэг болгох хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Би хурлаас урам хугарсан, цөхөрсөн байдалтай гарч ирэв. Маргааш нь судраа судалж байхдаа энэ хурлыг тэр өдрийнхөө асуулт болгохоор шийдсэн юм. Мормоны Номоос уншиж байхад надад хариулт ирсэн нь гайхалтай байв.

Би тэр өглөө хэрхэн илүү сайн багш болох талаар судраас олж мэдэхийн төлөө залбирсан байлаа. Алма 44-өөс ахмад Моронайн талаар уншиж байхад Ариун Сүнс надад зааж өгсөн юм. Миний уншсан хэсэгт ахмад Моронай болон нифайчууд Сидон голын дэргэд леменчүүдийг бүсэлж, тэднийг зэвсгээ хаятал нь айлгасан тухай өгүүлсэн байв. Би үргэлжлүүлэн уншаад, ангидаа ахмад Моронай шиг нөлөө бүхий, өөртөө итгэлтэй, амжилттай нэгэн байхыг хэчнээн их хүсэж байгаагаа бодлоо.

Би харилцан яриаг уншиж байхдаа Моронайн "Дайны зэр зэвсгээ бидэнд өг, . . . харин та нар замаараа явж мөн бидний эсрэг дайтахаар дахин ирэхгүй аваас амийг тань бид хэлтрүүлэх болно" эсвэл "хэрэв та нар ийнхүү үйлдэхгүй аваас, . . . та нарыг дайрахыг . . . би өөрийн хүмүүст тушаах болно" (Алма 44:6, 7) хэмээн Зерахемнагаар болон леменчүүдээр хүчээр сонголт хийлгэж байгааг олж харав. Би эрхлэгчийн маань хий гэж надад хэлсэн яг тэр зүйлийг Моронай хийж байна гэдгийг ойлгосон юм! Тэр "хоёр сонголт өгч, хэлсэн л бол ажил хэрэг болго" гэж хэлсэн байв. Үүнийг ойлгоод би Моронайн "Болгоогтун, бид зөрчилдөөнийг төгсгөнө" (Алма 44:10) гэсэн уриаг өөрийнхөө уриа болгож билээ.

Би хүндэлдэг баатрынхаа тухай судрын түүхээс мэдэж авсан зарчмаар зэвсэглэн, ангидаа өөртөө итгэлтэй, байлдааны төлөвлөгөөтэй эргэж ирсэн юм. Надад ахмад Моронайн жижигхэн баримал байсан бөгөөд би уг баримлаа ахмад Моронай дунд сургуулийн ангийг хэрхэн удирдахыг надад заасан үйл явдлыг өөртөө сануулахын тулд үлдсэн хичээлийн жилийн турш цамцныхаа халаасанд хадгалав. Суралцагчдадаа хоёр сонголт өгөх тусам тэдний зан авир сайжирч, хичээлээ хийдэг болсноос гадна бид хоорондоо хэл амаа сайн ойлголцдог болсон билээ. Хичээлийн жил ч дуусаж, хэдийгээр амаргүй байсан ч судраас ирсэн залбирлын хариулт, хүч чадлын ачаар би "зөрчилдөөнийг төгсгөж" чадсан юм. ■

Бэн Флоид, АНУ, Вашингтон

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

ЭММАГИЙН ТӨЛӨӨ МАЦАГ БАРЬЖ, ЗАЛБИРСАН НЬ

Сэсил Норрунг

Охиноо цонхоор унасны дараа бидний хамгийн их айдаг байсан зүйл тохиолдчихлоо шүү дээ гэж надад бодогдов.

Гэр бүл маань сайхан амарч явж байгаад, гэртээ дөнгөж ирээд байлаа. Оройн хоолны дараа би дөрвөн настай Маркус, гурван настай Эмма хоёрыг дөрвөн давхрын байрныхаа дээд талын унтлагын өрөөнд тоглуулахаар явуулав. Дани улсад байрны цонхнууд нь гадагшаа нээгддэг юм. Цонхнууд ихэвчлэн цоожтой байдаг ч амралтаар явахдаа байрандаа агаар оруулахын тулд хагас нээлттэй орхисон байв.

Аягаа угааж байх үед ямар нэг муу зүйл боллоо гэсэн мэдрэмж надад гэнэт төрөв. Маркусыг шатаар гүйн, бууж ирэхэд би зочны өрөө рүү харайн орлоо. Тэр айсандаа хашгирч, Эмма цонхоор уначихлаа гэж хэлэв. Цонх маань явган хүний замаас дээш, 12 метр зайтай байрладаг байлаа. Би шатаар гүйж буухдаа Эммагийн нэрийг дуудан хашгирч байсан ба бяцхан охиноо цементэн дээр үхлүүт мэт хэвтэж байхыг харав. Түүнийгээ тэврэхэд хөдлөхгүй байсан бөгөөд би хамгийн их айдаг зүйл минь тохиолдчихлоо шүү дээ гэж бодов. Нөхөр минь араас маань гарч ирээд, түүнийг гар дээрээ аван, тэр даруй санваарын адислал өгөв.

Түргэн тусламжийн тэрэг хурдан ирсэн бөгөөд эмч нарыг Эммад түргэн тусламж үзүүлэх зуур Маркус бид хоёр залбирсаар байлаа. Удалгүй бид бүгдээрээ түргэний тэргээр эмнэлэг рүү явсан.

Нэг их удалгүй эрчимт эмчилгээний тасагт бидэнд түшиг дэм болохоор гэр бүлийн гишүүд маань ирэв. Маркусыг үеэлтэйгээ гэр рүүгээ явахад, нөхөр бид хоёр үлдсэн бөгөөд Эммагийн биеийн байдлыг сайн мэдэхгүй байлаа.

Удаан хүлээсний эцэст эмч нарын нэг нь гарч ирээд, ослын талаар тодорхой зүйл асууж эхлэв. Ерөнхийдөө ийм өндрөөс унахад битүү гэмтэл авч, амьд гарах магадлал тун бага байдаг гэж эмч хэлсэн юм. Эммагийн аарцагны яс хугарч, тархи нь хөдөлсөн боловч шалбархайнууд нь өнгөцхөн байв. Тэнгэр элч түүнийг тосож авснаас зайлахгүй гэж эмч хэлж билээ.

Эмма амьд үлдсэн нь гайхамшиг байсан ч тархиндаа гэмтэл авснаас болж ухаан орохгүй хэвээр байв. Нөхөр маань хоёр дотны найзтайгаа хамт Эммад дахин адислал өгөв. Уг адислалд түүнийг ямар нэг хүндрэлгүйгээр бүрэн эдгэрч, энэ осол түүний амьдралд эерэг туршлага байх болно гэж амласан юм. Надад санваарын хүчинд тун их талархах сэтгэл төрж билээ. Шөнийн турш гуйсан залбирлуудыг маань сонссон байв.

Дөрөв хоногийн дараа Эмма маань ухаан орсон юм. Энэ дөрвөн өдрийн турш найз нөхөд, Сүмийн гишүүд болон өөр олон хүн түүний төлөө мацаг барьж, залбирч байв. Итгэлтэй гэгээнтнүүдийн залбирал намайг хүрээлэн, намайг болон гэр бүлийг маань хүчирхэгжүүлэхийг би мэдэрсэн. Тэнгэрлэг Эцэг намайг тэвэрч, тайтгаруулж байх шиг санагдсан билээ.

ЗУРГИЙГ © ISTOCK/THINKSTOCK

Охин маань ухаан орохын өмнөх өдөр манай гадасныхан мацаг барьсан байв. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, Эмма ухаан орсон нь мацаг барьсны шууд үр дүн гэдэгт бид итгэдэг. Үүнээс хойш Эмма хурдан эдгэрсэн. Тэр осолдсоноосоо хойш тав хоногийн дараа анхны үгээ хэлж, есөн хоногийн дараа эмнэлгээс гарсан. Тэр таван долоо хоног тэргэнцэртэй явж байгаад, дараа нь физик эмчилгээ хийлгэж эхлэв.

Ослоос хойш сар орчмын дараа Эммаг тэвэрсээр байгаад нуруу маань өөрийн эрхгүй өвдөх болсон юм. Надад зөвхөн бие махбодоороо биш, сүнслэг байдлаараа ч мөн хүч чадалгүй болсон мэт мэдрэмж төрөв. Би яаж түүнийг цаашид үргэлжлүүлэн асарч халамжлах вэ?

Нэг орой хүч чадалгүй байгаагаасаа болж гэм буруутай мэт дааж давшгүй мэдрэмж намайг эзэмдлээ. Би гэрээсээ гарч, цэцэрлэгийн сандал дээр суугаад, Тэнгэрлэг Эцэгтээ хандан цаг гаруй залбирав. Амьдралдаа анх удаа би Аврагчийн Цагаатгалын гайхамшигт хүч намайг нөмрөн ирэхийг мэдэрч билээ. Тэр залбирлын дараа өөртөө тээж явсан бүх зовлон, шаналал, ачаа дарамт мөрөн дээрээс минь авагдсан юм. Эмма тэргэнцэр дээрээ, би нуруундаа тогтмол эмчилгээ хийлгэсэн хэвээр байсан ч цааш үргэлжлүүлэх хүч чадлыг надад өгсөн байлаа.

Нэг жил өнгөрөхөд Эмма дөрвөн настай бусад хүүхдийн адил гүйж, инээж, түүх ярьж, бодож чаддаг болсон юм.

Бидэнд санаа тавьж, бидний хүн нэг бүрийг биечлэн мэддэг, хайраар дүүрэн Тэнгэр дэх Эцэг байдгийг бид мэднэ. Тэр биднийг ямар бэрхшээл туулж байгааг мэднэ. Залбирал, мацаг барилт, санваарын адислал зэргээр дамжуулан Тэр гайхамшгуудыг бидэнд өгсөн гэдэгт би хэзээ ч эргэлзэхгүй. ■

Энэхүү өгүүллийн зохиогч Дани улсын нийслэлд амьдардаг.

БИД БЭРХШЭЭЛД ЯМАР ХАРИУ ҮЗҮҮЛЭХ ВЭ?

"Амьдралд маань хүнд хэцүү зүйлс тохиолдоход бидний тэр даруй үзүүлэх хандлага ямар байдаг вэ? Эргэлзэж, тээнэгэлзэн, сүнслэг байхаа больдог уу? Итгэл маань буурдаг уу? Өөрийнхөө нөхцөл байдалд Бурханыг эсвэл бусдыг буруутгадаг уу? Эсвэл хэн болохоо мэдэж, амьд Бурханы хүүхдүүд гэдгээ санах нь бидний гаргадаг хамгийн эхний хандлага уу? Дэлхийн өвчин шаналал нь Түүнтэй адил болж, мөнхийн өв хөрөнгөө өвлөн авахад цэвэршүүлэгч галтай адил биднийг адислах болно гэдгийг Тэр мэддэг *учраас* энэ бүхнийг зөвшөөрдөг гэсэн туйлын итгэлтэй нэгддэг үү?"

Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Доналд Л.Холлстром, *"Би* Бурханы хүүхэд," *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 11.



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
ерөнхийлөгч
Рассэлл М.Нэлсон

Жинхэнэ мянган жилийнхэн мэт зогс

Олон хүн та нарыг millennials буюу *мянган жилийнхэн* гэж нэрлэдэг. Судлаачид та бүхнийг энэ үгээр нэрлэж, хийсэн судалгаа нь та нарын дуртай, дургүй зүйлс, сэтгэлийн хөдөлгөөн, сонирхол, сул болон давуу талуудын талаар юу гэж илчилснийг тайлбарлахад үнэндээ надад эвгүй санагддаг. Би тэдний *мянган жилийнхэн* гэсэн энэхүү нэр томьёог хэрхэн хэрэглэж байгаад санаа зовдог. Үнэндээ *шинжээчид* та нарын талаар юу гэж хэлж байгааг би сонирхдоггүй, харин Их Эзэн та нарын талаар надад юу гэж хэлснийг илүүтэй сонирхдог.

Би залбирч, та нарын талаар *Их Эзэний* ямар сэтгэгдэлтэй байгааг мэдэхийг Түүнээс хүсэхэд надад эрдэмтэн судлаачдын хэлж байгаагаас огт өөр мэдрэмж төрдөг. Та бүхний хүлээн авсан Сүнслэг мэдрэмж нь *мянган жилийнхэн* гэх энэхүү нэр томьёо үнэндээ шинжээчдийн ойлголтоос тэс өөр шалтгаанаар та нарт хамгийн төгс тохирно гэдэгт намайг иттүүлэхэд хүргэсэн юм. Гэхдээ шинжээчдийн ойлгож чадахаас огт өөр шалтгаан байгаа учраас юм шүү.

Мянган жилийнхэн гэх энэхүү нэр томьёо та нарын *үнэхээр* хэн болохыг, амьдралын тань зорилго *үнэхээр* юу болохыг сануулж өгч байгаа бол та нарт зохисон нэр гэж ойлгож болно. Жинхэнэ мянган жилийнхэн гэж мөнх бус байдлын өмнөх оршихуйд Есүс Христийн сайн мэдээг заалгаж мөн зааж, тэнд бидний Тэнгэрлэг Эцэгтэй энэ дэлхий дээр байхдаа хийхэд зориг, тэвчээр шаардагдах зүйлс, бүр *ёс суртахууны* талаар зориг гаргах шаардлагатай болох зүйлүүдийн талаар гэрээ байгуулсан хүмүүсийг хэлнэ.

Жинхэнэ мянган жилийнхэн бол энэ дэлхийн түүхэнд урьд өмнө тохиолдож байгаагүй, давж туулахад хамгийн хүнд эрин үед Бурханы дэлхий рүү илгээхдээ найдаж болно хэмээн үзсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс юм. Жинхэнэ мянган жилийнхэн гэдэг нь одоо амьдарч байгаа, энэ дэлхийн хүмүүсийг Есүс Христийн Хоёр дахь ирэлт болон Түүний мянган жилийн хаанчлалд бэлтгэхэд туслах эрэгтэй, эмэгтэй хүмүүс юм. Та нар бол жинхэнэ мянган жилийнхэн байхаар төрсөн хүмүүс гэдэгтээ бат итгэлтэй байгаарай.

Та нар бол энэ дэлхийн хүмүүсийг Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх гайхалтай ажлыг хийж гүйцэтгэхээр Бурханы бүр урьдаас тодорхойлсон "сонгогдсон үеийнхэн" билээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТИ РЭЙФСНАЙДЕР

МОРМОНЫ НОМ
Есус Христийн бас нэгэн гэрээ

Асуух зүйл юу вэ гэвэл, “Жинхэнэ мянган жилийнхний хувьд та нар хэрхэн бат зогсож, амьдарч чадах вэ? Надад та бүхэнд өгөх дөрвөн зөвлөмж бий.

Миний нэгдүгээр зөвлөмж: Өөрийгөө жинхэнэ хэн болох талаар суралц

Эдгээр зүйлийн талаар залбирч, тунгаан бодох цаг гарга.

- Та нар бол Бурханы сонгогдсон хүү, охин мөн.
- Та Түүний дүр төрхөөр бүтээгдсэн.
- Та нар Сүнсний дэлхийд байхдаа энэхүү хожмын үеийн сүүлийн хэсэгт тулгарч болох аливаа мөн бүхий л зүйлтэй тулгарахад бэлтгэхээр заалгуулсан юм (С ба Г 138:56-г үзнэ үү). Тэнд заалгасан зүйлс та нартай хамт байгаа.

Та нар “арван нэг дэх цагт” амьдарч байна. Их Эзэн үүнийг дэлхийн өнцөг булан бүрээс сонгомол хүмүүсийг Өөрийн усан үзмийн талбайд цуглуулахаар үйлчлэгчдээ дуудах сүүлийн цаг хэмээн тунхагласан юм. (С ба Г 33:3–6-г үзнэ үү.) Мөн *та нар* ч гэсэн энэ цугларалтад оролцохоор илгээгдсэн. Жинхэнэ мянган жилийнхэн бусдыг үнэний мэдлэгт авчрахдаа тэдэнд хүчтэй нөлөөлж байгааг би нүдээрээ олонтоо харж байсан билээ. Абрахамын үр удмын хувьд энэ нь та нарын жинхэнэ байдал мөн бөгөөд та нарын зорилгын нэгээхэн хэсэг юм (Галат 3:26–29-ийг үзнэ үү)!

Хэдэн сарын өмнө Вэнди бид хоёрыг алс холын Сибирьт аялж байхад нэгэн гайхалтай явдал тохиолдсон. Бидний бэлтгэлийн өдрөөр Эрхүү хотоор хамтдаа аялсан хүмүүсийн дунд номлолын ерөнхийлөгч Грэгори С.Бринтон, түүний эхнэр Салли мөн тэдний Орост номлолд үйлчилсэн, буцаж ирсэн номлогч хүү Сэм нар байлаа. Бид үзэсгэлэнт Байгаль нууран дээр очиж, эрэг дээрх захаар орж үзэв.

Автобус руугаа буцахдаа бид Сэмийн байхгүй байгааг гэнэт мэдэв. Хэдэн хормын дараа тэр Валентина гэх нэгэн дундаж насны эмэгтэйтэй хамт буцаж ирлээ. Валентина төрөлх орос хэлээрээ “Би энэ залуугийн ээжтэй нь уулзмаар байна. Тэр сайхан харьцаатай, ухаантай, найрсаг залуу байна. Би түүний ээжтэй л уулзмаар байна” гэж их л өөдрөг байдалтай хэлэв. Валентина Сэмийн баяр хөөртэй, гэрэлтсэн дүр төрхөд татагдсан байлаа.

Сэм Валентинаг эцэг, эх хоёртойгоо танилцуулаад, түүнд Аврагчийн тухай товхимол өгч, номлогчдыг

түүнтэй очиж уулзах талаар тохиролцож, зохицуулж өгөв. Дараа нь номлогчид түүн дээр Мормоны Ном авч очиход тэр уншина гэж амлажээ. Түүнтэй хамт зах дээр ажилладаг хэдэн эмэгтэй Валентинагийн хүлээн авсан шинэ номын талаар бас сонирхож эхэлсэн байна. Бид энэ түүхийн төгсгөлийг одоохондоо сайн мэдэхгүй ч Сэмээс цацарч байсан тод гэрлээс Валентина болон түүний найзууд сайн мэдээтэй танилцсаныг мэднэ.

Сэмийн адил жинхэнэ мянган жилийнхэн өөрсдийгөө хэн гэдгийг сайн мэддэг. Тэд Есүс Христийн иттэлтэй, дуулгавартай шавь нар бөгөөд бидний Аврагчийн мянган жилийн хаанчлалд өөрсдийгөө болон бусдыг бэлтгэхэд туслахаар зөн совингоороо аливаа боломжийг ашигладаг.

Тиймээс *өөрсдийнхөө* хэн болохыг мэдэж ав гэдэг нь миний өгөх гэсэн эхний зөвлөмж юм. Тэнгэрлэг Эцэгээсээ Есүс Христийн нэрээр таны тухай болон таны энэ дэлхий дээрх үүрэг хариуцлагын тухай ямар бодолтой байдгийг асуугаарай. Хэрэв та чин сэтгэлээсээ хүсэж асуувал Сүнс амьдралыг тань өөрчлөх үнэнүүдийг танд цагаас цагт шивнэх болно. Тийм мэдрэмжийг сайтар тэмдэглэж аваад, ойр ойрхон эргэн харж байх хэрэгтэй. Тэгээд тэдгээрийг яг таг дагаж мөрдөөрэй.

Таныг Тэнгэрлэг Эцэг хэрхэн харж, Өөрийнх нь төлөө юу хийхийг танаас хүсэж найдаж байдгийн өчүүхэн хэсгийг та зурвасхан ч гэсэн харж эхлэх үед амьдрал тань өмнөх шигээ хэзээ ч байхгүй гэдгийг би та нарт амлаж байна.

Миний хоёрдугаар зөвлөмж: Боломжгүй гэсэн зүйлийг ч хийнэ гэж бодож, бэлтгэлтэй бай

Бурхан Өөрийн гэрээт хүүхдүүдээс үргэлж хүнд, хэцүү зүйлийг хийхийг хүсэж ирсэн. Та нар гэрээгээ сахидаг мөн хожмын өдрүүдийн сүүл үед амьдарч байгаа Бурханы хөвгүүд, охид учраас Их Эзэн *та нараас* хүнд хэцүү зүйлийг хийхийг хүсэх нь гарцаагүй. Та нар үүнд итгэж болно. Абрахамд ирсэн сорилт Абрахамыг зогсоогоогүй юм шүү (С ба Г 101:4–5-ыг үзнэ үү).

Таны чадавхаас хол давсан мэт санагдах зүйлийг хийхийг танаас шаардах нь ямар санаа зовмоор байдаг гэдгийг би мэднэ. Намайг

Та нар сонгогдсон хүмүүсийг цуглуулах ажилд оролцохоор илгээгдсэн. Жинхэнэ мянган жилийнхэн бусдыг үнэний мэдлэгт авчрахдаа тэдэнд хүчтэй нөлөөлж байгааг би олонтоо харж байсан билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болоод дөнгөж 19 сар болж байхад ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл нас барсан. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсонийг (1899–1994) албанд нь томилсны дараа Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын эхний хурлаар тэрээр Арванхоёрын чуулгад тодорхой үүрэг даалгавар хүлээлгэсэн байдаг. Түүний надад өгсөн үүрэг даалгаварт: “Ахлагч Нэлсон, та Зүүн Европын улс орнуудыг сайн мэдээ номлоход нээлттэй болгох хэрэгтэй” гэсэн даалгавар байсан юм.

Тэр бол 1985 он байлаа. Улс төрийн хувьд бэрхшээлтэй, бидний хүйтэн дайн хэмээн нэрлэдэг тэр он жилүүдэд Берлин хот ханаар тусгаарлагдаад зогсохгүй, Зүүн Европ тэр чигээрээ коммунизмын дарлалд байлаа. Сүмүүд хаагдаж, сүсэглэж бишрэхийг хатуу хориглодог байв.

Би амьдралынхаа ихэнх үеийг мэргэжлийнхээ дагуу хүмүүсийн амь насыг аврахаар зүрхийг нь нээн, мэс засал хийхэд зориулсан. Гэхдээ улс орнуудыг сайн мэдээний номлолд нээж чадна гэж иттэхэд хүргэх туршлага надад *огт* байгаагүй юм. Гэсэн хэдий ч бошиглогч надад ийм даалгавар өгсөн тул би энэ огт боломжгүй гэж санагдаж байсан зүйлийг хийхээр сэтгэл шулуудсан билээ.

Бүр эхнээсээ л миний замд саад тотгор тулгарч байлаа. Би ихэнх улс оронд очихдоо хаашаа явахаа ч мэддэггүй байсан. Засгийн газрын холбогдох албаны хүний нэрийг олох боломж олдсон ч уулзалтыг сүүлчийн мөчид цуцлах эсвэл хойшлуулах нь хэвийн үзэгдэл байлаа. Нэг улсад уулзалтыг хоёр хоногоор хойшлуулах үед намайг шалгахаар хар зах дээр валют солиулах хавх мөн өөр бусад хууль бус үйл ажиллагаа явуулах уруу таталт тохиолдож байсан. Өөр нэгэн тохиолдолд уулзалтыг намайг *нэн даруй* яв гэсэн шаардлага тавьснаар эхлүүлж байсан удаа ч бий.

Гэвч Их Эзэн Өөрийн ажлыг хийж чаддаг (2 Нифай 27:20–21-ийг үзнэ үү) бөгөөд би гайхамшгууд ар араасаа цувран тохиолдохыг харах онцгой боломжтой байлаа. Намайг чадлынхаа хэрээр бодож, хамгийн зоригтой хичээл зүтгэлээ гарган, уг даалгаврын талаар хичээнгүйлэн залбирсны *дараа* л эдгээр гайхамшиг үргэлж тохиолддог байсан.

Тэдгээр улс орны зарим нь Берлиний ханыг нураахаас өмнө Сүмийг хүлээн зөвшөөрсөн байсан. Бусад нь хожим хүлээн зөвшөөрсөн. 1992 онд би ерөнхийлөгч Бэнсонд Сүмийг Зүүн Европын бүх улс

оронд байгуулсан гэж илтгэх боломжтой болсон юм.

Их Эзэний итгэлийг хүлээсэн жинхэнэ мянган жилийнхний хувьд *та нар* ч гэсэн түүхийг бүтээх болно! Та бүхнээс бас бэрхшээлтэй үүрэг даалгавар хүлээн авахыг хүсэх бөгөөд та нар Их Эзэний гарт зэмсэг байх болно. Тэр та нарыг боломжгүй зүйлийг хийж гүйцэтгэх чадвараар хангана.

Та нар хэрхэн боломжгүй зүйлийг хийж гүйцэтгэх вэ? Та нар Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлж, Түүний сэргээгдсэн Сүмд заагддаг сургаалын талаарх ойлголтоо нэмэгдүүлэхээр чадах бүхнээ хийснээр мөн үнэнийг цөхрөлтгүй хайснаар тэр бүхнийг хийж гүйцэтгэж чадна. Ариун сургаалд бөхлөгдсөн жинхэнэ мянган жилийнхний хувьд танаас боломжгүй зүйл хийхийг хүсэхэд та Их Эзэний зорилгуудыг гүйцэлдүүлэхийн тулд өөрийн чадах бүхнийг бууж өгөлгүй, урамтай, итгэлтэй хийхээр урагшилж чадах болно (С ба Г 123:17-г үзнэ үү).

Та бүхэнд бүрмөсөн шантрах өдрүүд ч тохиолдох болно. Тиймээс бууж өгөлгүй, зоригтой байхын төлөө залбирагтун! Та бүхэнд энэ хүч чадал хэрэгтэй, яагаад гэвэл хожмын үеийн гэгээнтэн байх нь улам бүр нэр хүндгүй зүйл болох үе гарна. Бас таны найзаа гэж бодож байсан хүмүүс ч та нараас урвах болно. Мөн нэлээд зүйл шударга бус мэт санагдах болно.

Гэвч та нар Есүс Христийг дагаснаараа тогтвортой амар амгалан, жинхэнэ баяр баясгаланг олох болно гэдгийг би амлаж байна. Та нарыг гэрээнүүдээ илүү чанд сахиж, өнөөгийн дэлхийд Сүмийг болон Бурханы хаант улсыг хамгаалах үед Их Эзэн та бүхнийг боломжгүй зүйлүүдийг бүтээх хүч чадал, мэргэн ухаанаар адислах болно.

Миний гуравдугаар зөвлөмж: Тэнгэрийн хүчийг ашиглаж сур

Бидний хүн бүр асуулт тавьдаг. Үнэнийг сурч, ойлгож авч, мэдэхээр эрэлхийлэх нь бидний мөнх бус аяны амин чухал хэсэг юм. Миний амьдралын ихэнх хугацаа судалгаа шинжилгээ хийхэд зарцуулагдсан. Та нар ч гэсэн сүнслэг өдөөлт бүхий асуулт тавьснаараа сайн суралцах болно.

Яг энэ мөчид та нарын зарим нь амьдралдаа юу хийх ёстойг мэдэх гэж зовниж байгаа. Та нарын зарим нь нүглээсээ уучлагдсан юм болов уу гэж санаа зовж байгаа. Мөн ихэнх нь мөнхийн хань минь хаана, хэн гэдэг хүн байгаа бол гэж бодож

байгаа. Тэгж бодоогүй хүн байвал бодох ёстой шүү.

Зарим нь Сүм яагаад ийм зүйлүүдийг хийдэг юм бол гэж гайхширдаг байж болох юм. Магадгүй та нарын олонх нь залбирлынхаа хариултуудыг хэрхэн хүлээн авахаа мэдэхгүй байж болно.

Бидний Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү хоёр Ариун Сүнсний тохинуулаар дамжуулан та бүхний асуултуудад хариулахад бэлэн байдаг. Харин тэдгээр хариултыг авахын төлөө хэрхэн зохистой болж мөн хүлээн авахад суралцах нь та нараас шалтгаална.

Юунаас эхэлж болох вэ? Юуны түрүүнд ариун газруудад илүү их цагийг өнгөрөөснөөр эхэлж болно. Ариун сүм бол ариун газар юм. Түүнчлэн та нарын ням гараг бүр ариун ёслолын шинэ гэрээнүүдийг хийдэг цуглааны байр ч гэсэн ариун газар мөн. Би та бүгдийг өөрсдийн орон сууц, оюутны байр, гэр орноо эсвэл өрөөгөө дэлхийн харанхуй анхаарал сарниулах зүйлсээс хол, аюулгүй орогнох ариун газар болгогтун хэмээн урьж байна.

Залбирал бол түлхүүр нь юм. Юу хийхээ болихоо мөн юу хийж эхлэх ёстойгоо мэдэхийн тулд залбир. Өөрийнхөө орчинд юуг нэмэх эсвэл юуг зайлуулах ёстойгоо мэдэхийн тулд залбир. Тэгснээр Ариун Сүнс та нартай элбэг дэлбэг байж чадна.

Ялгаж таних бэлэг өгөхийг Их Эзэнээс гуй. Тэгээд та нар уг бэлгийг хүлээн авахаар зохистой амьдарч, ажиллах юм бол дэлхийд самуун үйл явдлууд тохиолдох үед ч аль нь үнэн, аль нь худал гэдгийг тодорхой мэдэх болно (2 Нифай 31:13-ийг үзнэ үү).

Хайраа үзүүлэн үйлчил. Замаасаа төөрсөн эсвэл гэмтсэн сүнстэй хүмүүст хайраа үзүүлэн үйлчлэх нь та нарын зүрх сэтгэлийг хувийн илчлэлт хүлээн авахад нээж өгөх болно.

Сүнс байгаа газарт илүү их цагийг, бүр үлэмж их цагийг зарцуул. Энэ нь Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгахыг хүсэж буй найзуудтайгаа илүү их цагийг өнгөрүүл гэсэн үг юм. Илүү их цагийг өвдөг сөгдөн залбирч өнгөрүүл мөн судрууд, гэр бүлийн түүхийн ажил, ариун сүм зэрэгт илүү их цагийг зарцуул. Хэрэв та нар Их Эзэнд өөрийнхөө цагаас илүү их хэсгийг

Та бүхнээс хүнд үүрэг даалгавар хүлээн авч, Их Эзэний гарт зэмсэг болохыг хүсэх болно. Тэр та нарт боломжгүй зүйлийг хийж гүйцэтгэх боломжийг өгнө.

өгөөмрөөр тогтмол өгвөл Тэр үлдэгдлийг нь үржүүлж өгөх болно гэж би амлаж байна.

Бид 15 хүнийг бошиглогч, үзмэрч, илчлэгч байхаар томилогдоход дэмжин баталсан. Хүнд хэцүү асуудал тулгарч, тэдгээр нь өдөр ирэх тусам улам бүр ширүүссээр байвал эдгээр 15 хүн уг асуудалтай тэмцэж эхэлдэг бөгөөд авч болох арга хэмжээнүүдийн чиглэлийг цэгнэж, Их Эзэний дуу хоолойг сонсохыг хичээнгүйлэн эрэлхийлдэг юм. Мацаг барин, залбирч, судалж, тунгаан бодож, ах нартайгаа хүнд асуудлуудын талаар зөвлөлдсөний дараа санаа зовоож буй асуудлынхаа талаарх нэмэлт өдөөлтүүдийг шөнө дунд авч нойрноосоо сэрэх нь миний хувьд хэвийн үзэгдэл байдаг. Ах нарт маань ч үүнтэй адил зүйл тохиолддог.

Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга хоорондоо зөвлөлдөж, Их Эзэн биднийг хувиараа болон хамтдаа юу ойлгож, мэдрэхэд чиглүүлснийг хуваалцдаг юм. Энэ бүгдийн дараа бид Их Эзэн Сүмийн ерөнхийлөгч дээр ирж, Өөрийн хүслийг тунхаглахыг хардаг.

Энэхүү бошиглолын үйл явцыг 2012 онд номлогчдын насны доод хязгаарыг өөрчлөх үед баримталсан мөн зарим улс оронд ижил хүйстний гэрлэлтийг хуулиар зөвшөөрөх болсонтой холбогдуулж Сүмийн гарын авлагад саяхан нэмэлт өөрчлөлт хийх үеэр дагаж хэрэгжүүлсэн билээ. Бид бүх хүнийг, нэн ялангуяа хүүхдүүдийг хайрлах энэрлээр дүүргэгдэж, тухайн асуудлуудын талаарх Их Эзэний хүслийг ойлгохын тулд ихээхэн тэмцэлдсэн юм.

Бид Бурханы авралын төлөвлөгөө, Түүний Өөрийнхөө хүүхэд бүрд зориулсан мөнх амьдралын найдварын талаар санан, гарч болох тоолж баршгүй олон шийдэл, өөрчлөлт, хувилбарыг авч үзсэн. Бид ариун сүмд мацаг барин, залбирч, ойр ойрхон цугларан, нэмэлт удирдамж, сүнслэг өдөөлтийг эрэлхийлсэн. Тэгээд Их Эзэн бошиглогч Томас С.Монсонд Сүнсээр нөлөөлж, Их Эзэний бодол, хүслийг тунхаглахад бидний хүн нэг бүр тэрхүү ариун цаг мөчид сүнслэг баталгааг мэдэрсэн юм. Ерөнхийлөгч Монсоноор илчлэгдсэн зүйлийг дэмжин баталах нь төлөөлөгч бидэнд өгөгдсөн онцгой эрх байлаа. Их Эзэнээс Өөрийнхөө үйлчлэгчдэд өгдөг илчлэлт нь ариун үйл явц байдаг. Мөн хувийн илчлэлт хүлээн авах нь ч бас та нарын онцгой эрх юм.

Хайрт ах, эгч нар аа, Түүний Сүмийн талаар юу хийхээ мэдэх

боломж төлөөлөгч бидэнд байдаг шиг, амьдралынхаа талаар Их Эзэний бодол хүслийг мэдэх тийм их боломж та нарт ч бас байдаг шүү. Их Эзэн *биднээс* хүнд асуудлуудынхаа тухайд хайж, тунгаан бодох, мацаг барьж, залбирах, судалж, тэмцэхийг шаарддагтай адил Тэрээр *та нарыг* өөрсдийнхөө асуултын хариултыг хайж олохын тулд адил зүйл хийхийг шаарддаг юм.

Та нар Их Эзэний дуу хоолойг Ариун Сүнсний шивнээгээр дамжуулан сонсож сурч чадна.[1] Гүүгл, твиттер, фэйсбүк зэрэг нь тус нэмэртэй байж болох мэт санагдах ч тэдгээр нь хамгийн чухал асуултуудад хариулт өгч чаддаггүй.

Миний хайрт залуу анд нөхөд минь, та нар амьдралынхаа талаар Их Эзэний бодол, хүслийг мэдэж авч чадна. Та нар өөрсдийгөө Их Эзэний хүссэн газарт байгаа эсэх эсвэл Түүний та нараар хийлгэх хэрэгтэй зүйлийг хийж байгаа эсэхдээ гайхширах хэрэггүй юм. Та нар мэдэж чадна! Ариун Сүнс та нарын "хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно" (2 Нифай 32:3).

Миний дөрөвдүгээр зөвлөмж: Бошиглогчдыг дага

Би 1979 онд Ням гаргийн ангийн ерөнхий ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа Бүсийн төлөөлөгчдийн семинарт оролцохоор уригдсан бөгөөд энэ үеэр ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл тухайн үедээ Сүмийн хувьд хаалттай Хятад зэрэг зарим улс үндэстний хаалгыг нээх тухай сүнслэг өдөөлт бүхий үг хэлсэн юм. Ерөнхийлөгч тухайн арга хэмжээнд оролцож байсан бүх хүнийг хятад хэл сурахад уриалсан бөгөөд тэгснээр Хятадын ард түмэнд өөрсдийн мэргэжлийн дагуу дэмжлэг үзүүлж болох юм хэмээн хэлжээ.

Надад ерөнхийлөгч Кимбаллын урилга бошиглолын зарлиг мэт санагдсан. Тэр оройдоо би эхнэр Данцэлээс надтай хамт хятад хэл сурах уу гэж асуув. Тэр ч зөвшөөрч, бид заах цагийн багш олсон юм. Мэдээж, бид хятадаар тийм сайн ярьж сураагүй боловч дараагийн жил нь (урьдчилан төлөвлөөгүй байсан олон үйл явдлаас болж) намайг Хятадад зүрхний нээлттэй мэс заслын талаар заах айлчлагч профессороор урьсан урилгыг хүлээн авах үед би арай дээр бэлтгэгдсэн байлаа.

Зургаан жилийн дараах үе буюу 1985 оны талаар яривал энэ нь намайг Арванхоёрын чуулгад дуудагдсаны дараах жил байлаа. Нэг өдөр би яаралтай Хятад руу явж, тэдний дуурийн алдартай од, жүжигчин, Хятад даяар үндэсний

баатар болох нэгэнд зүрхний нээлттэй мэс засал хийх хүсэлт хүлээн авсан юм. Би бүрэн цагийн шашны үүрэг хариуцлагаасаа болоод очих боломжгүй байна гэдгээ тайлбарласан. Гэтэл хятадын эмч нар амь насыг нь аврах мэс засал хийж өгөхөөр даруй ирэхийг гуйв.

Би чуулгын ерөнхийлөгч болон Тэргүүн Зөвлөлтэй энэ асуудлыг хэлэлцсэн. Намайг Хятадын ард түмэнд туслахын тулд тийш явж, мэс засал хийх хэрэгтэй юм байна гэсэн мэдрэмж тэдэнд төржээ.

Би тэр мэс заслыг хийсэн. Хамгийн баярлууштай зүйл нь мэс засал маш амжилттай болж билээ. Хачирхалтай нь тэр бол миний хийсэн хамгийн сүүлчийн зүрхний нээлттэй хагалгаа байлаа. Энэ нь 1985 оны 3-р сарын 4-ний өдөр Хятадын Жинанд болсон юм.

Одоо цаашлаад, энэ удаад 2015 оны 10-р сар буюу гуравхан сарын өмнөх байдлын талаар ярья. Вэнди бид хоёр Жинан дахь Шандоны Анагаах Ухааны Их Сургуульд очихоор уригдсан юм. Намайг Хятадын "хуучин анд" мэт маш халуун дотно хүлээн авахад мөн 35 жилийн өмнө миний заасан мэс засалч эмч нартай дахин уулзуулахад эхнэр бид хоёр ихэд гайхаж билээ. Очсон өдрийнхөө орой бид дуурийн тэрхүү алдартай жүжигчний хүүтэй болон ачтай нь уулзсан явдал айлчлалын маань баярт мөч байлаа. Эдгээр бүх гайхамшигтай үйл явдал болоход нөлөөлсөн цорын ганц шалтгаан бол би бошиглогчийн хятад хэл сур гэсэн зөвлөгөөг дагасан явдал байсан юм.

Бошиглогчид ирээдүйг урьдаас хардаг. Тэд дайсны бидний замд тавьсан эсвэл тавих гэж байгаа аймшигт аюул заналыг хардаг. Бошиглогчид *дуулгавартай байх зорилготойгоор* сонсдог хүмүүст ирэх агуу боломж, эрх мэдлийг урьдчилж хардаг. Энэ нь үнэн гэдгийг би мэднэ! Үүнийг би өөрөө ахин дахин мэдэрсэн билээ.

Их Эзэн бошиглогч биднийг төөрөгдүүлэхийг хэзээ ч зөвшөөрөхгүй гэдгийг амласан. Ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973): "Та нар Сүмийн эрх мэдэлтнээс ирж буй зүйлд дургүй байдаг байж магадгүй. Энэ нь та нарын улс төрийн үзэлтэй нийцэхгүй байж болно. Энэ нь та нарын нийгмийн талаарх үзэл бодолтой мөн нийгмийн амьдралтай зарим талаараа зөрчилдөж магадгүй. Гэхдээ та нар эдгээр зүйлийг Их Эзэний Өөрийнх нь амнаас гарсан хэмээн үзэж, тэвчээртэй, итгэлтэй сонсох аваас 'тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно' гэж амласан байдаг (С ба Г 21:6)" хэмээн хэлжээ.[2]

Гэвч та нар бошиглогч бол бошиглогч гэдгийг мэдэх юм бол Их Эзэнд даруухан, итгэлтэй ирж, бошиглогчийнх нь тунхагласан ямар ч зүйлийн талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй болохыг гуйж болно.

Та нар амьд бошиглогчийн хийж буй мэдэгдэл бүрийг үргэлж ойлгодоггүй байж болно. Гэхдээ та нар бошиглогчийг бошиглогч мөн гэдгийг мэдэх юм бол Их Эзэнд даруухан, итгэлтэй хандаж, Түүний бошиглогчийн тунхагласан юуны ч талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй болохыг гуйж болно.

МЭӨ 40 оны үед нифайчуудаас олон нь Сүмд нэгдэж мөн Сүм өсөж хөгжсөн. Гэвч нууц хуйвалдаанууд ч бас өсөж эхэлсэн бөгөөд тэдгээрийн зальт удирдагчид хүмүүсийн дунд нуугдаж, тэднийг илрүүлэхэд хэцүү болсон байлаа. Хүмүүс улам бүр бардам болохын хэрээр нифайчуудаас олон хүн "ариун нандиныг элэг доог болгосон, бошиглолын болон илчлэлтийн суу билгийг үгүйсгэсэн" (Хиламан 4:12) гэдэг.

Үүнтэй яг адилхан аюул занал эдүгээ бидэнд тулгараад байна. Нийгэмд "Сатаны зарц нар" (С ба Г 10:5) нуугдсан байдаг нь бодит ноцтой байдал юм. Тиймээс хэний зөвлөгөөг анхаарч байгаадаа сэрэмжтэй ханд (Хиламан 12:23-ыг үзнэ үү).

Миний хайрт ах, эгч нар аа, та бүхэн жинхэнэ мянган жилийнхэн болохоор төрсөн. Та нар бол "сонгогдсон үеийнхэн" (1 Петр 2:9) бөгөөд энэ дэлхийн хүмүүсийг Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх гайхалтай ажлыг хийж гүйцэтгэхээр Бурханы бүр урьдаас тодорхойлсон үеийнхэн билээ. ■

2016 оны 1-р сарын 10-нд Хавай дахь Бригам Янгийн Их Сургуульд болсон залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт дээр хэлсэн "Жинхэнэ мянган жилийнхэн болох нь" үгнээс авав. Бүрэн эхээр нь үзэх бол devotionals.lds.org хаягаар орно уу.

ЭШЛЭЛҮҮД

1. 1947 оны 2-р сард бошиглогч Иосеф Смитийн амийг хороосноос гурван жил орчмын дараа тэрээр ерөнхийлөгч Бригам Янгад үзэгдэж, дараах мэдэгдлийг өгчээ. "Хүмүүст даруу төлөв, итгэлтэй байж, үргэлж Их Эзэний Сүнстэй хамт бай гэж хэл. Учир нь Их Эзэний Сүнс тэднийг зөв зүйлийг хийхэд удирдах болно. Анхааралтай соргог байж, намуухан зөөлхөн дуу хоолойноос бүү эргэ; энэ нь [танд] юу хийхийг, хаашаа явахыг зааж өгөх болно" (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 98).
2. *Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* (2000), 84–85.

Зөөлөн гал дээр болгохын гайхамшиг

Дэвид А.Эдвардс
Сүмийн сэтгүүлүүд

Нэгэн залуу хөвгүүн гэртээ ганцаараа, өлсөөд байж байна гэж төсөөлөөд үзье (үнэмшмээргүй ч гэсэн төсөөлөх гэж оролдоод үз). Одоо харин энэ залуу хөвгүүн анх удаа шарсан талхтай бяслагтай сэндвич өөрөө хийж үзэхээр шийдэж байна гэж бод.[1] Тэр ч байтугай энэ залуугийн эцэг эх нь түүнд тийм бяслагтай сэндвич хэрхэн хийдгийг хэзээ ч зааж байгаагүй бөгөөд тэднийг хийж байхад нь ч гэсэн дөхөж очоод, харж байгаагүй гэж бодъё.

Энэ залуу талх, бяслаг, талхныхаа гадна бага зэрэг масло түрхсэн гээд (тэр ухаалаг залуу болохоор дотор талд нь бага зэрэг майонез түрхсэн байна) бүх орцоо зөв сонголоо гэж бодъё. Дараа нь тэр хайруулын таваг гаргаж ирээд, цахилгаан зуухан дээрээ тавилаа. (Түүнд энэ сэндвич хийх зориулалтын шарагч эсвэл хэрэгсэл байхгүй гэж төсөөлцгөөе.)

Одоо түүнд "Хэрэв би зуухныхаа галыг нэмэх юм бол хурдан болно доо" гэсэн маш олон хүнд хайхрамж болгоомжгүйн улмаас (эсвэл хэсэг зуур бодлогогүй байсан учраас) төрж байсан нэгэн бодол төрлөө гэж бодъё.

Дараа нь юу болохыг төсөөлөөд үз. (Эсвэл төсөөлөх шаардлагагүй ч байж магад.)

Тэр шаржигнасан, алтан шаргал өнгөтэй талх эсвэл яг сайхан, хайлан урсах бяслаг хоёрын аль нэгийг л хийж чадна. Хоёуланг нь нэгэн зэрэг ийм болгох боломжгүй. Ер нь бол тэр галт уулын чулуу шиг харагдаж, мэдрэгдэх (тийм ч амттай байх нь гарцаагүй) талх, хоёрын хооронд гүйцэд хайлаагүй бяслаг л идэх байх.

Та нарын бодож байгаачлан асуудал нь мэдлэггүй байдал (үүнийг зөвтгөж болно), тэвчээргүй зан (ойлгож болох ч зөвтгөхөд тийм ч амар биш) хоёр юм. Хэрэв тэр дараагийн удаа энэ алдаагаа давтвал яах аргагүй тэвчээргүй байдлаасаа болж хийсэн гэх тул мэдлэггүй байдлаасаа болсон гэж түүнийг зөвтгөх боломжгүй юм.

Үүнийг зөв хийж сурахын тулд тэр зөөлөн галаар болгохын гайхамшгийг олж мэдэх ёстой.

ЗӨӨЛӨН ГАЛААР ХООЛ ХИЙХ НЬ УЙТГАРТАЙ ЗҮЙЛ БИШ

Цахилгаан зуухан дээр зөөлөн галыг ашиглах нь хоолыг түлэхгүй гүйцэд болгодог учраас шарсан талхтай бяслагтай сэндвич болон өөр олон хоол хийхэд яг тохирно. Үүний ганц дутагдалтай тал нь илүү их хугацаа, анхаарал буюу *тэвчээр* шаарддагт оршино.

Их Эзэн "төгөлдөржих хүртлээ тэвчээрт үргэлжлүүл" (С ба Г 67:13) хэмээн айлджээ. Тэрээр энэ шүлэгт гайхалтай сайхан шарсан талхтай бяслагтай сэндвич хийхээс ч илүү том зүйл болох төгөлдөржих тухай ярьж байна. Тэр биднийг Өөртэй нь илүү адил болоосой хэмээн хүсдэг. Есүс Христ бол тэвчээрийн хамгийн гайхалтай жишээ мөн. Түүний жишээг дагана гэдэг нь алсын хараагаа тэлж, тухайн цаг үеийн зүйлийн цаадахыг харах болон хувийн сахилга бат, иттэл, дуулгавартай байдал, байнгын болон тууштай хүчин чармайлт, тэсвэр тэвчээр, хайраас ирдэг, өөрөөр хэлбэл тэвчээртэй байснаас ирдэг илүү агуу шагналыг харна гэсэн үг юм.

Тэвчээр нь уйтгартай сонсогдож болох хүлээх гэсэн санааг агуулдаг боловч Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф "Тэвчээртэй байх гэдэг нь идэвхтэй хүлээх, тэвчихийг хэлнэ. Энэ нь бид ямар нэг зүйлийг хүлээх үедээ ажиллах, итгэж найдах, итгэлээ ашиглаж, бэрхшээлийг сэтгэлийн тэнхээтэй давах, тэр ч бүү хэл зүрх сэтгэлийн хүслүүд маань хойш

ЭШЛЭЛҮҮД

1. Энэ залуу хөвгүүн америк хүн гэдэг нь ойлгомжтой. Тэр өөр газраас ирсэн бөгөөд анх удаа шарсан хоол, шарвин, төмсний шарвин, бөөрөнхий мах, блинчик, бин хийж эсвэл будаа агшаах гэж байж болно. Гол санаа нь ижил гэдгийг санаарай.
2. Дийтр Ф.Угдорф, "Тэвчээрээр үргэлжлүүл," *2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 68, 70.

ЗУРГИЙГ GILE68/ISTOCK/THINKSTOCK

тавигдсан ч чадах бүхнээ хийх хэрэгтэй гэсэн үг юм. Тэвчээр гэдэг бол зүгээр нэг тэсвэрлэхийг биш; харин онцгой сайнаар тэсвэрлэхийг хэлдэг юм" хэмээн тэвчээр гэдэг нь зүгээр хүлээхээс хавьгүй илүү зүйл гэдгийг заасан.[2]

Тэвчээр гэдэг нь шарсан талхтай бяслагтай сэндвичээ хайруулын тавган дээр тавиад мартах биш, харин үүнийгээ сайн харж, зөв үед нь эргүүлэхийг хэлж байгаа юм.

Энэ нь сургууль, семинар эсвэл сүмд явах төдий бус, харин идэвхтэй суралцаж, шүтэн бишрэхийг хэлж байгаа юм.

Энэ нь бас асуусан гэвэл Мормоны Номын гэрчлэл өөрт чинь ирэхийг хүлээж суух биш, харин үргэлжлүүлэн уншиж, судалж, тунгаан бодож, залбирч, уг номны зарчмуудын дагуу амьдрахыг хэлж байгаа юм.

Мөн энэ нь найзууд чинь шашин шүтлэгээр чинь доог тохуу хийхийг хараад зүгээр суух биш, харин зүрх сэтгэл нь өөрчлөгдөөсэй хэмээн залбирч, үнэхээр хүсэж, үүнийгээ биелүүлэхийн

Чи үүнийг яг одоо идмээр байна уу эсвэл зөв хугацаанд зөв болгож идмээр байна уу?

УРАГШ ТЭМҮҮЛ

"Их Эзэнийг хүлээх гэдэг нь итгэлийн үрийг суулгаад, түүний-гээ 'агуу шаргуу итгэл хийгээд . . . тэвчээрээр' арчлах гэсэн утгатай [Алма 32:41]. . . .

Их Эзэнийг хүлээх гэдэг нь 'тууштай зогсох' [Алма 45:17], 'найдварын төгс гэрэлтэйгээр,' итгэлдээ 'урагш тэмүүлэх' [2 Нифай 31:20]" гэсэн утгатай юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс, "Их Эзэнийг хүлээх нь: Таны хүсэл биелэг," *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 83-86.

ВИДЕО БИЧЛЭГ ҮЗЭХ

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф тэвчээр нь хөөсөн зөөлөн чихэртэй юугаараа холбоотой болохыг тайлбарласныг lds.org/go/101656 хаягаар орж үзнэ үү.

тулд чадах бүхнээ хийхийг хэлж байгаа юм.

Үнэндээ энэ нь болзох 16 насаа хүлээж суух биш, харин дуулгавартай байж сурах, бошиглогчдын зөвлөгөөг дагах нь өөрийг тань хэрхэн адислахыг ойлгохоор хичээхийг хэлж байгаа юм.

ГАЛАА БАГАСГА

Тэвчээр ба өөрийгөө захирах байдал буюу өөрийгөө хянах чадвар нь хоёулаа "Сүнсний үр жимс" (Галат 5:22–23-ыг үзнэ үү) юм. Хурдан түргэн үйлдэхийг эсвэл хариу үйлдэл хурдан үзүүлэхийг шаарддаг олон зүйл байдаг боловч (зарим хоолыг ширүүн гал дээр болгох хэрэгтэй байдгийн адил), та нар илүү их тэвчээртэй болж, өөрийгөө хянах чадвараа хөгжүүлэхээр хичээж ажиллах ёстой. Хэрэв та нар тэвчээртэй болж байгаагаа олж харвал энэ нь Сүнс та нар дээр ажиллаж байгаагийн шинж тэмдэг юм.

Зөөлөн галаар болгохын гайхамшиг танд төгс шарсан талхтай бяслагтай сэндвич, дотроо түүхий махгүй, хоккейн шайб шиг харагддаггүй гамбургер, түлэнхий хар биш харин сайхан шарсан төмсний шарвин, хатсан зажлууртай биш хөвсгөр зөөлөн будааг өгнө. Тэвчээр нь та нарын амьдралд "төгс үр дүнтэй" (Иаков 1:4) байх бөгөөд Есүс Христтэй илүү адил болохоор урагшлахад тань тусалж, Ариун Сүнсний нөлөөг авчирч, эцэст нь мөнх амьдрал руу алхахад тань тусална.

Та нар тэвчээрийг тань алдагдуулахад хүргэдэг зүйлсийг олж харах болгондоо энэ шарсан талхтай бяслагтай сэндвичний (эсвэл өөр ямар ч хоол байж болно) талаар мөн тэвчээргүй байдалд хөтлөгдсөнөөр юуг золиосолж байна вэ гэдгээ бодоорой. Хэрэв та нар тэвчээрээ ойр ойрхон алддаг бол бидэнтэй нэгд. Та нар наманчилж, Есүс Христийн үлгэр жишээ болон сургаалыг дахин дагах гэж хичээж болно. Цаашдаа шарсан талхтай бяслагтай сэндвич хийх тул тэвчээрээр дамжин ирдэг төгс байдлын талаар суралцахад хэзээ ч оройтохгүй билээ. ■

ХАМТДАА ЯРИЛЦ

НЯМ ГАРАГТ ТУНГААН БОДОХ ЗҮЙЛС

- Ямар бэрхшээл эсвэл өдөр тутмын нөхцөл байдал таныг тэвчээрээ алдахад хүргэдэг вэ?
- Та энэ бүх нөхцөл байдалд хэрхэн илүү тэвчээртэй байж чадах вэ?

ТАНЫ ХИЙЖ БОЛОХ ЗҮЙЛС

- Судруудын удирдамжинд тэвчээрийн талаар жагсааж бичсэн судруудыг судал.
- Гэр бүлтэйгээ эсвэл сүм дээр илүү тэвчээртэй болохын тулд хийж болох тодорхой зүйл дээр тавьсан зорилгуудаа ярилцаж болно.

ӨӨРСДИЙГӨӨ СЭРГЭЭН БОСГОГДОЖ БАЙГААГААР

ТӨСӨӨЛ

“Таны амьдрал эвдэрхий балгас дотор байгаа мэт санагдаж магадгүй. . . . Бидний хайрт Тэнгэрлэг Эцэг биднийг дахин босгож чадна. Биднийг байгаагаас маань илүү ихээр, төсөөлж чадахаас маань илүү агуу болгон босгох нь Түүний төлөвлөгөө юм.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган

СУМИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ © ART KONOVALOV, SHUTTERSTOCK.COM; OF DRESDEN © ARP/GETTY IMAGES-ИЙН ЗӨВШӨӨРӨӨР АШИГЛАВ; ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД СТОКЭР

ЦӨХРӨЛТГҮЙ ХҮЧ ЧА

Жессика Төрнэрийн түүхийг
Лин Крандаллд ярьснаар

Намайг 16 нас хүрэхээс нэг сарын өмнө гэр бүл маань Сүмийн түүхэн газруудыг үзэхээр Америкийн Нэгдсэн Улсыг хөндлөн гулд туулах аялалд гарсан юм. Гэр бүлээрээ цагийг зугаатай өнгөрөөдөг байсан учраас машинд удаан явах нь надад хэцүү санагддаг-гүй байв. Бид Небраскагийн Винтер Квартерст очсоныхоо маргааш машиндаа эргэж сууснаа санаж байна. Тэгэхэд бороо цутган орж байсан юм. Би арын суудал дээрээ суугаад, нэг хөнжил авч нөмрөн, бороо орж байгааг сонсонгоо унтахаар тухлав.

Үүний дараа би ямар ч хяналтгүй эргэлдэж байснаа л санаж байна. Манай машин гулгаж, гарцны доод талын цементэн хаалтыг мөргөсөн гэдгийг би дараа нь олж мэдсэн юм. Хэн нэгэн хүн миний хөлийг хугарсан, мэс засалд орохоор явж байна гэж хэлснийг би бүдэг бадаг санадаг.

Удсан ч үгүй, эмнэлэгт хэвтэж байхад аав маань өрөөнд орж ирэв. Тэр орон дээр, миний хажууд суугаад, гараас минь барилаа. Би яагаад ч юм бэ юу хэлэх гэж байгааг мэдэж байв.

Тэр "Охин минь, чи хаана байгаагаа мэдэж байна уу?" гэж асуулаа.

Намайг "эмнэлэгт" гэж хариулахад,

"Чи юу болсныг мэдэж байна уу?"

"Бид машины осолд орсон."

"Гэр бүлийн бусад гишүүний талаар хэн нэг нь чамд хэлсэн үү?" гэв.

Би түр чимээгүй болоод, үгүй гэж хариуллаа.

Миний ээжээс бусад бүх хүнийг зүгээр гэж тэр хэлэв. Тэр амьд гараагүй.

Би аймшигтай уй гашуу мэдрэх байх гэж бодсон ч тэгсэнгүй. Цочролд орсондоо ч тэр үү бүү мэд, би ямар ч байсан амар амгалан, бүх зүйл сайхан болно, Бурханд иттэж болно гэсэн мэдрэмжийг мэдрэв.

Эмнэлгийн орон дээр хэвтэж байхдаа би осол болохоос хоёр хоногийн өмнө Вайомингт Мартины агуй гэдэг Сүмийн түүхэн газар очсоноо саналаа. Олон анхдагч өлсгөлөн, цас, хүйтэнд нэрвэгдсэнээс болж амьсгал хураасан. Би булшнууд дээр овоолсон чулуур хараад, гар тэргээ аван, аяллаа цааш үргэлжлүүлэх нь амьд үлдсэн анхдагчдаас ямар их итгэл шаардсан бол гэж бодож байснаа санав. Энэ түүх надад хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн юм. Энэ туршлагын талаар эргээд бодоход, анхдагчид цөхрөлтгүй зүтгэсэн гэдгийг мөн би ч бас тэдний адил байж, дүү нарынхаа төлөө

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАЙКЛ МУЛЛАН

ЗҮТГЭХ ДАЛ

Эмтэрсэн зүрх, хугархай хөлтэй надад эдгээлт хэрэгтэй байсан юм. Найдвар надад хүч чадлыг өгсөн билээ.

сэтгэлийн тэнхээтэй байх хэрэгтэй гэдгээ мэдсэн билээ.

Анх мэдэрсэн амар амгалангийн мэдрэмж долоо хоног гаруй намайг орхисонгүй. Би 7-р сарын 4-нд тэргэнцэр дээр суун, эмнэлгийн цонхоор ёслолын буудлага харж байхдаа ээж минь байхгүй шүү дээ гэсэн бодол гэнэт толгойд минь орж ирэв. Тэр ахлах сургуулийн төгсөлтөн дээр минь байхгүй. Ариун сүмд хишиг хүртэх үед маань ч дэргэд минь байхгүй. Бас миний хуриман дээр ч байхгүй. Ээж маань хэзээ ч эргэж ирэхгүй.

Яг энэ үеэс эхлэн бүх зүйл маш хэцүү болж ирсэн юм. Хөл маань аймшигтай өвдөж, хоол идэх дуршил ч төрөхгүй байв. Би зурагт руу хий гөлрөн сууж, ихэвчлэн унтдаг байлаа. Би уйлах ч үгүй байсан болохоор гэр бүлийнхэн минь надад санаа зовох болов.

Биднийг Орегон дахь хоосон гэртээ эргэж ирсний дараа би заримдаа уйлдаг болсон юм. Ээжийнхээ зарим үүрэг хариуцлагыг өөр дээрээ үүрэх шаардлага гэнэт гарч ирсэн бөгөөд дүү нар минь тайтгарал хэрэгтэй үедээ намайг л гэдэг байлаа. Би тэдний төлөө сэтгэлийн тэнхээтэй байхыг хичээсэн. Гэхдээ энэ тийм ч амар зүйл байсангүй.

Сургуульдаа эргэж очих хүнд байв. Хүн бүр ослын талаар сонссон байсан бөгөөд сонсоогүй нэг нь багш нарыг намайг осолд орсон охин гэж танилцуулах үед энэ тухай мэддэг байлаа. Надад бусдаас тусгаарлагдсан мэт санагдаж байсан юм.

Ээжийг нас барснаас хойш есөн сарын дараа аав дахин гэрлэсэн нь хамгийн хэцүү зүйл байв. Хойд ээж минь гэр бүлд маань түшиг тулгуур болно, тэр бидэнд хэрэгтэй гэдгийг мэдэж байсан ч надад үүнийг хүлээн авахад хэцүү байлаа.

Гэхдээ энэ үеэр бүх зүйл харанхуй байсангүй. Би Тэнгэр дэх Эцэг, гэр бүл, Сүмийн удирдагчдаасаа асар их хайрыг мэдэрдэг байсан. Ослын дараа эдгэрч, цааш амьдрахад маань тусалсан зүйл бол итгэлийг маань хүчирхэгжүүлдэг энгийн зүйлүүдийг хийсэн явдал байсан юм. Өдөр бүр би орондоо орохын өмнө хувцасны шүүгээндээ ороод, судруудаа уншиж, залбиран, өдрийн тэмдэглэлээ хөтлөхөд нэг цагийг зарцуулдаг байв. Шүүгээнд ганцаараа байхдаа би дүү нарынхаа дэргэд байдгийн адил хүчтэй байх хэрэггүй байлаа. Би хүссэнээрээ уйлж, зүрх сэтгэлээ Бурханд уудлан гаргадаг байв. Би Түүнд яг юу мэдэрч байгаа, ээжийгээ хэр их санаж байгаагаа хэлдэг байсан юм. Би олон удаа нигүүлслийг мэдэрсэн учраас Тэр намайг сонссон гэдгийг мэднэ. Шүүгээ нь миний хувьд ариун нандин газар болж хувирсан билээ.

Эдгээр энгийн зүйлийг хийх нь надад Бурханаас хөндийрч, уурлаж хорсох биш, харин Бурхантай холбоотой хэвээр үлдэхэд тусалсан. Би Бурхан гэр бүлийг минь зовоох гэж уг ослыг бий болгосон гэж хардаггүй байлаа. Би тэвчээртэй байж, Түүний хүсэлд захирагдан, хүнд өдрүүдийг давах илүү их хүч чадалтай болсноо мэдэрдэг байсан юм. Гэхдээ үнэхээр *хэцүү* өдрүүд ч бас байсан.

Аавыгаа дахин гэрлэсний дараа би дүү нартаа сайн үлгэр жишээ үзүүлэхийг хичээсэн бөгөөд хойд ээжийнхээ талаар муу зүйл яасан ч байсан бодохыг хүсээгүй учраас Бурханд үргэлжлүүлэн найдсаар байв. Хувийн хөгжил дэвшил номон дээрх нэг үйл ажиллагаа нь хоёр долоо хоногийн турш гэр бүлийнхээ нэг гишүүнтэй харилцаагаа сайжруулах замаар гэр бүлийнхээ амьдралаа илүү сайжруулах тухай байсан юм. Ерөнхийдөө зорилго нь Христтэй адил байж, үйлдлээрээ хайраа харуулах ёстой байв. Би үүнийг туршиж үзэн, хойд ээждээ үйлчлэхээр шийдлээ.

Хоёр гэр бүл нийлсэн учраас маш их аяга таваг угаах хэрэг гардаг байв. Тэгээд би яг энэ зүйлээс чадсан. Би хоёр долоо хоногийн турш хойд ээждээ үйлчилснээр түүнийг хайрлаж, хэдийгээр дургүй байсан ч гэсэн тэвчээртэй байж чадсан юм. Түүнд үйлчлэхэд анхаарлаа төвлөрүүлсэн маань Сүнсийг надтай хамт байлгаж, хүнд хэцүү үеийг даван туулахад тусалсан билээ.

Энэ осол яагаад гэр бүлд минь тохиолдсон талаар би бүх зүйлийг өнөөг хүртэл ойлгоогүй бөгөөд одоо ч гэсэн хэцүү байх өдөр бий. Гэхдээ би анхдагчидтай адил итгэл найдвараа Бурханд тавьснаар цөхрөлтгүй зүтгэх хүч чадлыг хүлээж авсан юм. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЗҮРХ СЭТГЭЛЭЭ ДЭЭШ НЬ ӨРГӨ

"Таны амьдрал эвдэрхий балгас дотор байгаа мэт санагдаж магадгүй. . . . Та айж, уурлаж, гашуудаж эсвэл эргэлзээнээс болж тарчилдаг байж мэднэ. Гэхдээ Сайн Хоньчин хонио олдгийн адилаар та зүрх сэтгэлээ дэлхийн Аврагчид өргөх юм бол Тэр таныг олох болно.

Тэр таныг аврах болно.

Тэр таныг өргөж мөрөн дээрээ тавих болно.

Тэр таныг гэртээ аваачна."

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, "Тэр таныг мөрөн дээрээ тавиад, гэртээ авчрах болно," *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 91.



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
**ахлагч Д.Тодд
Кристоффэрсон**

ХЭРХЭН АВРАГЧИЙГ АМЬДРАЛЫНХАА ТӨВ БОЛГОХ ВЭ

Есүс бие, сүнс аль алинаар нь Өөрийгөө Эцэгийн хүсэлд захируулснаар Эцэгтэй төгс эв нэгдэлтэй болж чадсан. Есүс Эцэгийнхээ талаар "Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг" (Иохан 8:29) хэмээн хэлжээ. Есүс Эцэгийн хүслийн улмаас бүр үхэлд хүртэл үг дуугүй захирагдан, "Хүүгийн таалал Эцэгийн таалалд багтсан" (Мозая 15:7). Есүс Эцэгт бүх анхаарлаа төвлөрүүлдэг байсан нь Түүний тохинуулал тийм тод томруун, хүчтэй байсан үндсэн шалтгаануудын нэг юм. Түүнд анхаарлыг нь сарниулах хоёрдмол санаа гэж байгаагүй.

Та бид мөн ийм байдлаар **Христийг амьдралынхаа төвд тавьснаар** Тэрээр Эцэгтэй нэг байдгийн адил бид ч бас **Түүнтэй нэг болж** чадна (Иохан 17:20–23-ыг үзнэ үү). Бид Аврагчийг амьдралынхаа төвд тавихын тулд хийдэг бүх зүйлээ эргэн харж, дүгнэж цэгнэн, амьдралаа шинээр төлөвшүүлэхээр эхэлж болно. "Бид **Түүнийг үргэлж санах боломжийг олгодог юмсыг**—тэр дундаа байнга залбирах, судраас судлах, төлөөлөгчдийн сургаалыг нухацтай судлах, долоо хоног бүр ариун ёслолоос зөв зохистой хүртэх, ням гаргийн шүтэн бишрэх үйл ажиллагаануудад бэлдэх, жинхэнэ шавь байх талаар Сүнс болон туршлага юу зааж буйг тэмдэглэн авч санаж байх зэргийг эн тэргүүнд тавих ёстой. Бусад зүйл, ялангуяа амьдралын чинь тодорхой үед өөрт чинь шаардлагатай ямар нэг зүйл санаанд чинь орж ирж болно. Бид **амьдралаа Христ дээр төвлөрүүлэхийн тулд** дээрх асуудлуудад **зохих цаг хугацаа, хөрөнгө мөнгө** зарцуулан, хэрэв төвлөрүүлж чадсан бол дараа нь боловсрол, гэр бүлийн үүрэг хариуцлага, өөрийн сонирхдог зүйлс зэрэг үнэ цэнтэй **бусад үүрэг хариуцлагыг нэмж** болно. Ийм байдлаар бидний амьдрал дан ганц сайн гэсэн зүйлсээр биш, харин нэн чухал гэсэн зүйлсээр дүүрч, ач холбогдол багатай зүйлс хоёрдугаарт тавигдах буюу бидний амьдралаас бүрмөсөн алга болно.

Энэ нь амаргүй ч бид Их Эзэнд **итгэх итгэлээр байнга урагш тэмүүлж** чадна. Цаг хугацаа өнгөрөх тусам Аврагчийг үргэлж санаж, дагах гэсэн хүний хүсэл, чадвар өсөн нэмэгддэг гэдгийг би нотолж чадна. Бид энэ зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө тэвчээртэй **ажиллаж,** өөрсдөдөө хэрэгтэй байгаа ялган таних чадвар, бурханлаг тусламжийн төлөө **үргэлж залбирдаг** байх ёстой (2 Нифай 32:9-ийг үзнэ үү). ■

2009 оны 1-р сарын 27-нд болсон Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс авав.

ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БЭ?

Манай гэр бүл томоохон саад бэрхшээлтэй тулгарсан бөгөөд одоо гэрт минь санваартан байхгүй. Бэрхшээл биднийг өвдөг сөгдөн залбирахад тусалдаг. Надад судар байгаад мөн тэднийг өдөр бүр унших боломжтой байгаадаа би талархаж байна. Судрууд надад бусад хүний шийдвэр амьдралд минь нөлөөлж болох ч миний үнэ цэн агуу хэвээр гэдгийг заасан. Би өдөр шөнийн ямар ч үед Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьж болно гэдгийг мэддэгтээ маш их талархдаг. Энэ бол адислал.

Хэйли Д., нас 17, АНУ, Айдахо

Рөүзмэри Такэрэй

Би багадаа ээжийгээ гал тогоонд юм хийхийг хэдэн цагаар ч хамаагүй хардаг байж билээ. Ээж маань гэр бүлдээ зориулан хамгийн амттай хоол, талх, жигнэмэг, бялуу хийдэг байсан юм. Хэсэг хугацааны дараа би жор уншиж, зааврын дагуу хоол хийж эхэлсэн. Би ээждээ найдалгүй өөрөө хийж чаддаг болсон байв.

Хоол хийж сурахтай адил бид үйлдэл хийснээрээ сайн мэдээнээс суралцаж, гэрчлэлтэй болдог. Лихайг амьдралын модны тухай зүүдээ гэр бүлийнхэндээ ярьсны дараа Нифай "эдгээр зүйлсийг би өөрөө харж бас сонсож, түүнчлэн мэдэхийг хүсч байлаа" (1 Нифай 10:17) хэмээн хэлжээ. Өөрөөр хэлбэл, Нифайд аавынхаа гэрчлэлийг сонсох нь хангалттай байсангүй. Тэр аавынхаа аль хэдийн мэдэх зүйлийг олж мэдэхийг хүссэн байна.

Сайн мэдээнээс суралцах жор нь хэдхэн энгийн алхмаас бүрддэг. Та нар гэр бүлтэйгээ, сүм дээр эсвэл хувийн сургалтын үеэрээ сайн мэдээнээс суралцах үйл явцаа сайжруулахад тус болох дараах дөрвөн санааг хэрэгжүүлж болно.

1. Суралцахад бэлэн бай.

Хувийн сургалтаа залбирч эхлүүл. Уншиж байгаа зүйлээ ойлгоход тань туслахыг Тэнгэрлэг Эцэгээс хүс. Нэг юм уу хоёр асуулт бичиж аваад, хариултуудыг нь эрж хай. Та нарыг уншиж, тунгаан бодож, залбирах үед Ариун Сүнс үнэнийг гэрчлэх болно (Моронай 10:5-ыг үзнэ үү).

Сүм дээр сайн мэдээнээс суралцахад бэлтгэхийн тулд хичээлийнхээ материалыг урьдчилан унш. *Ирээд, Намайг дага* товхимлын хичээлүүдийг LDS.org вэбсайтаас болон Gospel Library программаас олж авч болно.

2. Суралцах үйл явцад оролц.

- Ойлгохын тулд унш. Уншиж байгаа зүйлээ ойлгох нь унших хуудасны тооноос эсвэл хэр хурдан уншихаас ч илүү чухал. Та нар зарим өгүүлбэрийг хэд хэдэн удаа унших хэрэгтэй байж болно. Мэдэхгүй үгсээ толь бичиг ашиглан хар. Жишээлбэл, *эрин үе* гэж юу гэсэн үг вэ? Та нар үүнийг олж мэдэхийн тулд Судруудын удирдамжийг ашиглаж болно.
- Уншиж буй зүйлийнхээ талаар асуу. Та нар магадгүй "Лихай гэр бүлтэйгээ Иерусалимаас явах үед тэнд юу болж байсан юм бол? Хүмүүс яагаад Лихайг сонсоогүй вэ?" гэж бодож байж болох юм.
- Сайн мэдээний ямар нэг сургаалын талаарх дараах гурван асуултад хариулахыг хичээгээрэй. Тухайлбал: Энэ нь яагаад тухайн үеийн хүмүүст чухал байсан бэ? Энэ нь өнөөдөр *бидэнд* ямар хамаатай вэ? Энэ нь *надад* ямар хамаатай вэ?
- Загвар, холбоосуудыг эрж хай. Жишээлбэл, Нифай бэрхшээлтэй тулгарахдаа ямар загварын дагуу хариулсан бэ? Аглаг буйд дахь түүний гэр бүлийн аялал Египетээс гарсан израильчуудын аялалтай юугаараа адил байна вэ?

СУРАЛЦАХ ЖОР

Бурханы үгийг бодгальд чинь илүү амттай болгох энэ дөрвөн арга замыг туршиж үзээрэй.



- Төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ тэмдэглэл дээрээ бич. “Таныг үнэ цэнтэй сэтгэгдлээ бичиж авах тусам тэдгээр нь илүү олноороо ирэхийг харах болно. Мөн та олж авах мэдлэгээ амьдралынхаа турш ашиглах боломжтой байх болно” (Ричард Г.Скотт, “To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Liahona,* 2002 оны 8-р сар, 12, 14). Ялангуяа төрсөн санаа бодол нь таны амьдралд ямар утга учиртай болохыг бич.
- Зураг зур. Суралцаж буй зүйлээ тэмдэглэх өөр нэг арга бол зураг зурах юм. Нэг удаа намайг найзынхаа гэр бүлийн үдэшт оролцохоор сууж байхад эмээ нь итгэл, залбирлын тухай хувийн түүхээ хуваалцсан. Хичээл эхлэхээс өмнө найз минь бага насны хүүхдүүддээ цаас, тосон харандаа өгсөн бөгөөд тэд эмээгээ ярьж байх хооронд түүхийг нь зурах ёстой байлаа. Зураг зурах нь тэдэнд анхаарлаа төвлөрүүлэхэд тусалсан бөгөөд зурж байх үедээ түүхийн зарим хэсгийг тодруулан асууж байв.

3. Өдөр бүр сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдар.

Суралцах үйл явц нь хичээл зүттэл шаарддаг учир бид ойлгохын тулд зүрх сэтгэлээ зориулах хэрэгтэй (Мозая 12:27-г үзнэ үү). Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Рассэлл М.Баллард бидэнд “өдөр бүр, хэдэн минут ч байсан хамаагүй судруудаас суралцах цаг гаргаж, тийм орчинг үүсгэ” хэмээн зөвлөсөн (“When Shall These Things Be?” *Ensign,* 1996 оны 12-р сар, 60). Бид тогтмол суралцвал сурахад илүү амар болдог. Жишээлбэл, Мормоны Номын Исаиагийн бүлгүүдийг үнэхээр уншсан (алгасалгүй) минь тэдгээрийг илүү ойлгомжтой болгож байгааг би анзаарсан.

Сайн мэдээнээс суралцах үйл явцад аливаа зүйлийг оюун ухаандаа мэддэг байх нь хангалттай биш. Бид суралцаж буй зүйлээ үйлдэл болгох хэрэгтэй. Бид үнэний дагуу үйлдэх үед Ариун Сүнс үүнийг бидэнд баталж өгдөг бөгөөд бидний гэрчлэл өсдөг. Бид энэ үнэний дагуу тууштай амьдарснаар өөрчлөгдөж, Есүс Христэд хөрвөгдөж эхэлдэг.

4. Ойлгож мэдэж авч байгаа зүйлээ хуваалц.

Сайн мэдээний зарчмыг өөрийнхөө үгээр бусдад ярих нь уг зарчмаа санаж, бидний гэрчлэлийг хүчирхэг болгодог Сүнсийг мэдрэхэд тусалдаг. Хуваалцах тохиромжтой цаг нь ихэвчлэн гэр бүлийн үдэш байдаг. Та нар түүнчлэн сургууль дээрх найзуудтайгаа болон оройн хоолны үеэр мөн гэр бүлийнхээ гишүүдтэй ярьж байхдаа хуваалцаж болно.

Бид энэ дөрвөн энгийн алхмыг дагаж, Аврагчийг таньж мэдэхийг тууштай эрэлхийлбэл “Бурханы нуц ууд нь [бидэнд] Ариун Сүнсний хүчээр задлагдах ажгуу” (1 Нифай 10:19) хэмээх амлалт биелэх болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

БИДЭНД ХЭРЭГТЭЙ ДӨРВӨН ЗҮЙЛ

“Та бидэнд гойд сайн судлах гарын авлага хэрэггүй мөн бид бусдын сүнслэг мэдлэгт хэт найдах ёсгүй. Бидэнд зөвхөн суралцах чин хүсэл, Ариун Сүнсний нөхөрлөл, ариун судрууд, идэвхтэй ба сониуч оюун ухаан л хэрэгтэй.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, “A Reservoir of Living Water” (Залуучуудад зориулсан СБС-ийн галын дэргэдэх цугларалт, 2007 оны 2-р сарын 4), 3, si.lds.org.

“Өөрийнхөө жишгийг хүчирхэгжүүлэхийн тулд өөр жишгийг дагадаг найзуудтай байх хэрэгтэй гэж зарим хүн хэлдэг. Энэ үнэн үү?”

Эцсийн эцэст, өөрийн жишгийг Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдарснаар хүчирхэгжүүлдэг учраас найзууд тань үүнийг хийхэд тусалж чадна эсвэл саад болно. Найз нөхөд бол та нарт бодож сэтгэх, хэлэх ярих, үйлдэх, тэр байтугай хэн болоход тань асар их нөлөөлдөг. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дээр “Өөрийн чинь эрхэмлэдэг үнэт зүйлсийг хуваалцдаг найз нөхдийг сонго. Ингэснээр та нар өндөр жишгүүдээр амьдрахад бие биенээ хүчирхэгжүүлэн, бие биедээ урам дэм хайрлах болно” ([2011], 16) гэсэн зөвлөгөө байдаг. Ийм найзууд Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдарч, жишгүүдээ хадгалж, илүү сайн хүн болоход тань тусална.

Гэхдээ та нартай уулзах бүх хүн өөртэй тань адил жишигтэй эсвэл Сүмийн гишүүд байдаггүй. Хүн бүртэй нөхөрсөг харьцаж, Аврагч тэдэнтэй яаж харьцах байсны адил хайр, сайхан сэтгэлээр хандах нь чухал. Та нар жишгүүдийнхээ дагуу үргэлжлүүлэн амьдарснаар “итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дуурайл болж” (1 Тимот 4:12) чадна. Таны үлгэр жишээнээс тэд өндөр жишгүүдийн дагуу амьдарснаар хэрхэн адислагдаж байгааг харах бөгөөд та нар тэднийг үүний адил үйлдэхэд урамшуулан дэмжиж чадна.

Найз нөхдөө сонгож, жишгүүдээ хүчирхэгжүүлэхийг хичээхдээ Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлж, Түүний өдөөлтийн дагуу үйлдэх зоригтой бай.

Жинхэнэ найзууд

Би дунд сургуульд орсон эхний жилдээ жишгүүдийг минь хүндлэх найз олж чадахгүй байх гэдэгт санаа зовж байсан юм. Удалгүй ангийнхаа нэг хүүхэдтэй сайн найз болж, өөрийгөө мормон гэдгийг хэлэв. Тэр энэ талаар надаас асуусан болохоор би түүнд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг өгсөн юм. Тэр өдрөөс эхлэн найз маань миний дэргэд хараалын үг хэлэхээ больсон. Найзууд чинь жинхэнэ найз л юм бол та нарын шийдвэрийг хүндэлж, жишгүүдээ хадгалахад тань туслах болно.

Кандэла М., 13 настай, Аргентин, Буэнос Айрэс

Жишгүүдээ өндөрт байлга

Өөр жишигтэй найзууд та нарын жишгийг тэр болгон хүчирхэгжүүлдэггүй ч та тэдний найз байснаар дагах сайн үлгэр жишээ үзүүлж чадна. Адил шүтлэг бишрэлтэй найзуудтай байх нь та нарыг жишгээ өндөр байлгахад урамшуулж, зөв зүйлийн төлөө зогсоход тань туслах болно.

Уоррэн С., 14 настай, АНУ, Орегон

Бошиглогчдын зөвлөгөөг дага

Хэрэв бид муу сонголт хийдэг эсвэл биднээр муу сонголт хийлгэхийг ороллдог найзуудтай уулздаг бол заримдаа уруу таталтыг эсэргүүцэхэд хэцүү болдог. Бошиглогчид *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дээр найз нөхөд “та нарын бодол санаа,

Эдгээр хариулт та нарт тусалж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

үйлдэлд их нөлөө үзүүлнэ. Тэр ч байтугай та нарыг ямар хүн болох вэ гэдгийг тодорхойлоход тусална" ([2011], 16) хэмээн хэлсэн. Бид жишгийг маань хүндэлдэг, тэр ч байтугай жишгээ сахихад маань анхаарал тавьдаг найзуудтай байх ёстой гэж би боддог.

Калвин В., 16 настай, АНУ, Аризона

Сайн найзууд бол адислал мөн

Хэрэв найз нөхөд тань өөр жишгээр амьдардаг бол өөрийнхөө жишгийг хүчирхэгжүүлэх нь илүү хэцүү байж болно. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг байнга уншсанаар намайг хүндэлдэг сайн найзыг сонгоход надад үргэлж тусалдаг. Би одоо номлолд үйлчлэхээр бэлтгэж байгаа бөгөөд надтай адил жишигтэй хүмүүсийн дунд байх нь сайн мэдээнд итгэлтэй хэвээр үлдэхэд маань тусалсан гэдгийг мэднэ.

Наэр М., 19 настай, Аргентин, Буэнос Айрэс

Төмөр бариулаас зууран барь

Сайн жишгийн дагуу амьдардаг найзуудтай болох нь таны хүсэж байгаа яг тэр зүйл мөн. Та өөрийгөө зарлигуудыг сахихад тусалдаг, зөв шударга амьдрахад урам зориг өгдөг найзуудаар хүрээлүүлэх хэрэгтэй. Агуу хийгээд нүсэр барилга руу биш, харин амьдралын мод руу аваачдаг төмөр бариулаас сайтар зууран барь. Өөрийгөө зөв шударга бус зүйлээр хүрээлүүлэх нь таныг уруу татагдахад хүргэх болно. Сайн мэдээний дагуу амьдрахад тань нөлөөлөх сайн найзуудтай бол.

Анни П., 13 настай, АНУ, Юта

Найз нөхөдтэй болохын төлөө залбир

Гэр бүл минь шинэ мужид нүүж ирсний дараа би сайн мэдээний тухай ярилцаж болох найзуудтай болохын төлөө залбирсан юм. Залбирч байхдаа би тайтгарлыг мэдэрсэн бөгөөд хэдэн сарын дараа хэд хэдэн гайхалтай сайн найзтай болсон билээ. Би тэдний дэмжлэгт найдаж болох байсан бөгөөд тэд сайн мэдээг илүү их хайрладаг болоход маань тусалсан. Найзууд чухал бөгөөд сайн мэдээний дагуу амьдрах үйл явцыг илүү амархан болгодог гэдгийг би мэднэ.

Сара П., 16 настай, Бразил, Рио де Жанейро

Жишгүүдээ сана

Та нарын жишгийг дагадаггүй найз нөхөд жишгийг тань сулруулж, үгүй хийж чадна. Би шинэ сургуульд орсныхоо дараа найз нөхөдтэй болохын тулд эргэн тойрныхоо хүмүүсийн хэлдэг зүйлийг хэлж үзсэн. Бусадтай адилхан болох гэж хичээж байхдаа өөрийнхөө зарим жишгийг мартах шахсан билээ. Жишгээ хүчирхэгжүүлэхийн тулд та нарт жишгийг тань дэмжиж, хуваалцдаг найзуудтай болох хэрэгтэй гэдгийг би ойлгосон. Надад жишгийг маань сануулдаг найзуудтай болсондоо би талархдаг.

Логан Ж., 15 настай, АНУ, Юта

САЙН НАЙЗ НӨХДИЙН НӨЛӨӨ

"Хүн бүрд сайн найз хэрэгтэй. Найз нөхөд тань та нарын бодол санаа, зан төлөвт ихээхэн нөлөөлдөг. Мөн үүний адил чи ч бас тэдэнд нөлөөлдөг. Та нар эрхэмлэдэг зүйлсээ найз нөхөдтэйгөө хуваалцах үедээ бие биенээ хүчирхэгжүүлэн, дэмжиж чадна. Хүн бүхэнтэй эелдэг, уриалгахан, хүндэтгэлтэй харьц. Найзууд нь Сүмийн үйл ажиллагаануудад урьснаар олон гишүүн бус хүн сүмд ирсэн байдаг."

Ерөнхийлөгч Томас С.Монсон, "That We May Touch Heaven," *Ensign*, 1990 оны 11-р сар, 46.

ДАРААГИЙН АСУУЛТ

"Залбирах, судар судлахаас гадна гэрчлэлээ хүчирхэгжүүлэх хамгийн шилдэг арга юу байж болох вэ?

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар эсвэл liahona@ldschurch.org руу э-мэйл хаягаар 2016 оны 11-р сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

(1) Овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт ба гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн, эсвэл 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичсэн зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах болно.

Загасч

Жюлиа Вентура
Бодит түүхээс сэдэвлэв

*“Энд дэлхий дээр надад гэр бүл бий. Тэд надад сайн ханддаг.” (*Children’s Songbook, *188).*

Гох, дэгээ, уургаа авцгаая. Загасчлах цаг ирлээ!” гэж аав хэлэв.

Хэйдэн эргэн тойрноо харангаа нүүр дүүрэн инээв. Бүх зүйл тод, гялалзаж байлаа. Нуур бүхэлдээ тэдний өмнө мэлтийн байв.

Хэйдэн аавыгаа дагаж алхаад, машины араас загасны хэрэгсэл хийдэг том хайрцгийг авч өргөв. Хүнд байсан ч тэр түүртсэнгүй. Тэр аавтайгаа загасчилж л байвал үүнээс хоёр дахин хүнд зүйлийг ч өргөж чадахаар байлаа.

Аавыг загасны уурганууудаа гаргаж ирэхэд тэд хоорондоо харшилдаж, чимээ гаргав. “Дэн унтаж байх шиг байна” гэж тэр хэллээ. “Чи түүнийг сэрээчих үү?”

Хэйдэн санаа алдах гэснээ болиод, “Мм, тэгье” гэв.

Тэр бяцхан дүү Дэнтэйгээ хамт ирснээ бараг мартах шахсан байлаа. Дэн үргэлж л тойрон гүйж, чанга ярьдаг байв. Тэр хамаг загас үргээчихнэ дээ!

Тэр нээлттэй цонхоор хараад, “Дэн, босох цаг боллоо” гэв.

Гэвч Дэн бөх гэгч унтсан хэвээр.

Хэйдэн түр азнав. Аз дайрч, Дэн загасчилж дуусах хүртэл унтчих юм биш биз.

Хэйдэн хайрцагтай хэрэгслээ аваад, эрэг дээр аавынхаа загасчилж байгаа газар руу чимээгүйхэн очлоо.

“Энд өгөөш, өт гээд бүх зүйл байна!”

Аав нь хайрцгийг түүнээс авлаа. “Сайн байна, баярлалаа.” Тэгээд аав нь өнгийж хараад, “Дүү чинь хаана байна?” гэв.

Хэйдэн машин руу харлаа. Гэв гэнэт тэр машин дотор ганцаараа сэрсэн бол *түүнд* ямар санагдах

байсныг бодож үзэв. Лав л сайхан санагдахгүй байсан гэж Хэйдэн бодлоо. Үнэндээ тэр нэлээд их айх байсан байх. Харин Дэн дөнгөж тавхан настай.

“Одоохон, аав аа. Би удахгүй эргээд ирнэ ээ” гэлээ. Харин түүнийг машин дээрээ иртэл Дэн байсангүй.

Хэйдэнд хорхой, шавжны дүнгэнэх чимээ хүртэл сонсогдохоо болив. Бүх зүйл нам гүм болох шиг санагдлаа.

“Дэн энд байхгүй байна” гэж Хэйдэн хашгирав.

Аав нь хурдан гэгч гүйж ирээд, машин дотор хайв.

“Тэр бид хоёрыг хайж байгаа байх” гэж аав нь хэлээд, “Тэр яваад минут л болж байна. Тэр холдоогүй байх” гэв.

Хэйдэн тайван байхыг хичээсэн ч гэдэс дотор нь эргэчих шиг боллоо. “Би залбирч болох уу?” гэхэд аав нь

“Наадах чинь маш зөв санаа гэж би бодож байна” гэлээ.

Хэйдэн бяцхан дүүтэй байгаадаа Тэнгэрлэг Эцэгт талархаад, Дэнийг айхаас нь өмнө хурдан олоход туслахыг гуйлаа.

Хэйдэн залбирч дуусахад түүний зүрх давчдахаа больсон байв.

Аав нь Хэйдэний мөрөн дээр гараа тавиад, “Чи Дэн байсан бол яах вэ? Чи хаашаа явах байсан бэ?” гэж асуув.

Машины нөгөө талын хаалга нээлттэй байгааг Хэйдэн анзаарчээ. Дэн тэр хоёрыг эрэг дээр байхыг хараагүй бололтой. Хэйдэн ойролцоо байх жим рүү заав. “Би тэр зүг рүү алхах байсан байх” гэж тэр хэллээ.

Тэд жим даган хурдан алхалж эхэллээ.

Хором бүр удаан, хүнд санагдаж байв. Хэйдэн алхах зуураа зүрх сэтгэлдээ залбирсаар л байв. Хэдэн алхам явсны дараа тэд мурийсан жимтэй тааралдаж, Дэн өмнө нь яваг харав.

“Дэн!” гэж Хэйдэн хашгирлаа.

Дэн эргэж хараад инээмсэглэх нь тэр. “Хөөе, та хоёр хаашаа явсан юм бэ?”

Цаг хугацаа хурдалж эхлэв. Хэйдэн Дэн рүү гүйж очоод, түүнийг чанга гэгч тэвэрлээ.

“Чамайг олсондоо би маш их баярлаж байна” гэж Хэйдэн хэлэв. Тэр дотроо хурдхан талархлын залбирал хэлжээ.

Дэн нүүр дүүрэн инээгээд, “Загас хаана байна вэ?” гэж асуув.

“Алив нааш ир, би чамд үзүүлье” гэж Хэйдэн хариуллаа. Нуур руу гүйнэ гэхээс хөлнийх нь ул загатнах аж. Тэр “Хэн нь түрүүлж загас барихаа үзье. Би дэгээнд өгөөшөө хийхэд чинь тусалъя” гэв. ■

Зохиогч нь АНУ-ын Жоржиад амьдардаг.

лахаар явсан нь

Хэйдэн загасанд явахыг тэсэн ядан хүлээж байлаа. Дэн хамт яваагүй байсан бол бүр сайхан байхсан. . . .

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын **ахлагч Гари Э.Стивэнсон**

Би гэр орноо амар тайван газар болгоход хэрхэн тусалж чадах вэ?



Бид гэр орноо ариун сүм шиг амар тайван, ариун газар болгож чадна.

Гэрээ цэвэрхэн, эмх цэгцтэй байлгахад тусал.

Есүсийн эсвэл ариун сүмийн зургийг гэртээ байрлуул.

Гэр бүлээрээ судалж, хамтдаа суралцаж болох өрөөнд судруудыг хадгал.

"Ариун өргөө, ариун сүм," 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, *101–103-аас авав.*

БИДНИЙ ХУУДАС

Гэр бүлтэйгээ хамт ариун сүм рүү явах гайхалтай сайхан байсан. Манай хотоос ариун сүм рүү явахад их хол, бараг 14 цаг явж хүрдэг. Бид ариун сүмийн ойролцоо нэг долоо хоног болсон юм. Би 12 нас хүрээд, өвөг дээдсийнхээ өмнөөс баптисмыг нь хийхийг тэсэн ядан хүлээж байна. Миний дуртай дуунуудын нэг бол "Би ариун сүм харах дуртай." Би ариун сүмд гэрлэж, мөнхийн гэр бүлтэй болохыг хүсдэг. Ариун сүм бол Их Эзэний өргөө гэдгийг би мэднэ.

Жюлиа К., 11 настай (зураг авахуулах үедээ), Бразил, Гоиас

Аллэн Э., 10 настай (зураг зурах үедээ), Эл Сальвадор, Сан Сальвадор

БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Би энэ зургийг зурж байхдаа, хэрэв би зарлигуудыг дагавал нэгэн өдөр аав, ээжтэйгээ адил ариун сүмд орж, лацдан холбогдож, өөрийн гэсэн мөнхийн гэр бүлтэй болж чадна гэж бодсон. Би гэр бүлдээ мөн Тэнгэрлэг Эцэгтээ хайртай.

Манолита Г., 8 настай (зураг зурах үедээ), Гватемала, Чималтенанго

Манай тойргийн ээлж болоход дүү бид хоёр Мексикийн Юкатан Меридад байдаг ариун сүм рүү явах дуртай байдаг. Бид цэцэрлэгт цагийг өнгөрөөж, ариун сүмд ирсэн бусад хүүхэдтэй тоглодог. Би хэзээ нэгэн өдөр ариун сүмд орохоор өөрийгөө бэлтгэж байгаа.

Марта С., 6 настай (зураг зурах үедээ), Мексик, Ютакан

Сайн уу, найзууд аа.

Намайг Стори гэдэг. Би Туркменистанд амьдардаг байсан. Энэ бол Төв Азид оршдог улс. Би унших, зурах, оёх дуртай. Би бас аавтайгаа хамт од харах дуртай. Манай гэр бүлийнхэн улсынхаа цорын ганц Сүмийн гишүүд байсан.

Сторигийн тухай түүх

Жилл Хакинг
Сүмийн сэтгүүлүүд

МИССИГИЙН ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН НЬ

Нэг өдөр хүчтэй шуурга болсны дараа миний найзын Мисси гэдэг муур алга болов. Бид хаа сайгүй хайсан боловч түүнийг олж чадсан-гүй. Бид залбирч болно гэж би хэлэв. Найзууд маань яаж залбирахаа сайн мэдэхгүй байсан болохоор би тэдэнд зааж өгөв. Бид бүгдээрээ өвдөг сөгдөөд, дотроо залбирсан. Тэгээд бид босоод, дахин хайж эхлэв. Нэг охин бидэн рүү гүйж ирээд, Миссиг олсон гэж хэллээ. Би сайн мэдээ-ний нэгээхэн хэсгээс ч гэсэн най-зуудтайгаа хуваалцсандаа баяртай байсан.

НЭГ НЭГНЭЭСЭЭ СУРАЛЦСАН НЬ

Миний эгч Сариа бид хоёр олон орны хүүхдүүдтэй хамт сурдаг. Бид нэг нэг-нэгээ их юм сурч, хөгжилдөх дуртай.

ГАР УРЛАЛ БА ХӨӨР БАЯСАЛ

Сариа бид хоёр хамт тоглохоор найзуу-даа урьсан юм. Бид зураг зурж, юм урлаж, салхинд гарав. Христийн мэндэлсний баярын үеэр бид хөрш найзуудтай-гаа жүжиг тоглосон.

ГЭРТЭЭ СҮМИЙН ЦУГЛААН ХИЙХ НЬ

Биднээс өөр Сүмийн гишүүд байхгүй болохоор бид Сүмийн цуглаанаа гэртээ хийдэг байв. Бид ариун ёслолын цуглаан хийж, дуулах, хуваалцах цаг гаргаж, Хүүхдийн хэсгийн хичээлд суу-даг байлаа. Дуулах цагаар би төгөлдөр хуур тоглодог байсан.



ХӨЛИЙНХӨӨ МӨРИЙГ БИДЭНД ИЛГЭЭ

Та нар нэр төрөө өндөрт өргөн авч явснаар Есүсийг хэрхэн дагадаг вэ? Хөлийнхөө мөрийг зураад, өөрийн түүх, зургийг эцэг эхийнхээ зөвшөөрлийн хамт бидэнд илгээгээрэй. Та бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар ("Submit Your Work" дээр дарж) эсвэл liahona@ldschurch.org гэсэн э-мэйл хаягаар илгээнэ үү.

Ээжээсээ сурсан

Далын ахлагч
Жайро Мазагарди

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙН МАТТ СМИТ

ЗҮЙЛ

Бага байхад мөнгөтэй болох бүрд ээж минь хамгийн бага үрчийсэн, цэвэрхэн дэвсгэртүүдийг аваад, бидний явдаг байсан сүмийн санваартанд өгдөг байсан юм. Тэрээр үүнийг бүх амьдралынхаа турш хийсэн. Тэр "Энэ бол Бурханы өмч" гэж хэлдэг байлаа. Тэр үг миний сэтгэлд хоногшиж үлдсэн юм. Ээж минь аравны нэгийн хуулийг дуулгавартай дагахыг надад заасан учраас насанд хүрсэн хойноо Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэж, аравны нэгээ төлөх нь надад хэцүү байсангүй.

Түүнчлэн ээж минь надад хэцүү зүйлийг хийх байсан ч үнэнч шударга байхыг заасан. Манай хөрш олон төрлийн жимс, ногоо тарьдаг байсан юм. Заримдаа жимс нь манай хашаа руу түрж орон ургадаг байлаа. Нэг удаа намайг хэдэн жимс түүгээд, ээждээ аваачиж өгөхөд тэр над руу хараад, "Энэ биднийх биш шүү дээ" гэв. Би ингэж хэлсэнд нь итгэж чадахгүй байлаа. Би "Юу гэсэн үг вэ? Манай хашаан дотор байна шүү дээ!" гэв. Тэр "Энэ биднийх биш ээ" гэж дахин хэллээ. Тэгээд тэр намайг гараас минь хөтлөөд, хөршийн гэр рүү явж билээ. Бид түүний жимсийг авсандаа уучлал гуйв. Ээж маань хэрэв бид ямар нэг зүйл авахыг хүсвэл шударгаар олж авах ёстой гэж хэлдэг байсан.

Та нарын эцэг, эх Сүмийн гишүүн биш эсвэл та нар тэдний сонголттой заримдаа санал нийлдэггүй байж болно. Тэгсэн хэдий ч та нар үнэнч шударга байдал, үүрэг хариуцлага, бие даах чадвар, шаргуу хөдөлмөрлөх зэрэг үнэн зарчмуудыг тэднээс сурах боломжтой. Эдгээр зарчим та нарын амьдралд агуу адислал байх болно. ■

ЭЦЭГ, ЭХЭЭСЭЭ АСУУ

Эцэг, эх байхын юу нь танд хамгийн их таалагддаг вэ?

Хамгийн хэцүү нь юу вэ?

Таныг юу аз жаргалтай болгодог вэ?

Таны өдөр бүр хийдэг хамгийн чухал зүйл юу вэ?

Сайн мэдээ танд сайн эцэг, эх байхад хэрхэн тусалдаг вэ?

Таны өдөр бүр хамгийн сүүлд хийдэг зүйл юу вэ?

Та нар өөр ямар асуулт тавьж болох вэ?

Нэг өдрийн турш ээж, аавынхаа туслагч нь байгаарай! Сурсан зүйлээ өдрийн тэмдэглэлдээ бичиж эсвэл зураарай. Эцэг, эхдээ хийдэг бүх зүйлийнх нь төлөө талархаарай.

Мормоны Номон дахь эмэгтэй баатрууд

Бидэнд сайн үлгэр жишээ болдог олон эмэгтэй Мормоны Номонд гардаг. Цуглуулгандаа нэмэх гурван баатрын карт энд байна. Бид бүгдийнх нь нэрийг мэдэхгүй ч гэсэн тэдний үлгэр жишээнээс сурал-цаж чадна. Та нар хэрхэн Мормоны Номын эдгээр эмэгтэй шиг байж чадах вэ?



Та нар тэдэн шиг өөр эмэгтэйг судруудаас олж чадах уу? Тэдэнд зориулан өөрийнхөө баатрын картыг хийгээд, зургаа бидэнд илгээгээрэй!

- 1 Нифай 7:19. Эдгээр эмэгтэй Нифайн талд зогсож, эр зоригоо харуулсан. Тэд хэн байсан бэ?
- 2 Нифай 5:6. Эдгээр эмэгтэй Бурханд итгэж, Нифайг дагаж аглаг буйд руу явсан. Тэд хэн байсан бэ?
- Алма 56:47-48. Эдгээр эмэгтэй хүүхдүүддээ Бурханы тухай заасан. Тэд хэн байсан бэ?

[Хариуцлага: Ийшэлийн эхнэр бөгөөн охид, Нифайн эгч нар, залуу дайчдын эхчүүд]

ЗУРАГ ЧИМЭГТЭЛИЙГ ЖАРЭД БЭКСТРАНД

Энэ даалгаврын хуудсыг хайчилж, нугалаад, хадгал.



Би гэрчлэлтэй болж чадна.

Сариа нөхөр Лихай нь Бурханы бошиглогч мөн гэсэн гэрчлэлтэй болсон. Та нар өөрийн гэсэн гэрчлэлтэй болж, гэрчлэлээ бусадтай хуваалцсанаар Сариатай адил болж чадна.

- ☐ 1 Нифай 5:7–8-ыг унш.
- ☐ Гэрчлэлээ бич эсвэл гэрчлэлээ найз-тайгаа эсвэл гэр бүлийнхээ гишүүнтэй хуваалц.
- ☐ Би өөртөө . . . даалгавар өгөв.

_____

Би итгэж чадна.

Лемонайн эхнэр Аммоныг Бурханы бошиглогч мөн гэдэгт итгэлтэй байсан. Та нар өнөөгийн бошиглогч, төлөөлөгчдөд итгэснээр Лемонайн эхнэртэй адил болж чадна.

- ☐ Алма 19:2–5, 8–10-ыг үзнэ үү.
- ☐ Ерөнхийлөгч Монсоны чуулган дээр хэлсэн үгийг үз. Тэр бол Бурханы бошиглогч гэдэгт та нар итгэдэг үү?
- ☐ Би өөртөө . . . даалгавар өгөв.

_____

Би үзэл бодлоо илэрхийлж чадна.

Мориантон ёс бус хүн байсан. Тэр шивэгчингүүдийнхээ нэгийг зодсон бөгөөд тэр эмэгтэй Мориантоны хийж байгаа зүйлүүдийг ахмад Моронайд хэлэхээр шийджээ. Та нар буруу зүйлийн талаар нуулгүй хэлснээр энэ шивэгчинтэй адил болж чадна!

- ☐ Алма 50:30–31-ийг унш.
- ☐ Хэрэв хэн нэгэн чамайг дээрэлхвэл эсвэл өөр хэн нэгнийг дээрэлхэж байгааг харвал энэ талаар итгэж явдаг насанд хүрсэн хүндээ хэлээрэй.
- ☐ Би өөртөө . . . даалгавар өгөв.

_____

Амлагдсан нутаг

руу аялсан нь

Жаред болон түүний ах гэр бүл, найзуудтайгаа нэгэн хөндийд амьдардаг байжээ. Есүс Христ Жаредын ах дээр айлчлан ирэв. Тэр түүнд хүмүүсээ амлагдсан нутагт аваачихын тулд далайг гатлах хөлгүүд хий гэж хэлжээ.

Түүний хүмүүс цонхгүй хөлгүүд хийсэн байв. Жаредын ах яаж амьсгалж, юм харах билээ гэж санаа зовж байлаа. Тэднийг хөлгүүддээ агаар оруулахын тулд нүх гаргах хэрэгтэй гэж Есүс хэлэв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭПРИЛ СТОТТ

Тэгвэл яаж гэрэлтэй болох вэ? Жаредын ах 16 тунгалаг чулуу гаргаж авав. Тэр Есүсээс чулуунуудад хүрч тэднийг гэрэлтдэг болгож өгөөч гэж хүссэн юм.

Есүс чулуу болгонд хуруугаараа хүрэхийг Жаредын ах харжээ. Чулуунууд хурцаар гэрэлтэж байв. Жаредын ах асар их итгэлтэй байсан учраас Есүс Христийг харсан байлаа!

Бурхан хөлгүүдийг далайг гатлахад туслахаар хүчит салхи илгээв. Жаредчууд амлагдсан нутагт ирснийхээ дараа өөрсдийг нь хамгаалсан Бурханд талархаж залбирсан юм.

Бид Бурханд найдаж, Есүс Христэд итгэлтэй байснаар Жаредын ахтай адил болж чадна. ■

Ифер 2–3; 6-аас авав.

Хөгжим намайг аз жаргалтай болгодог

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008)

ИХ ЭЗЭНИЙ СҮМИЙН ТЭНГЭРЛЭГ СУУ БИЛЭГ

Бурхан Өөрийнхөө сүр жавхлант загвараар хивсээ нэхдэг билээ.

Энэ ажлын зохион байгуулалт, удирдагчдын дуудлагын ард тэнгэрлэг суу билэг байгаа нь илэрхий юм. Ерөнхий эрх мэдэлтнүүд өөрсдийн гэсэн зан чанартай хувь хүмүүс. Хүн нэг бүр үүрэгт ажилдаа өөр өөрийн арвин туршлага, ур чадварыг авч ирдэг. Сүмийн удирдах зөвлөлд авч хэлэлцэх шаардлагатай асуудал гарч ирэхэд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ сонирхолтой үйл явцыг харж ажиглаж байдаг хүний хувьд Ариун Сүнсний хүч эдгээр эрэгтэйд хэрхэн нөлөөлж байгааг гэрчлэн харах нь гайхалтай байдаг. Эхэн үе дэх үзэл бодлын ялгаа хэдийгээр хурц биш ч гэлээ мэдэгдэхүйц зөөлрөн зөөлөрсөөр нэгдмэл байдалд ордог. Их Эзэн "Миний өргөө болбоос . . . дэг журмын өргөө мөн" (С ба Г 132:8-ыг үзнэ үү) хэмээн хэлсэн. Энэ үйл явц үнэн гэдгийг гэрчлэх болгонд миний итгэл шинэчлэгдэж байдаг гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу. . . .

Зарим хүн Сүмийн ерөнхийлөгч ямар ч нөхцөлд нэлээн өндөр настай

эрэгтэй хүн байдагт санаа зовж байдгаа хэлэхэд нь би "Ямар гайхалтай адислал вэ" гэж хариулдаг. Энэ эрин үеийн ажил хамгийн түрүүнд бошиглогч Иосеф Смитээр дамжуулан зохион байгуулагдсан билээ. Тухайн үед тэрээр залуу, эрч хүчтэйгээс гадна оюун санаа нь цаг үеийнхээ уламжлалд автаагүй нэгэн байсан юм. Их Эзэн ажлаа эхлүүлж байсан түүний залуу оюун ухааныг шинэ, нойтон шаврын адил дуртай хэвэндээ оруулах боломжтой байв.

Иосефын залгамжлагч асар олон хүнийг аглаг буйдаар удирдан явж, шинэ газар суурьших сүрдмээр том үүрэг хариуцлагыг нуруун дээрээ үүрэх үедээ бас л харьцангуй залуу байсан.

Гэхдээ одоо сургаалын маань үндсэн зарчмууд бэхжиж, Их Эзэн биднийг дахин нүүлгэхгүй л юм бол бид байр сууриа баттай сайн олсон байгаа билээ. Бидэнд шинэчлэлт хэрэггүй. Харин бид тэнгэрээс өгсөн зарчмуудыг дагаж мөрдөх хэрэгтэй. Бид Бурханаас томилогдсон удирдагчдадаа үнэнч байх хэрэгтэй. Тэр бол бидний бошиглогч, үзмэрч, илчлэгч. Хэрэв бид зохистой амьдарч чадвал үргэлж бошиглогчтой байх болно. Тэр залуу байх шаардлагагүй. Түүнд тохинууллын ажлыг дэлхий даяар аялан хийх шижигнэсэн залуучууд байсаар ирсэн, цаашид ч байх болно. Тэр бол тэргүүлэх дээд прист, ариун санваарын бүх түлхүүрийг тээгч, Бурханы илчлэлтийг хүмүүст нь дамжуулдаг дуу хоолой юм.

Эртний нэгэн зүйр үгэнд "Залуу насанд эрч хүч. Өтөл насанд мэргэн ухаан" гэсэн байдаг.

Ойрын ирээдүйд бид сахилга баттай, боловсролтой, шалгуурыг давсан, үйлчилж байхдаа ажил үйлсдээ үнэнч, үйл хэрэгтээ гуйвшгүй гэдгээ харуулсан, итгэл нь хөгжиж, олон жилийн туршид Бурхантай ойр байж харилцаагаа хөгжүүлсэн тийм нэгэн ерөнхийлөгчтэй байна гэж бодох нь надад асар их урам зориг хайрладаг. . . .

Бид илчлэгдсэн зарчмуудаа чандлан сахиж чадвал ирээдүйгээсээ айх хэрэггүй. ■

"He Slumbers Not, nor Sleeps," Ensign, *1983 оны 5-р сар, 5–8-аас авав. Цэг тэмдэг болон том үсэг хэрэглэх дүрмийн стандартын дагуу засварлав.*

ГЭРЭЛ ЗУРГИЙГ МЭРИ ОУЗОУНИАН, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

ОЙЛГОЛТ

Би үргэлжлүүлэн амьдрах зүрх зоригийг хаанаас олж авах вэ?

"Таны амьдрал эвдэрхий балгас дотор байгаа мэт санагдаж магадгүй. Та гэм нүгэл үйлдсэн байж болно. Та айж, уурлаж, гашуудаж эсвэл эргэлзээнээсээ болж тарчилдаг байж мэднэ. Гэхдээ Сайн Хоньчин хонио олдгийн адилаар та зүрх сэтгэлээ дэлхийн Аврагчид өргөх юм бол Тэр таныг олох болно. Тэр таныг аврах болно. Тэр таныг өргөж мөрөн дээрээ тавих болно. Тэр таныг гэртээ аваачна."

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, **ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф,** "Тэр таныг мөрөн дээрээ тавиад, гэртээ авчрах болно," *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 91.

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Жинхэнэ мянган жилийнхэн мэт зогс

Жинхэнэ мянган жилийнхэн гэдэг нь та нарын наснаас ч илүү чухал зүйл буюу дэлхийг Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд туслахыг хэлж байгаа юм.

46-р хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



ЦӨХРӨЛТГҮЙ ЗҮТГЭХ ХҮЧ ЧАДАЛ

58-р хуудас

Амьдралынхаа хамгийн хүнд хэцүү үед эдгээр энгийн зүйлийг хийсэн маань надад Бурханаас хөндийрч, уурлаж хорсох биш, харин Түүнтэй холбоотой хэвээр үлдэхэд тусалсан юм.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Ээжээсээ сурсан зүйл

72-р хуудас

Ээж, аавдаа эдгээр асуултыг тавьж, эцэг эх байхын юунд нь дуртай болохыг олж мэдээрэй.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN
4 021329 0363 9